




УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.5-д “Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, био бэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлнэ”, 3.4.2.3-д “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилго 7-д “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана”, Зорилт 7.3-т “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ”, 7.3.15-д Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ гэж;

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.2.6-д “Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирлын эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлнэ”, “3.3.4.19-д “Стратегийн хүнсний хангамж, нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ”, 3.3.4.34-д “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах

үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мянган тонн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ”, 4.4.4.6-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгсэл, агуулахын технологийг хөгжүүлж, гамшгийн үеийн болон стратегийн зориулалттай бараа материалын нөөц, хангамжийн хэмжээг нэмэгдүүлнэ”, 4.4.4.14-т “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна”, 4.4.5.1-т “Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон түүний дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно” гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 19-д “Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгасан нь хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцүүлэн Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах газраас олон улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хурлыг 2015 онд Япон улсын Сендай хотноо зохион байгуулж “Сендайн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан.

Сендайн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2017 онд дунд хугацааны стратегийг баталсан.

Сендайн үйл ажиллагааны 2015-2030 оны хөтөлбөрийн 19 (i)-дугаарт гамшиг эрсдлийг бууруулах, гамшгийн болон онцгой нөхцөл байдлын улмаас учирч болох хохирлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авах асуудал нь газар зүйн байрлал, дэд бүтэц, орон нутгийн иргэдийн гамшигт өртөх эмзэг байдал зэрэг гамшгийн эрсдэлийг ойлгон гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллахыг үйл ажиллагааны нэг зарчим болгон тодорхойлжээ.

Олон улсын уриалга, эрх зүйн бичиг баримтад дурдагдсан шаардлага, Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хүрээнд болон Улсын нөөцийн тухай хуульд заасан гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд аюултай цаг өрсөн хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад орон нутгийн нөөцийн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны менежментийг хөгжүүлэн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад Улсын нөөцийн тухай хуульд орох нэмэлт, өөрчлөлтүүдийн үзэл санаа оршиж байгаа болно.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Хүчин төгөлдөр үйлчилж буй Улсын нөөцийн тухай хуульд улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн нөөц гэж

4 ангилснаас батлан хамгаалах материаллаг нөөцийг Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулиар зохицуулж байна. Харин Улсын нөөцийн тухай хуулиар зохицуулж буй стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу захиран зарцуулах үйл ажиллагааны практик болон уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнээс дүгнэн үзвэл орон нутгийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагаа төдийлэн хангалттай түвшинд хүрэхгүй байна.

Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээг цаг алдалгүй хүргэх, орон нутгийн гамшгийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх нь нөөцийн удирдлагаас шууд хамааралтай. Иймд орон нутгийн онцлогт тохирсон нөөц бүрдүүлэлт, хадгалалтын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ бий болжээ.

Дэлхий дахинд геополитик, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж, тээвэр ложистик болон хангамжийн тасалдал нэмэгдэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, технологийн дэвшлээс үүдэлтэй гамшиг, осол болон халдварт өвчний эрсдэл улам бүр эрчимжиж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох байгалийн аюулт үзэгдлийн давтамж, хүч чадал нэмэгдэж, хүн, малын гоц халдварт өвчний эрсдэл эрчимжиж байна. Энэхүү нөхцөл байдал нь хүн амын амь нас, эд хөрөнгөд аюул учруулахаас гадна улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд үлэмж хэмжээний хохирол учруулж байна.

Тухайлбал, Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт үер, ган, зуд, хэт халалт, ой, хээрийн түймэр, гоц халдварт өвчний давтамж эрс нэмэгдлээ. Статистик мэдээллээр 2016 онтой харьцуулахад 2025 онд ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2.4 дахин өссөн. Сүүлийн 10 жилд (2016-2025 он) 45,446 удаагийн гамшиг, осол тохиолдож, үүний улмаас 4,338 хүний амь нас эрсдэж, 11.3 сая мал хорогдон, эдийн засагт 1.9 их наяд төгрөгийн шууд хохирол учирсан нь улсын нөөцийн бэлэн байдлыг шинэ шатанд гаргахыг шаардаж байна.

Практикт тулгарч буй хүндрэлийг арилгах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах, нөөцийн удирдлага болон хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодотгож, хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна. Үүнд:

1.Одоогийн хуулиар орон нутгийн нөөцийг бүрдүүлэх үүргийг Засаг дарга болон аж ахуйн нэгжүүд хүлээдэг ч практик дээр эдгээр нөөц нь Онцгой байдлын ерөнхий газрын бүртгэл, хяналтад байдаггүй. Энэ нь гамшгийн үед нөөцийн бэлэн байдлыг бодитоор үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Орон нутагт нөөцийг зөвхөн малын өвс, тэжээлийн хэмжээнд явцуу ойлгож бэлтгэдэг практик тогтсон. Гамшиг, онцгой нөхцөл байдал үүсэхэд хүн амд нэн шаардлагатай хүнс, ундны ус, эм, эмнэлгийн хэрэгслийг аймаг, сумын түвшинд нөөцлөх, тэдгээрийг хадгалах дэд бүтцийг (агуулах, программ хангамж) хөгжүүлэх шаардлагатай.

2.Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан нөөц нь цаасан дээр биш, бодит байдал дээр чанар, хүртээмжийн шаардлага хангаж буйг хянахын тулд улсын нөөцийн бараа материалын нэгдсэн мэдээллийн санг байгуулж, програм хангамжийн тусламжтайгаар эрсдэлийг удирдах хэрэгцээ үүссэн.

3.Нөөцийн бараа материалыг чанартай хадгалахын тулд технологийн дагуу сэлгэх үйл ажиллагаа тогтмол хийгдэх ёстой. Гэвч өнөөдөр үүнд зориулсан тусгайлсан зардал байхгүй, салбар нэгжүүд дотоод нөөц бололцоогоороо гүйцэтгэж байгаа нь хадгалалтын горим алдагдах эрсдэлийг дагуулж байна.

4.Гамшгийн голомтын бүсэд нэн шаардлагатай бараа материалыг улсын нөөцөөс гаргахад Засгийн газрын хуралдааны шийдвэрийг хүлээж цаг алдалгүйгээр, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай гаргаж, дараа нь Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлдэг уян хатан зохицуулалт үгүйлэгдэж байна.

5.Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн насжилт ихэссэн, дэд бүтэц муудсан нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад сөргөөр нөлөөлж байна. Иймд агуулахыг шинээр барих, өргөтгөх зардлыг улсын төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх эрх зүйн үндсийг бий болгох шаардлага бий болоод байна.

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд үндэслэн эрх зүйн зохицуулалтыг дараах чиглэлээр боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв. Үүнд:

1. Орон нутгийн нөөцийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхой болгох: Орон нутгийн нөөцөд бүрдүүлэх бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ тодорхойгүй, хариуцах байгууллага, албан тушаалтан болон хяналтын механизм нарийвчлагдаагүй нь хуулийн хэрэгжилтийг сулруулж байна. Гамшиг, аюулт үзэгдлийн үед нэн шаардлагатай тусламжийг шууд улсын нөөцөөс гаргадаг практик нь орон нутгийн түвшинд нөөц бүрдүүлэх хөшүүрэггүй болгож байгаа тул орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн тогтоох шаардлагатай. Эдгээр зохицуулалтыг шинэчлэн тогтоосноор орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт нь шат шатандаа тодорхой, хариуцлагатай, хяналттай болох бөгөөд улсын нөөцийн ачааллыг бууруулж, гамшгийн хариу арга хэмжээний шуурхай байдлыг хангах ач холбогдолтой.

2. Нөөцийн хэрэгцээг тодорхойлоход мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангах: Стратегийн болон гамшгийн нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоохдоо шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүй, эдийн засаг, санхүүгийн бодит тооцоолол дутагдаж байна. Иймд нөөцийн хэрэгцээг төлөвлөхдөө төсөв, санхүү, худалдаа, эдийн засгийн мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангах, эрсдэлийн удирдлагад суурилсан эрх зүйн үндсийг бий болгох нь зүйтэй байна.

3. Нөөцийн нэгдсэн мэдээллийн сан, цахим удирдлагыг нэвтрүүлэх: Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн нөөц бүрдүүлэх чиг үүргийн хэрэгжилт (Засаг дарга, албад, хуулийн этгээд) практикт бодитой байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна. Иймд улсын хэмжээнд нөөцийн бараа, материалын мэдээллийн санг үүсгэж, програм хангамжид суурилсан удирдлагын менежментийг нэвтрүүлснээр нөөцийн чанар, хүрэлцээнд бодит хяналт тавих боломж бүрдэж, шаардлагатай тусламж, нөөц бэлэн байгаа эсэхэд эргэлзээгүй дүн шинжилгээ хийх боломжтой болно.

4. Агуулахын дэд бүтэц, санхүүжилтийн механизмыг шинэчлэх: Нөөцийн агуулахын насжилт ихсэж, хадгалалтын горим болон хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүссэнийг шийдвэрлэхийн тулд дэд бүтцийн менежментийг шинэчлэн хуульчлах шаардлагатай. Агуулах шинээр барих, өргөтгөх, засвар үйлчилгээний зардлыг улсын төсвөөс гадна Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах, агуулах, барилга байгууламжид тавигдах шаардлагыг батлан мөрдүүлэх эрхийг эрх бүхий этгээдэд олгож, аюулгүй байдал, харуул хамгаалалтын журмыг хуульчлах, агуулах савыг түрээслэх замаар өөрийн орлого бүрдүүлэх эрх зүйн үндсийг нээх шаардлагатай байна. Эдгээр зохицуулалтыг нэвтрүүлснээр нөөцийн агуулахын дэд бүтэц зах

зээлийн зарчмаар шинэчлэгдэх нөхцөл бүрдэж, стратегийн бараа, бүтээгдэхүүний хадгалалтын аюулгүй байдал баталгаажих юм.

5. Бараа материалыг сэлгэх үйл ажиллагааг технологижуулах: Нөөцийн бараа материалыг сэлгэх ажиллагааг зөвхөн “байршил солих” эсвэл “биеийн хүчээр зөөх” төдийхнөөр хязгаарлаж буй өнөөгийн практик алдааг засаж, хадгалалтын чанарыг баталгаажуулах нийтлэг ойлголтын томъёолол, технологийн горимын зохицуулалт байхаар хуульчлах шаардлагатай. Сэлгэлтийг зөвхөн механик хөдөлгөөн бус, бараа материалын чанарыг хадгалахад чиглэсэн нарийвчилсан заавар, стандартын дагуу, мэргэжлийн хяналтын дор гүйцэтгэдэг тогтолцоонд шилжүүлснээр нөөцийн бараа материалын хадгалалтын хугацаа, чанар, аюулгүй байдалд тавих хяналт сайжирч, хадгалалтын явцад гардаг техникийн болон технологийн алдагдлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

6. Гамшгийн үеийн шийдвэр гаргах ажиллагааг шуурхай болгох: Гамшиг, ослын үед улсын нөөцөөс бараа гаргахад заавал Засгийн газрын шийдвэрийг хүлээдэг нь хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгахад цаг хугацаа алдах шалтгаан болж байна. Иймд онцгой нөхцөл байдлын үед нөөцийг шуурхай гаргаж, дараа нь Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлдэг механизмыг хуульд нэмж оруулснаар иргэдэд үзүүлэх тусламжийг шуурхай болгоно.

7. Хууль тогтоомжийн нийцэл, хэл зүйн найруулгыг сайжруулах: Улсын нөөцийн тухай хуулийг бусад салбарын хууль тогтоомжтой уялдуулан нийцүүлэх, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжгүй, зөрчилтэй зүйл, хэсэг, заалтыг засварлан, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байна.

Дүгнэж хэлбэл, Улсын нөөцийн тухай хуулийг зөвхөн ерөнхий чиг үүрэг заасан бус, шинжлэх ухааны тооцоололд суурилсан, эдийн засгийн үр ашигтай, гамшгийн үед шуурхай ажиллах чадвартай, төлөвлөлт, хадгалалт, сэлгэлт, санхүүжилт гэсэн бүх шатанд нарийвчилсан процесс, стандарт, хариуцлагыг тодорхой болгосон “Процессын хууль” болгон шинэчлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийн бэлэн байдлыг сайжруулах, улсын нөөцийн удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилттэй холбоотой практикт гарч буй бэрхшээл, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулахад чиглэнэ.

Төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг тусгалаа:

1. Орон нутгийн нөөцийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох талаар: “Орон нутгийн нөөц” болон “Агуулах”-ын нэр томъёог хуульчлан, орон нутгийн нөөцийг тухайн шатны гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувиар төсөвлөж бүрдүүлэхээр зохицуулсан. Улсын нөөцийн тухай хуулийн 3.1.10-т “Орон нутгийн нөөц”-ийг нэр, томъёогоор тодорхойлж, 13.1.11 болон 14.1.4-т орон нутгийн нөөцийн журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрхийг Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газарт олгохоор төсөлд тусгав. Мөн 16.1.1-т орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх заалтыг оруулав.

2. Төр, хувийн хэвшлийн түншлэл ба агуулахын ашиглалтыг сайжруулах талаар: Агуулах шинээр барих, өргөтгөх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх, түншлэгч нь нууцын болон аюулгүй байдлын шалгуур хангасан байх, мөн ашиглагдаагүй сул багтаамжийг стандартын дагуу түрээслүүлж, орлогыг төсөвт

төвлөрүүлэн цаашид засвар үйлчилгээнд зарцуулах механизмыг нээж өгөхөөр тусгав. Улсын нөөцийн тухай хуулийн 7.4-т агуулахыг түрээслүүлж болохыг, 10.2-т агуулахын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж, өргөтгөж болохыг тодорхой зааж өглөө.

3. Гамшгийн үеийн шуурхай удирдлага ба мэдээллийн сан үүсгэж, ашиглах талаар: Онцгой байдлын үед нэн түрүүнд шаардлагатай бараа, материалыг улсын нөөцөөс Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай гаргаж, Засгийн газарт танилцуулдаг уян хатан зохицуулалтыг оруулан Улсын нөөцийн тухай хуулийн 14.1.5-д “Гамшгийн онцгой нөхцөл байдалд... нөөцийг улсын нөөцөөс гаргаж, Засгийн газарт танилцуулах” гэж зааснаар гамшгийн үеийн шуурхай үйл ажиллагааны эрх зүйн боломжийг нээж өгөв. Улсын нөөцийн хөдөлгөөний мэдээллийг “Гамшгийн мэдээллийн сан”-д төвлөрүүлж, шинжлэх ухаан, эдийн засгийн тооцоололд үндэслэн бусад яамдтай хамтран төлөвлөх тогтолцоог бүрдүүлнэ. Улсын нөөцийн тухай хуулийн 14.2 болон 15.1.5-д улсын нөөцийн мэдээллийг “Гамшгийн мэдээллийн сан”-д бүртгэх, хөтлөх үүргийг тусгаж, 16.1.3-т орон нутгийн нөөцийн мэдээллийг цахим санд ажлын 3 өдрийн дотор бүртгэхийг үүрэг болгов. Улсын нөөцийн тухай хуулийн 15.1.6-д нөөцийн нэр төрөл, тоо хэмжээний саналыг боловсруулахдаа “холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” боловсруулахаар хуульчлав.

4. Гэрээт хадгалагчийн статус, үүргийн талаар: Нөөц хадгалах хувилбар буюу “гэрээт хадгалагч”-ийн эрх зүйн статусыг тодорхойлон баталгаажуулж, бараа материалыг “сэлгэх” нөөцийн чанарыг алдагдуулахгүй байх технологийн үйл ажиллагааг хуулийн нэр томьёонд нэмж тусгалаа.

5. Нэр томьёо, үйл ажиллагааны нарийвчлалын талаар: Хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор зарим нэр томьёог тодотгож, үйл ажиллагааны хүрээг тэлэхээр тусгав. Улсын нөөцийн тухай хуулийн 3.1.8-д нөөцийн анги, салбарын чиг үүрэгт “сэлгэлт”-ийг нэмж, хуулийн 1 дүгээр зүйл болон бусад заалтуудад “сэлгэх” гэдэг нэр томьёог системтэйгээр нэмж оруулав. Мөн “Төсвийн тухай”, “Гамшгаас хамгаалах тухай” хуулиудыг иш татан хоорондын уялдааг хангав.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Нийгмийн үр дагавар: Гамшиг тохиолдсон үед иргэдэд хүрэх хүнс, хоргодох байр, эм тарианы тусламж цаг алдалгүй, орон нутгийн түвшинд шуурхай хүрэх боломж бүрдэж, хүн амын амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах чадавх эрс дээшилнэ. Гамшигт өртсөн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ шуурхай болж, гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавх дээшилнэ.

Эдийн засгийн үр дагавар: Зарим төрлийн сул агуулахыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг ашигласнаар улсын төсвөөс агуулах барих, хадгалахад гарах зардлыг хэмнэнэ. Нөөцийн барааг хугацаа дуусахаас өмнө зөв горимоор сэлгэснээр үнэгүйдэх, устгалд орох эдийн засгийн алдагдлаас бүрэн сэргийлж, нөөцийн удирдлага сайжирснаар эрсдэл буурч, зардал хэмнэгдэнэ. Шинээр ажлын байр, салбар нэгж байгуулах шаардлагагүй тул төсөвт нэмэлт ачаалал ирэхгүй.

Хууль зүйн үр дагавар: Улсын нөөцийн тухай хууль нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуулиудтай бүрэн нийцэж, хяналтын систем цахимжиж, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоо, хэрэгжих механизм нь тодорхой болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр улсын нөөцийг бүрдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэх, орон нутгийн хариуцлагыг өндөрсгөх, гамшгийн үед цаг алдалгүй

хариу арга хэмжээ авах болон цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцнэ.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулна.

Цаашид шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байхгүй болно.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Улсын Их Хурлаас 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын нөөцийн тухай хуулийг баталж, 2007 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэнээс хойш 2014, 2015, 2016, 2017, 2022, 2023 онуудад бусад хуулийг батлахтай холбогдуулан түүнийг дагалдан гарах хуулиар нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Эдгээр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь Улсын нөөцийн тухай хуулийн зорилго, үзэл баримтлалд шууд хамааралгүй харин гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлж Улсын нөөцийн тухай хуулийн зарим хамааралтай зүйл, хэсэгт нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Улсын нөөцийн тухай хуульд заасан улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний аюулыг байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах зориулалт бүхий улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэх зэрэг хуулийн зорилтыг хангахтай холбоотой үндсэн харилцааг зохицуулсан шинжтэй нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан. Уг үндсэн чиглэлд нийт 147 хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор тусгасан ба Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэж УИХ-д өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэхээр тогтсон байна.

Иймд Улсын нөөцийн тухай хуулиар зохицуулж буй харилцааг тодотгох, зарим зүйл, хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах замаар уг хуулийн зорилтыг хангах, хэрэгжилтийг улам сайжруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Өөрөөр хэлбэл уг хуулийг хэрэгжүүлэх явцад практикт гарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд улсын нөөцийн үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараахь зохицуулалтыг энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг шинээр тодорхойлсон. Тухайлбал, Улсын нөөц хариуцсан нэгж нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, нэгдмэл, харилцан уялдаатай, шуурхай тасралтгүй байх, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тул уг зарчмыг тусгасан. Ингэснээр улсын нөөцийг бүрдүүлэх, салбар дундын

уялдаа холбоог хангаж, нэгдмэл байх, үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглах, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх боломж бүрдэх юм.

Улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл зарим хэсэгт оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учирсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед дотоодын хууль тогтоомжоос гадна Монгол Улсын олон улсын гэрээг дагаж мөрдөх зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг олон улсын эрх зүйн болон бусад баримт бичиг, стандартуудад нийцүүлэх, гамшгаас хамгаалах Үндэсний чадавхыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Түүнчлэн нөөцийн бараа, материалын аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгов.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй улсын нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, стандарт, хадгалалтын технологийн мөрдөлтөд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.” гэж заасан боловч “аюулгүй байдал”-ыг хангахыг хэрхэн ойлгох нь тодорхой бус байсныг хуулийн төсөлд тодотгож тусгалаа.

Мөн Улсын нөөцийн тухай хуульд заасан ангилалд үндэслэн, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс нөөцийн бараа, материалын нэгдсэн тоо бүртгэлийг улсын хэмжээнд хөтөлж байх эрх зүйн үндэслэлийг хуулийн төсөлд тусгалаа.

Улсын нөөцийн бараа, материалын хэрэгцээ, шаардлагыг тооцоолох болон хэвийн хорогдол, нөөцлөх хугацаа тооцох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор хуулийн төсөлд оруулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, хүн амыг хамгаалах үүднээс гамшиг, аюулт үзэгдлийн онцгой тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эхний ээлжинд нэн шаардлагатай нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс зарцуулах шийдвэрийг гаргаж, Засгийн газарт даруй танилцуулах үүргийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд тусгалаа.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ____ зүйлтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Улсын нөөцийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн тухай

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.5-д “Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, био бэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлнэ”, 3.4.2.3-д “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн **Зорилго 7-д** “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана”, **Зорилт 7.3-т** “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ”, 7.3.15-д Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ гэж;

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.2.6-д “Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирлын эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлнэ”, “3.3.4.19-д “Стратегийн хүнсний хангамж, нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ”, 3.3.4.34-д “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мянган тонн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ”, 4.4.4.6-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгсэл, агуулахын технологийг хөгжүүлж, гамшгийн үеийн болон стратегийн зориулалттай бараа материалын нөөц, хангамжийн хэмжээг нэмэгдүүлнэ”, 4.4.4.14-т “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна”, 4.4.5.1-т “Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон түүний дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад

эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно” гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 19-д “Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгасан нь хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцүүлэн Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах газраас олон улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хурлыг 2015 онд Япон улсын Сендай хотноо зохион байгуулж “Сендайн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан.

Сендайн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2017 онд дунд хугацааны стратегийг баталсан.

Сендайн үйл ажиллагааны 2015-2030 оны хөтөлбөрийн 19 (i)-дугаарт гамшиг эрсдлийг бууруулах, гамшгийн болон онцгой нөхцөл байдлын улмаас учирч болох хохирлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авах асуудал нь газар зүйн байрлал, дэд бүтэц, орон нутгийн иргэдийн гамшигт өртөх эмзэг байдал зэрэг гамшгийн эрсдэлийг ойлгон гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллахыг үйл ажиллагааны нэг зарчим болгон тодорхойлжээ.

Олон улсын уриалга, эрх зүйн бичиг баримтад дурдагдсан шаардлага, Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хүрээнд болон Улсын нөөцийн тухай хуульд заасан гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд аюултай цаг өрсөн хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад орон нутгийн нөөцийн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны менежментийг хөгжүүлэн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад Улсын нөөцийн тухай хуульд орох нэмэлт, өөрчлөлтүүдийн үзэл санаа оршиж байгаа болно.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Хүчин төгөлдөр үйлчилж буй Улсын нөөцийн тухай хуульд улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн нөөц гэж 4 ангилснаас батлан хамгаалах материаллаг нөөцийг Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулиар зохицуулж байна. Харин Улсын нөөцийн тухай хуулиар зохицуулж буй стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу захиран зарцуулах үйл ажиллагааны практик болон уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнээс дүгнэн үзвэл орон нутгийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагаа төдийлэн хангалттай түвшинд хүрэхгүй байна.

Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээг цаг алдалгүй хүргэх, орон нутгийн гамшгийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх нь нөөцийн удирдлагаас шууд хамааралтай. Иймд орон нутгийн онцлогт тохирсон нөөц бүрдүүлэлт, хадгалалтын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ бий болжээ.

Дэлхий дахинд геополитик, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж, тээвэр ложистик болон хангамжийн тасалдал нэмэгдэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, технологийн дэвшлээс үүдэлтэй гамшиг, осол болон халдварт өвчний эрсдэл улам бүр эрчимжиж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох байгалийн аюулт үзэгдлийн давтамж, хүч чадал нэмэгдэж, хүн, малын гоц халдварт өвчний эрсдэл эрчимжиж байна. Энэхүү нөхцөл байдал нь хүн амын амь нас, эд хөрөнгөд аюул учруулахаас гадна улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд үлэмж хэмжээний хохирол учруулж байна.

Тухайлбал, Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт үер, ган, зуд, хэт халалт, ой, хээрийн түймэр, гоц халдварт өвчний давтамж эрс нэмэгдлээ. Статистик мэдээллээр 2016 онтой харьцуулахад 2025 онд ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2.4 дахин өссөн. Сүүлийн 10 жилд (2016-2025 он) 45,446 удаагийн гамшиг, осол тохиолдож, үүний улмаас 4,338 хүний амь нас эрсдэж, 11.3 сая мал хорогдон, эдийн засагт 1.9 их наяд төгрөгийн шууд хохирол учирсан нь улсын нөөцийн бэлэн байдлыг шинэ шатанд гаргахыг шаардаж байна.

Практикт тулгарч буй хүндрэлийг арилгах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах, нөөцийн удирдлага болон хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодотгож, хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна. Үүнд:

1. Одоогийн хуулиар орон нутгийн нөөцийг бүрдүүлэх үүргийг Засаг дарга болон аж ахуйн нэгжүүд хүлээдэг ч практик дээр эдгээр нөөц нь Онцгой байдлын ерөнхий газрын бүртгэл, хяналтад байдаггүй. Энэ нь гамшгийн үед нөөцийн бэлэн байдлыг бодитоор үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Орон нутагт нөөцийг зөвхөн малын өвс, тэжээлийн хэмжээнд явцуу ойлгож бэлтгэдэг практик тогтсон. Гамшиг, онцгой нөхцөл байдал үүсэхэд хүн амд нэн шаардлагатай хүнс, ундны ус, эм, эмнэлгийн хэрэгслийг аймаг, сумын түвшинд нөөцлөх, тэдгээрийг хадгалах дэд бүтцийг (агуулах, программ хангамж) хөгжүүлэх шаардлагатай.
2. Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан нөөц нь цаасан дээр биш, бодит байдал дээр чанар, хүртээмжийн шаардлага хангаж буйг хянахын тулд улсын нөөцийн бараа материалын нэгдсэн мэдээллийн санг байгуулж, програм хангамжийн тусламжтайгаар эрсдэлийг удирдах хэрэгцээ үүссэн.
3. Нөөцийн бараа материалыг чанартай хадгалахын тулд технологийн дагуу сэлгэх үйл ажиллагаа тогтмол хийгдэх ёстой. Гэвч өнөөдөр үүнд зориулсан тусгайлсан зардал байхгүй, салбар нэгжүүд дотоод нөөц бололцоогоороо гүйцэтгэж байгаа нь хадгалалтын горим алдагдах эрсдэлийг дагуулж байна.
4. Гамшгийн голомтын бүсэд нэн шаардлагатай бараа материалыг улсын нөөцөөс гаргахад Засгийн газрын хуралдааны шийдвэрийг хүлээж цаг алдалгүйгээр, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай гаргаж, дараа нь Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлдэг уян хатан зохицуулалт үгүйлэгдэж байна.
5. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн насжилт ихэссэн, дэд бүтэц муудсан нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад сөргөөр нөлөөлж байна. Иймд агуулахыг шинээр барих, өргөтгөх зардлыг улсын төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх эрх зүйн үндсийг бий болгох шаардлага бий болоод байна.

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд үндэслэн эрх зүйн зохицуулалтыг дараах чиглэлээр боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв. Үүнд:

1. Орон нутгийн нөөцийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхой болгох: Орон нутгийн нөөцөд бүрдүүлэх бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ тодорхойгүй, хариуцах байгууллага, албан тушаалтан болон хяналтын механизм нарийвчлагдаагүй нь хуулийн хэрэгжилтийг сулруулж байна. Гамшиг, аюулт үзэгдлийн үед нэн шаардлагатай тусламжийг шууд улсын нөөцөөс гаргадаг практик нь орон нутгийн түвшинд нөөц бүрдүүлэх хөшүүрэггүй болгож байгаа тул орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн тогтоох шаардлагатай. Эдгээр зохицуулалтыг шинэчлэн тогтоосноор орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт нь шат шатандаа тодорхой, хариуцлагатай, хяналттай болох бөгөөд улсын нөөцийн ачааллыг бууруулж, гамшгийн хариу арга хэмжээний шуурхай байдлыг хангах ач холбогдолтой.

2. Нөөцийн хэрэгцээг тодорхойлоход мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангах: Стратегийн болон гамшгийн нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоохдоо шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүй, эдийн засаг, санхүүгийн бодит тооцоолол дутагдаж байна. Иймд нөөцийн хэрэгцээг төлөвлөхдөө төсөв, санхүү, худалдаа, эдийн засгийн мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангах, эрсдэлийн удирдлагад суурилсан эрх зүйн үндсийг бий болгох нь зүйтэй байна.

3. Нөөцийн нэгдсэн мэдээллийн сан, цахим удирдлагыг нэвтрүүлэх: Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн нөөц бүрдүүлэх чиг үүргийн хэрэгжилт (Засаг дарга, албад, хуулийн этгээд) практикт бодитой байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна. Иймд улсын хэмжээнд нөөцийн бараа, материалын мэдээллийн санг үүсгэж, програм хангамжид суурилсан удирдлагын менежментийг нэвтрүүлснээр нөөцийн чанар, хүрэлцээнд бодит хяналт тавих боломж бүрдэж, шаардлагатай тусламж, нөөц бэлэн байгаа эсэхэд эргэлзээгүй дүн шинжилгээ хийх боломжтой болно.

4. Агуулахын дэд бүтэц, санхүүжилтийн механизмыг шинэчлэх: Нөөцийн агуулахын насжилт ихсэж, хадгалалтын горим болон хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүссэнийг шийдвэрлэхийн тулд дэд бүтцийн менежментийг шинэчлэн хуульчлах шаардлагатай. Агуулах шинээр барих, өргөтгөх, засвар үйлчилгээний зардлыг улсын төсвөөс гадна Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах, агуулах, барилга байгууламжид тавигдах шаардлагыг батлан мөрдүүлэх эрхийг эрх бүхий этгээдэд олгож, аюулгүй байдал, харуул хамгаалалтын журмыг хуульчлах, агуулах савыг түрээслэх замаар өөрийн орлого бүрдүүлэх эрх зүйн үндсийг нээх шаардлагатай байна. Эдгээр зохицуулалтыг нэвтрүүлснээр нөөцийн агуулахын дэд бүтэц зах зээлийн зарчмаар шинэчлэгдэх нөхцөл бүрдэж, стратегийн бараа, бүтээгдэхүүний хадгалалтын аюулгүй байдал баталгаажих юм.

5. Бараа материалыг сэлгэх үйл ажиллагааг технологижуулах: Нөөцийн бараа материалыг сэлгэх ажиллагааг зөвхөн “байршил солих” эсвэл “биеийн хүчээр зөөх” төдийхнөөр хязгаарлаж буй өнөөгийн практик алдааг засаж, хадгалалтын чанарыг баталгаажуулах нийтлэг ойлголтын томъёолол, технологийн горимын зохицуулалт байхаар хуульчлах шаардлагатай. Сэлгэлтийг зөвхөн механик хөдөлгөөн бус, бараа материалын чанарыг хадгалахад чиглэсэн нарийвчилсан заавар, стандартын дагуу, мэргэжлийн хяналтын дор гүйцэтгэдэг тогтолцоонд шилжүүлснээр нөөцийн бараа материалын хадгалалтын хугацаа, чанар, аюулгүй

байдалд тавих хяналт сайжирч, хадгалалтын явцад гардаг техникийн болон технологийн алдагдлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

6. Гамшгийн үеийн шийдвэр гаргах ажиллагааг шуурхай болгох: Гамшиг, ослын үед улсын нөөцөөс бараа гаргахад заавал Засгийн газрын шийдвэрийг хүлээдэг нь хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгахад цаг хугацаа алдах шалтгаан болж байна. Иймд онцгой нөхцөл байдлын үед нөөцийг шуурхай гаргаж, дараа нь Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлдэг механизмыг хуульд нэмж оруулснаар иргэдэд үзүүлэх тусламжийг шуурхай болгоно.

7. Хууль тогтоомжийн нийцэл, хэл зүйн найруулгыг сайжруулах: Улсын нөөцийн тухай хуулийг бусад салбарын хууль тогтоомжтой уялдуулан нийцүүлэх, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжгүй, зөрчилтэй зүйл, хэсэг, заалтыг засварлан, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байна.

Дүгнэж хэлбэл, Улсын нөөцийн тухай хуулийг зөвхөн ерөнхий чиг үүрэг заасан бус, шинжлэх ухааны тооцоололд суурилсан, эдийн засгийн үр ашигтай, гамшгийн үед шуурхай ажиллах чадвартай, төлөвлөлт, хадгалалт, сэлгэлт, санхүүжилт гэсэн бүх шатанд нарийвчилсан процесс, стандарт, хариуцлагыг тодорхой болгосон “Процессын хууль” болгон шинэчлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

2.1. Зорилго, бүтэц

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийн бэлэн байдлыг сайжруулах, улсын нөөцийн удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилттэй холбоотой практикт гарч буй бэрхшээл, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулахад чиглэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Улсын нөөцийн тухай хууль нь 4 бүлэг, 19 зүйл, 31 хэсэг, 52 заалттай.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн бүтэц 7 зүйлтэй байх бөгөөд зарим хэсэг, заалтыг шинээр нэмэх, өөрчлөн найруулах, нэмэлт оруулах, өөрчлөх, хасах, хүчингүй болгох, хуулийг дагаж мөрдөх хугацаа гэсэн бүтэцтэй, 1 зүйл, 8 хэсэг, 24 заалт нийт 33 нэмэлт, өөрчлөлт орж байна. Үүнд:

- Шинээр нэмж орох – 1 зүйл, 3 хэсэг, 11 заалт;
- Өөрчлөн найруулах – 3 заалт;
- Нэмэлт орох – 2 хэсэг, 5 заалт;
- Өөрчлөх – 1 хэсэг, 5 заалт;
- Хасах - 1 хэсэг;
- Хүчингүй болгох – 1 хэсэг байна.

Ингэснээр хуулийн 32 хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нэмэлт, өөрчлөлтийн хэлбэрээр боловсруулах шаардлагыг хангаж байна.

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

2.2. Хуулийн төслийн гол агуулга

Төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг тусгалаа:

1. Орон нутгийн нөөцийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох талаар: “Орон нутгийн нөөц” болон “Агуулах”-ын нэр томъёог хуульчлан, орон нутгийн нөөцийг тухайн шатны гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувиар төсөвлөж бүрдүүлэхээр зохицуулсан. Улсын нөөцийн тухай хуулийн 3.1.10-т “Орон нутгийн нөөц”-ийг нэр, томъёогоор тодорхойлж, 13.1.11 болон 14.1.4-т орон нутгийн нөөцийн журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрхийг Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газарт олгохоор төсөлд тусгав. Мөн 16.1.1-т орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх заалтыг оруулав.

2. Төр, хувийн хэвшлийн түншлэл ба агуулахын ашиглалтыг сайжруулах талаар: Агуулах шинээр барих, өргөтгөх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх, түншлэгч нь нууцын болон аюулгүй байдлын шалгуур хангасан байх, мөн ашиглагдаагүй сул багтаамжийг стандартын дагуу түрээслүүлж, орлогыг төсөвт төвлөрүүлэн цаашид засвар үйлчилгээнд зарцуулах механизмыг нээж өгөхөөр тусгав. Улсын нөөцийн тухай хуулийн 7.4-т агуулахыг түрээслүүлж болохыг, 10.2-т агуулахын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж, өргөтгөж болохыг тодорхой зааж өглөө.

3. Гамшгийн үеийн шуурхай удирдлага ба мэдээллийн сан үүсгэж, ашиглах талаар: Онцгой байдлын үед нэн түрүүнд шаардлагатай бараа, материалыг улсын нөөцөөс Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай гаргаж, Засгийн газарт танилцуулдаг уян хатан зохицуулалтыг оруулан Улсын нөөцийн тухай хуулийн 14.1.5-д “Гамшгийн онцгой нөхцөл байдалд... нөөцийг улсын нөөцөөс гаргаж, Засгийн газарт танилцуулах” гэж зааснаар гамшгийн үеийн шуурхай үйл ажиллагааны эрх зүйн боломжийг нээж өгөв. Улсын нөөцийн хөдөлгөөний мэдээллийг “Гамшгийн мэдээллийн сан”-д төвлөрүүлж, шинжлэх ухаан, эдийн засгийн тооцоололд үндэслэн бусад яамдтай хамтран төлөвлөх тогтолцоог бүрдүүлнэ. Улсын нөөцийн тухай хуулийн 14.2 болон 15.1.5-д улсын нөөцийн мэдээллийг “Гамшгийн мэдээллийн сан”-д бүртгэх, хөтлөх үүргийг тусгаж, 16.1.3-т орон нутгийн нөөцийн мэдээллийг цахим санд ажлын 3 өдрийн дотор бүртгэхийг үүрэг болгов. Улсын нөөцийн тухай хуулийн 15.1.6-д нөөцийн нэр төрөл, тоо хэмжээний саналыг боловсруулахдаа “холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” боловсруулахаар хуульчлав.

4. Гэрээт хадгалагчийн статус, үүргийн талаар: Нөөц хадгалах хувилбар буюу “гэрээт хадгалагч”-ийн эрх зүйн статусыг тодорхойлон баталгаажуулж, бараа материалыг “сэлгэх” нөөцийн чанарыг алдагдуулахгүй байх технологийн үйл ажиллагааг хуулийн нэр томъёонд нэмж тусгалаа.

5. Нэр томъёо, үйл ажиллагааны нарийвчлалын талаар: Хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор зарим нэр томъёог тодотгож, үйл ажиллагааны хүрээг тэлэхээр тусгав. Улсын нөөцийн тухай хуулийн 3.1.8-д нөөцийн анги, салбарын чиг үүрэгт “сэлгэлт”-ийг нэмж, хуулийн 1 дүгээр зүйл болон бусад заалтуудад “сэлгэх” гэдэг нэр томъёог системтэйгээр нэмж оруулав. Мөн “Төсвийн тухай”, “Гамшгаас хамгаалах тухай” хуулиудыг иш татан хоорондын уялдааг хангав.

Гурав: Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Нийгмийн үр дагавар: Гамшиг тохиолдсон үед иргэдэд хүрэх хүнс, хоргодох байр, эм тарианы тусламж цаг алдалгүй, орон нутгийн түвшинд шуурхай хүрэх боломж бүрдэж, хүн амын амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах чадавх эрс

дээшилнэ. Гамшигт өртсөн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ шуурхай болж, гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавх дээшилнэ.

Эдийн засгийн үр дагавар: Зарим төрлийн сул агуулахыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг ашигласнаар улсын төсвөөс агуулах барих, хадгалахад гарах зардлыг хэмнэнэ. Нөөцийн барааг хугацаа дуусахаас өмнө зөв горимоор сэлгэснээр үнэгүйдэх, устгалд орох эдийн засгийн алдагдлаас бүрэн сэргийлж, нөөцийн удирдлага сайжирснаар эрсдэл буурч, зардал хэмнэгдэнэ. Шинээр ажлын байр, салбар нэгж байгуулах шаардлагагүй тул төсөвт нэмэлт ачаалал ирэхгүй.

Хууль зүйн үр дагавар: Улсын нөөцийн тухай хууль нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуулиудтай бүрэн нийцэж, хяналтын систем цахимжиж, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоо, хэрэгжих механизм нь тодорхой болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр улсын нөөцийг бүрдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэх, орон нутгийн хариуцлагыг өндөрсгөх, гамшгийн үед цаг алдалгүй хариу арга хэмжээ авах болон цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцнэ.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 13 дугаар зүйлд 13.1.30 дахь заалт *“Улсын нөөцийн тухай хуульд заасны дагуу улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх, сэлгэх зорилгоор борлуулсан борлуулалт болон тухайн зориулалтаар нөхөн бүрдүүлэхээр худалдан авсан бараа”-г* албан татвараас чөлөөлөхөөр тусгана. Цаашид шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын нөөцийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 3.1.10, 3.1.11 дэх заалт:

“3.1.10.“**орон нутгийн нөөц**” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар бүрдүүлсэн бараа, материалыг;

3.1.11.“**улсын нөөцийн агуулах**” гэж нөөцийн бараа, материал хадгалах зориулалтаар байгуулсан энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий барилга байгууламж, тусгайлан бэлтгэсэн талбайг. /цаашид “**агуулах**” гэх/.”

2/ 7 дугаар зүйлийн 7.4, 7.5 дахь хэсэг:

7.4. Улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийн ашиглагдаагүй байгаа багтаамжийг стандартын шаардлага хангасан бусад бараа, материалыг хадгалахад гэрээний үндсэн дээр түрээслүүлж болно.

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, улсын нөөцийн барилга байгууламжийн засвар үйлчилгээний зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

3/ 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, 10.2. дахь хэсэг:

“10.1.6.агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, агуулахын болон техникийн засвар үйлчилгээний зардал.

10.2.Агуулахын барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, агуулахын болон техникийн засвар үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхдээ өмчлөх эрхийг төрд үлдээх нөхцөлтэйгөөр гүйцэтгүүлж болох бөгөөд түншлэгч нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тогтоосон аюулгүй байдлын шалгуурыг хангасан байна.”

4/ 13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалт:

“13.1.11.орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журмыг батлах.”

5/ 14 дүгээр зүйлийн 14.1.4, 4.1.5 дахь заалт, 14.2 дахь хэсэг:

“14.1.4.орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журмын хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.5.гамшгийн онцгой нөхцөл байдал, голомтын бүсэд нэн түрүүнд шаардлагатай нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс гаргаж, Засгийн газарт танилцуулах;

14.2.Улсын нөөцийн мэдээллийг **гамшгийн мэдээллийн санд** бүртгэх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

6/ 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.6 дахь заалт:

“15.1.5.улсын нөөцийн мэдээллийг **гамшгийн мэдээллийн санд** бүртгэх, хөтлөх;

15.1.6.улсын нөөцөд бүрдүүлэх стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын талаарх саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах.”

7/ 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт:

“16.1.4.энэ хуулийн 3.1.10-т заасан бараа, материалыг гамшгийн үед зарцуулсан тохиолдолд борлуулалтын орлого болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөн бүрдүүлэх.”

8/ 17¹ дугаар зүйл:

“17¹ дугаар зүйл. Гэрээт хадгалагчийн үүрэг

17¹.1.Гэрээт хадгалагч дараах үүрэг хүлээнэ:

17¹.1.1.нөөцийн бараа, материалыг батлагдсан нэр төрөл, тоо хэмжээний дагуу зориулалтын агуулахад технологийн заавар, стандартын горимыг баримтлан чанар, бүрэн бүтэн байдлыг нь ханган хадгалах, хамгаалах;

17¹.1.2.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг зориулалтын цэгт тээвэрлэн хүргэх;

17¹.1.3.нөөцийн бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдэл, гүйцэтгэлийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

17¹.1.4.нөөцийн бараа, материалын хадгалалтын явцад жилд нэгээс доошгүй удаа чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг гаргуулж, холбогдох арга хэмжээ авах.

17¹.2.Гэрээт хадгалагчаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 26.1-д заасан шалгалтад хамрагдсан, уг хуулийн 32 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдийг сонгон шалгаруулна.”

2 дугаар зүйл.Улсын нөөцийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8.“**Улсын нөөцийн анги, салбар**” гэж Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээний дагуу нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, тэдгээрийн хадгалалт, сэлгэлт, шинэчлэлт болон багцлалт, *тээвэр, хангамжийн зохион байгуулалт, зарцуулалтыг* хариуцан гүйцэтгэгч Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг;”

2/ 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3 дахь заалт:

“16.1.1.орон нутгийн нөөцийг *тухайн шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах санд жил бүр тодорхой хувийг тусгах замаар* бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;

16.1.3.орон нутгийн нөөцийн мэдээллийг улирал тутам шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүрт ажлын 3 өдрийн дотор **гамшгийн мэдээллийн санд** бүртгүүлэх, хяналт тавих;”

3 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “шинэчлэх,” гэсний дараа “сэлгэх,” гэж, 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.2, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 17 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “нөөцийн” гэсний дараа “анги,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “хадгалах,” гэсний дараа “сэлгэх, шинэчлэх, аюулгүй байдлыг хангах,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3 дахь заалтын “тоо” гэсний дараа “хэмжээ, гэрээт хадгалагчид хадгалах тоо,” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын “бүрдүүлэх” гэсний дараа “, агуулахын барилга байгууламжийг түншлэлээр хэрэгжүүлэх төслийн” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн” гэснийг “Олон улсын гэрээ, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төсвийн” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.9, 10 дугаар зүйлийн 10.1.5, 13 дугаар зүйлийн 13.1.10, 14 дүгээр зүйлийн 14.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтын “.” гэснийг “;” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 4.2, 4.3-т зааснаас бусад” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

*Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар*

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.3.15-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадварыг бэхжүүлнэ.”, “Онцгой байдлын ерөнхий газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний Зорилт 12-д “Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх”, 12.1-д “Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах /холбогдох судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийнэ/, Зорилт 15-д “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээллийн технологи, цахим үйлчилгээг нэвтрүүлэх”, 15.1-д “ОБЕГ-ын бүтцэд цахим мэдээллийн технологийн нэгж шинээр байгуулах” 15.3-д Байгууллагын нэгдсэн мэдээллийн систем, гамшгийн болон бусад мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх”- гэж заасан.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын² /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 2.1-д “Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”, 3.1-д “Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ”, 4.1.7. “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг; 42.1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

² Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.” гэсэн зохицуулалт хангагдаж хуулийн хэрэгжилт сайжирна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Гамшгаас хамгаалах тухай хууль болон Улсын нөөцийн тухай хуулийн уялдаа холбоо сайжирч, хуулийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаа, арга зам тодорхой болж Онцгой байдлын ерөнхий газар /Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар цаашид “ОБЕГ”, “УНХТГ” гэх/-ын улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, сэлгэх, аюулгүй байдлыг хангах, захиран зарцуулах, санхүүжүүлэх үйл ажиллагаа болон бусад чиг үүргийн хэрэгжилт сайжирна. Тухайлбал:

1. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэхээр зохицуулна.
2. Хуулийн зорилт болон холбогдох бусад зүйл, хэсэгт улсын нөөцийн бараа, материалыг “сэлгэх”, “аюулгүй байдлыг хангах” талаар тусгана.
3. Үйл ажиллагааны зарчмыг “хууль дээдлэх, нэгдмэл харилцан уялдаатай, шуурхай, тасралтгүй байх, шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологи, мэдээллийн сүлжээг ашиглах” гэж тодорхойлно.
4. Улсын нөөцийн бараа, материалын бүртгэл, судалгааг үнэн зөв хөтлөх, мэдээ, тайланг шуурхай гаргах, УНХТГ-ын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн нэгдсэн санг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэн “нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх журам, аргачлал, маягтыг Засгийн газар батлах” зохицуулалтыг тусгана.
5. Улсын нөөцийн тухай хуульд орон нутгийн нөөцийг улсын нөөцийн нэг ангилалд хамруулж, уг нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн батлах эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх болгон заасан. ОБЕГ-т орон нутгийн нөөцийн асуудлыг мэргэжлийн удирдлагаар хангах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг эрх хэмжээ хуульд байхгүй байгаа нь орон нутгийн нөөцийн талаарх хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн гол шалтгаан болж байна. Иймд хуульд “орон нутгийн нөөцөд хамаарах бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, захиран зарцуулах журам, жагсаалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батлах”, зохих “хуулийн этгээд нь нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх үүрэг хүлээх” зохицуулалтыг бий болгоно.
6. Улсын нөөцийн бараа, материалын чанар аюулгүй байдлыг хангах, хадгалалтын хугацааг уртасгах судалгаа хийх, үр дүнг практикт нэвтрүүлэх, чанарын болон судалгааны лабораторийг байгуулах, түүний үйл ажиллагааны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор “Улсын нөөц хариуцсан албаны тогтолцоог Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтоох”, “Улсын нөөц хариуцсан албаны дэргэд нөөцийн бараа, материалын чанар стандартыг судлан тогтоох лаборатори

болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн нэгжтэй байж болох” зохицуулалтыг тусгана.

7. Стратегийн нөөцийн нэр төрлийг тогтоох эрхийг УИХ-д, гамшгийн нөөцийн нэр төрлийг тогтоох эрхийг Засгийн газарт, орон нутгийн нөөцийн нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн тогтоох эрхийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн /Монгол Улсын Шадар сайд/-д тус тус олгосон. Гэвч хуулиар олгогдсон эрх ямар арга замаар хэрэгжих нь тодорхойгүй, нарийвчлан зохицуулаагүйгээс практик дээр ОБЕГ /бүтцийн нэгж УНХТГ-аар дамжуулан/ улсын нөөцийн бараа, материалын нэр төрлийн санал /жагсаалт/-ыг гаргаж, шийдвэр гаргах эрх бүхий субъектэд өгөх үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Иймд нөөцийн бараа, материалын хэрэгцээ шаардлага нэр төрөл, тоо хэмжээ, байршлын талаар тооцоо судалгаа хийх, албажуулах үйл ажиллагааг хариуцах этгээд, түүний процессыг хуульчлан тогтоох нь хуульд нийцнэ. ОБЕГ нь ийнхүү нөөцийн бараа, материалын нэр төрлийн санал /жагсаалт/-ыг гаргахдаа хуульчилсан дүрэм, журам, аргачлалгүй түүнчлэн эдийн засгийн мэргэжлийн байгууллагын хамтын оролцоогүй ажиллаж байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах боломжийг хязгаарлаж байгаа тул “нийгэм-эдийн засгийн байдал, газар зүйн онцлог, хүн амын нягтрал, хотжилт, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээ болон бусад нөхцөл байдлыг харгалзан улсын нөөцийн бараа, материалын жагсаалтыг тогтоох, бүрдүүлэх, гаргах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох, нөөцлөх хугацаа тооцох аргачилсан зааврыг батлах” эрхийг Засгийн газарт олгосон зохицуулалтыг бий болгоно.
8. ОБЕГ нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээд биш тул хадгалагдаж буй бараа, материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулахад НӨАТ үнийн дүнг хасаж тооцдог. Практикт нөөцийн бараа, материалыг НӨАТ-тэй үнээр бүрдүүлээд, түүнийг шинэчлэх буюу борлуулахдаа /НӨАТ-гүй үнээр/ худалдаж орлогоор нь нөхөн бүрдүүлэлтийг хийж байна. Энэ нь нөхөн бүрдүүлэлтээр тухайн нэр төрлийн барааны тоо, хэмжээ багасах гол хүчин зүйл болж байна. Ялангуяа үнэ ихтэй бараа, материал дээр их хэмжээний зөрүү гарах, төсвийн хөрөнгө алдагдал хүлээх нэг шалтгаан нөхцөл нь болж байгаа тул “Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, шинэчлэхэд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.11-т заасан албан татвараас чөлөөлөхөд мөрдөх журмыг баримтлах” зохицуулалтыг тусгана.
9. Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр улсын нөөцийн бараа, материалыг гаргах /зарцуулах/-аар хууль болон журамд тодорхой заасан. Харин яаралтай, хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд улсын нөөцөөс бараа, материалыг хэрхэн яаж гаргах /зарцуулах/-тай холбоотой зохицуулалт Улсын нөөцийн тухай хууль болон холбогдох журамд байхгүй байна. Практикт гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед улсын нөөцөөс бараа материалыг гаргах /зарцуулах/ шийдвэрийг яаралтай гаргах, богино хугацаанд гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага цөөнгүй тохиолддог бөгөөд ийм үед эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүргийн хүрээнд улсын нөөцийн бараа, материалыг гарган Засгийн газрын шийдвэрийг нөхөж албажуулж байна. Практикт цөөнгүй тохиолддог энэ үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн зорилгыг хангаж байгаа боловч Улсын нөөцийн тухай хуулийг зөрчсөн үйлдэл болно. Иймд Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийн бүрэн эрхэд “гамшиг, аюулт үзэгдлийн онцгой тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эхний ээлжинд нэн

шаардлагатай нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс зарцуулах шийдвэр гаргаж, Засгийн газарт даруй танилцуулах” зохицуулалтыг бий болгоно.

10. Мөн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор техникийн болон нэр томьёо, найруулгын шинжтэй зохих өөрчлөлтүүдийг хийхээр хуулийн төслийг боловсруулна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Иргэн, хуулийн этгээдийн хувьд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхгүй бөгөөд холбогдох өөрчлөлтийг оруулж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор улсын нөөцийн тухай хуулиар зохицуулж буй харилцаа ойлгомжтой, тодорхой болохын зэрэгцээ ОБЕГ /УНХТГ/-ын үйл ажиллагаа сайжирч, хүний нөөцийн чадавх, удирдлага, зохион байгуулалт, алба хаагчийн эрх зүйн байдал эрс дээшилж бодитой үр дүнд хүрнэ.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн бүрдэл, зорилтыг бүрэн тодорхойлох, Гамшгаас хамгаалах тухай хуулийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн хамрах хүрээ зохицуулах харилцаа, арга зам, нэр томьёо, зарчмыг тодорхой болгох, нөөцийн бараа, материалын жагсаалт гаргах, бүрдүүлэх, гаргах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох, нөөцлөх хугацаа тооцох, улсын нөөцөд хамаарах бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх зэрэг уг хуулийн хэрэгжих нөхцөлийг хангасан процессын заалтуудыг зарим дүрэм, журам, аргачлалыг батлах эрх олгох замаар нэмж хуульчлах, УНХТГ-ын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн бүрдэл, зорилтыг бүрэн тодорхойлох, Гамшгаас хамгаалах тухай хуулийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн хамрах хүрээ зохицуулах харилцаа, арга зам, нэр томьёо, зарчмыг тодорхой болгох, нөөцийн бараа, материалын жагсаалт гаргах, бүрдүүлэх, гаргах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох, нөөцлөх хугацаа тооцох, улсын нөөцөд хамаарах бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх зэрэг уг хуулийн хэрэгжих нөхцөлийг хангасан процессын заалтуудыг зарим дүрэм, журам, аргачлалыг батлах эрх олгох замаар нэмж хуульчлах, УНХТГ-ын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох зорилгоор холбогдох өөрчлөлтийг оруулахаар тусгана.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн бүрдэл, зорилтыг бүрэн тодорхойлох, Гамшгаас хамгаалах тухай хуулийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн хамрах хүрээ зохицуулах харилцаа, арга зам, нэр томьёо, зарчмыг тодорхой болгох, нөөцийн бараа, материалын жагсаалт гаргах, бүрдүүлэх, гаргах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох, нөөцлөх хугацаа тооцох, улсын нөөцөд хамаарах бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх зэрэг уг хуулийн хэрэгжих нөхцөлийг хангасан процессын заалтуудыг зарим дүрэм, журам, аргачлалыг батлах эрх олгох замаар

нэмж хуульчлах, УНХТГ-ын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох зорилгыг хангаж чадах эсэх зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төрийн албаны захирах, захирагдах ёсыг санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим талаар байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой.	Бага хэмжээний зардал шаардагдах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор ОБЕГ, УНХТГ-ын улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, сэлгэх, аюулгүй байдлыг хангах, захиран зарцуулах, санхүүжүүлэх үйл ажиллагаа болон бусад чиг үүргийн хэрэгжилт сайжирна. Үүний зэрэгцээ иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаа хангагдана.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Улсын нөөцийн тухай хуульд холбогдох өөрчлөлтийг тусгахдаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй. Тус хуулиар дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэхээр нэмэх;
2. Хуулийн зорилт болон холбогдох бусад зүйл, хэсэгт улсын нөөцийн бараа, материалыг “сэлгэх”, “аюулгүй байдлыг хангах” талаар тусгах;
3. Үйл ажиллагааны зарчмыг “хууль дээдлэх, нэгдмэл харилцан уялдаатай, шуурхай, тасралтгүй байх, шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологи, мэдээллийн сүлжээг ашиглах” гэж тодорхойлох;
4. Улсын нөөцийн бараа, материалын мэдээллийн нэгдсэн санг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэн “нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх журам, аргачлал, маягтыг Засгийн газар батлах” зохицуулалтыг тусгах;
5. “Орон нутгийн нөөцөд хамаарах бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, захиран зарцуулах журам, жагсаалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батлах”, зохих “хуулийн этгээд нь нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх үүрэг хүлээх” зохицуулалтыг бий болгох;
6. “Улсын нөөц хариуцсан албаны тогтолцоог Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтоох”, “Улсын нөөц хариуцсан албаны дэргэд нөөцийн бараа, материалын чанар стандартыг судлан тогтоох лаборатори болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн нэгжтэй байж болох” зохицуулалтыг тусгах;
7. “Нийгэм-эдийн засгийн байдал, газар зүйн онцлог, хүн амын нягтрал, хотжилт, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээ болон бусад нөхцөл байдлыг харгалзан улсын нөөцийн бараа, материалын жагсаалтыг тогтоох, бүрдүүлэх, гаргах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох, нөөцлөх хугацаа тооцох аргачилсан зааврыг батлах” эрхийг Засгийн газарт олгосон зохицуулалтыг бий болгох;
8. “Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, шинэчлэхэд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.11-т заасан албан татвараас чөлөөлөхөд мөрдөх журмыг баримтлах” зохицуулалтыг тусгах;
9. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийн бүрэн эрхэд “гамшиг, аюулт үзэгдлийн онцгой тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эхний ээлжинд нэн шаардлагатай нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс зарцуулах шийдвэр гаргаж, Засгийн газарт даруй танилцуулах” зохицуулалтыг бий болгох;
10. Мөн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор техникийн болон нэр томьёо, найруулгын шинжтэй зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг хийхээр хуулийн төслийг боловсруулах.

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийхийг зорилгоо.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдсэн болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо уг төсөл нь “нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр бичигдэж байгаа буюу уг харилцаа нь нэгэнт өмнө нь хуулиар зохицуулагдсан харилцаа байх тул хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийг өргөжүүлсэн хэсэгт зардал тооцох болно.

Тодруулбал, тус аргачлалд зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардлыг, иргэнд үүсэх зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацааг тус тус оруулан тооцохоор заасан.

Иймд тус аргачлалд заасан журмыг үндэслэн зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцож үзсэн бөгөөд хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно.

Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

НЭГ: УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь иргэдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

ХОЁР: УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”-т дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцүүлэн “Онцгой байдлын ерөнхий газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г Монгол Улсын Шадар сайд баталсан.

Энэхүү төлөвлөгөөнд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 үйл ажиллагаа, онцгой байдлын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 9 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ, төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 30, нийт 80 арга хэмжээг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэхээр боловсруулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 9.2-д “Улсын нөөцөд стратегийн болон гамшгийн нөөцийн бараа материалыг нөхөн бүрдүүлэх ажиллагааг зохион байгуулж, 100.000 хүнийг анхдагч хэрэгцээгээр хангахаар бэлтгэн, бэлэн байдлыг хангах”, 9.4-д “Улсын нөөцийн анги, салбар, цэгийн нөөцийн барааны бүртгэл, хяналтын цахим мэдээллийн санг бий болгож хадгалалт, хамгаалалтад хиймэл оюун ухаан ашиглаж эхлэх”, 12.3-д “Онцгой байдлын байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах”-аар тусгасан. Энэхүү хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.4.6, 4.4.4.7, 4.4.4.8 дахь заалтууд болон “Онцгой байдлын ерөнхий газрын стандарттай хөгжлийн стратеги 2030” баримт бичгийн зорилттой бүрэн нийцэж байгаа болно.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн **7/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.5 дахь хэсэгт** “Энэ хуулиар зохицуулж буй нөөцөд хамаарах бараа, материалын нэгдсэн мэдээллийн сан хөтлөх журам, заавар, маягыг батлах.” бүрэн эрхийг Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр,

4/4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан аймаг, сум, нийслэл, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллага нь нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх үүрэг хүлээнэ.” гэж тусгасан.

Энэхүү үүрэг хүлээлгэж буй зохицуулалт нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.1-д “Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна:”, 10.3-д “Өдөр тутмын бэлэн байдлын үед дараахь арга хэмжээг авна:”, 10.3.5-д “Гамшгийн

болон орон нутгийн нөөц бүрдүүлэх”, 34.2-д “Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ.”, 34.2.2-д “гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;” зэрэг заалтуудтай нийцэж байгаа болно.

Өөрөөр хэлбэл тухайн шатны засаг дарга болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга нь Улсын нөөцийн тухай хуулийн 4.2-дахь заалтын хэрэгжилтийг хэрхэн яаж хангасан тухайгаа хуулийн төслийн **7/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.5 дахь хэсэгт** заасан журам, маягтын дагуу мэдүүлэх үүрэгтэй байхаар тусгасан гэсэн үг.

Үүнээс гадна өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан “**гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах үүргийг**” хуулийн этгээд бүр хүлээхээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6-д заасан байна.

Хуулийн этгээд нь нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг улирлаар¹ гарган хүргүүлэх ба “Мэдээ, мэдээллийг нэгдсэн санд бүртгүүлэх” үүрэгт дараах агуулга багтана гэж тооцоолбол:

1. Мэдээлэл бэлтгэх;
2. Зохих маягтыг бөглөх;
3. Мэдээлэл /маягт/-ийг зохих байгууллагад хүргэх /ОБЕГ, анги, салбар/

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /минут/
Мэдээлэл бэлтгэх	Тоолох, тулгах	30
Зохих маягтыг бөглөх	Бичих	15
Мэдээллийг хянах	Хянах	5
Мэдээлэл /маягт/-ыг зохих байгууллагад хүргэх	Хүргэх	10
НИЙТ		60 минут буюу 1 цаг

Тайланг жилд 4 удаа гаргахаар ДАВТАМЖ-ийн ТОО-г 4 гэж тооцоолов.

Хуулийн этгээд нь “мэдээ, мэдээллийг нэгдсэн санд бүртгүүлэх” үүргийг нэг жилийн хугацаанд улирал тутам хэрэгжүүлэхдээ нийт 240 минут (60мин * 4) буюу 4 цаг 00 минут зарцуулна.

Хуулийн этгээд нь “мэдээ, мэдээллийг нэгдсэн санд бүртгүүлэх” үүргийг гүйцэтгэсэн ажилтныг улиралд 1 удаа 1 цагийн хугацаатайгаар илүү цагаар

¹ Улсын нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь хэсэг “улсын нөөцийн салбаруудын бараа, материалын хөдөлгөөний талаархи мэдээ болон санхүүжилтийн тайланг улсын нөөцийн салбаруудаас авч нэгтгэн, **улирлаар** гаргаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

ажиллуулж, нөхөн амрах эсхүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтаар баталсан журамд заасны дагуу илүү цагийн хөлсийг олгох замаар шийдвэрлэх боломжтой.

Тухайлбал:

Ажилтан Б 2025 оны 3 дугаар сард ажлын 21 өдөр буюу 168 цаг ажиллахаас ажлын шаардлагаар 4 цаг илүү ажиллаж, нөхөн амраагүй бол түүнд олгох илүү цагийн хөлсийг дараах байдлаар тооцно:

Он, сар	Ажлын өдөр	Ажлын цаг	Сарын цалин хөлс
2025 оны 3 дугаар сар	21	168	1,092,000
2025 оны 4 дүгээр сар	22	176	1,144,000
2025 оны 5 дугаар сар	22	176	1,144,000
ДҮН	65	520	3,380,000

Нэг цагийн дундаж цалин хөлс = 3,380,000 төгрөг ÷ 520 цаг = 6,500 төгрөг

Илүү цагт ногдох нэмэгдэл хөлс = 6,500 төгрөг × 4 цаг × 1.5 = 39,000 төгрөг болно.

ГУРАВ: УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан үзэхэд шинэ төрлийн буюу зардал үүсгэх боломжтой үүргийг шинээр бий болгоогүй байна. Өөрөөр хэлбэл, Онцгой байдлын ерөнхий газар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын нөөцийн тухай тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хүрээнд үндсэн чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Төрийн байгууллагад шинээр үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төрд тусгайлсан нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

---oOo---

**УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ

- 1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- 1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- 1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох
- 1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох
- 1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- 1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 2.1 Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах
- 2.2 Судалгааны аргаар цуглуулсан мэдээллийг боловсруулах

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

- 3.1 Улсын нөөцийн тухай хуулийн 1 дүгээр зүйл
Хуулийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ
- 3.2 Улсын нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйл
Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ
- 3.3 Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйл
Хуулийн нэр томъёоны хэрэгжилтийн үнэлгээ
- 3.4 Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйл
Улсын нөөцийн ангилал, түүний хэрэгжилтийн үнэлгээ
- 3.5 Улсын нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйл
Улсын нөөцийн бараа, материалын ашиглах зориулалт, хэрэгжилтийн үр дагавар
- 3.6 Улсын нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйл
Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар
- 3.7 Улсын нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйл
Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар
- 3.8 Улсын нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйл
Улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар
- 3.9 Улсын нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйл
Улсын нөөцийн бараа, материалыг зарцуулах нөхцөл, хэрэгжилтийн үр дагавар
- 3.10 Улсын нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйл
Улсын нөөцийн улсын төсвийн санхүүжилт, хэрэгжилтийн үр дагавар
- 3.11 Улсын нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйл
Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт, хэрэгжилтийн үр дагавар
- 3.12 Улсын нөөцийн тухай хуулийн 12 дугаар зүйл
Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар
- 3.13 Улсын нөөцийн тухай хуулийн 13 дугаар зүйл
Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар
- 3.14 Улсын нөөцийн тухай хуулийн 14 дүгээр зүйл
Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар
- 3.15 Улсын нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйл

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар
- 3.16 Улсын нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйл
Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар
- 3.17 Улсын нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйл
Улсын нөөцийн салбарын үүрэг, хэрэгжилтийн үр дагавар
- 3.18 Улсын нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйл
Улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалахтай холбогдуулан гэрээ байгуулсан этгээдийн хүлээх эд хөрөнгийн хариуцлага, хэрэгжилтийн үр дагавар
- 3.19 Улсын нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл
Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтийн үр дагавар.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- 4.1 Дүгнэлт, зөвлөмж

ТАВ. НОМ ЗҮЙ

ЗУРГАА. ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Монгол Улсын Их Хурал
ЗГ	Монгол Улсын Засгийн газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УНГ	Улсын нөөцийн газар

1.1 Үнэлгээ хийх үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.5-д “Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, био бэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлнэ.”, 3.4.1.11-д “Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эмнэлгийн тусламжийг хүн амд шуурхай хүргэх чадавхыг байнга дээшлүүлнэ.”, 3.4.2.3-д “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ.” гэж тус тус заасан.² Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Амар тайван, аюулгүй нийгэм буюу долоодугаар бүлгийн 7.3 дахь зорилтын 1-р үе шат (2021-2030)-д Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ, уг зорилтыг хэрэгжүүлэх 1-р үе шатанд төлөвлөсөн ажлын 3-д “Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн түвшнийг бүрэн тодорхойлно” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.” 3.3.4.8-д “Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулж, өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллана.”, 3.3.4.19-д “Стратегийн хүнсний хангамж, нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ. 3.3.4.34-д “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мянган тонн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.”, 4.4.4.6-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгсэл, агуулахын аж ахуйн технологийг хөгжүүлж, гамшгийн үеийн болон стратегийн зориулалттай бараа материалын нөөц, хангамжийн хэмжээг нэмэгдүүлнэ.”, 4.4.4.7-д “Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барьж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангана.”, 4.4.4.8-д “Шатахуун, шатах, тослох материалын бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулах барина.”, 4.4.5.1-д “Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон түүний дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2010 он, №36

тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.”, 4.4.5.4-д “*Эрсдэлийн удирдлагын үе шат бүрд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангаж, урамшуулах бодлогыг дэмжинэ.”* гэж тусгасан байна.

Гамшгийн эрсдлийг бууруулах дэлхийн 3 дугаар бага хурал Япон улсын Сендай хотноо зохион байгуулагдаж Сендайн үйл ажиллагааны хүрээнд хамтын нийгэмлэгийн улс орнууд уриалан дэмжсэнд манай улс нэгдэн орсон. 2017 онд Монгол Улсын Засгийн газрын 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн зорилтыг “Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх” гэж тодорхойлжээ.

Иймд улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилт нь байгалийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалсан гамшиг, аюулт үзэгдэл, тохиолдлын үед улсын нөөцийн бараа, материал хуульд заасан зориулалтаар ашиглагдах үйл ажиллагааны агуулга, үйл ажиллагааны цар хүрээ, үр дүн нь Үндэсний хууль тогтоомж, төрийн бодлогын бичиг баримтын хэрэгжилт болон гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшиг, аюулт үзэгдлийн үед яаралтай хариу арга хэмжээ авах, тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон улсын эрх зүйн бичиг баримт, уриалга, хөтөлбөрийн хэрэгжилтээс хамаарна. Учир нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх зүйн бусад актууд болон олон улсын эрх зүйн бичиг баримт, зөвлөмж зэрэгт гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсэг нь гамшгийн нөөц, хангалтын бэлэн байдлын тухай байна.

Улсын нөөцийн тухай хуульд “Улсын нөөц” гэж нийгэм эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед ашиглахаар нөөцлөн хадгалж буй буй бараа, материалыг тодорхойлжээ.

Хуульд заасан тодорхойлолтоор улсын нөөцийн бараа, материалын зориулалт, ашиглагдах тохиолдлын агуулга нь өргөн хүрээтэй ба улсын нөөцийн зориулалтаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг гамшгийн үед ашиглах нь тэрхүү өргөн хүрээ бүхий зориулалтын зөвхөн нэг хэсэг болж байна. Мөн улсын нөөцийн тухай хуульд нөөцийн бараа, материалыг нөөцлөн хадгалж буй гэж тодотгон заасан нь онцлог байна. Энэ утгаараа улсын нөөцийн бараа, материал нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд чухал ач холбогдол бүхий хүчин зүйл болох авч гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нөөцлөн хадгалж буй бараа, материал гэдэг утгаараа гамшиг, аюулт үзэгдэл, онцгой байдлын үед нөөц гэх *ухаагдахуунтай* холбоотой бүх асуудлыг зохицуулах боломжгүй юм. Учир нь байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдлийг эрт илрүүлэх, бууруулах, нэрвэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, гамшигт нэрвэгдэгсдийг аврах, эрэн хайх, сэргээн босгох их үйл хэрэгт **нөөцийн** тухай ойлголтыг бараа, материал, үйлчилгээ, технологи, тээвэр ложистик, харилцаа холбооны болон гамшгийн үед яаралтай аврах, аюулыг зогсоох, нэрвэгсдэд яаралтай тусламж

үйлчилгээ үзүүлэх бие бүрэлдэхүүн болон үүрэг хүлээсэн бусад субъектүүдийн хэрэглэх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нэрвэгсдийн хоргодох байр, түүний дагалдах наад захын ахуйн хэрэглээ гэх зэргээр өргөн ойлголтыг хамруулдаг байна. */Гадаад орнуудын туршлага хэсгээс гамшгийн нөөцийн тодорхойлолт, төрөл, нөөцлөх, болон удирдлагын талаар дэлгэрэнгүй үзнэ үү/*

Хуулийн хэрэгжилтийн үр дүн нь аливаа байгууллагын бичмэл тайлан бус харин гамшиг, аюулт үзэгдэл, онцгой байдал үүсэн тохиолдолд хүн амын аюулгүй байдал хэрхэн хангагдснаар илэрхийлэгдэх, хохирол багатай даван туулах боломжыг бүрдүүлсэн байхад орших тул Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ өнөөдрийн хүрсэн түвшинг ахиулахад хуулийн зохицуулж буй харилцаа тохирч нийцэж байгаа эсэх, гадаад орнуудын туршлага, гамшгийн эрсдлийг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд нөөцийн тухай асуудал хэрхэн тавигддаг болохыг анхаарав.

Мөн гамшгаас хамгаалах тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудаар гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгийн тохиолдлыг эрт илрүүлэх, шинээр гамшгийн эрсдэлт нөхцлийг нэмэгдүүлэхгүй байх зэрэгт нөөцийн тухай асуудал хөндөгдөж байна. Жишээлбэл, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах улсын албад, аймаг, нийслэл, сум, дүүрэг гамшгийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөтэй байх үүрэгтэй. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.3-т гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын Шадар сайдын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 120 дугаар тушаалаар баталсан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан байх гамшгийн бэлэн байдлын нөөц нь Улсын нөөцийн тухай хуульд заасан орон нутгийн нөөц байх нь тодорхой байна. Харин гамшгийн бэлэн байдлын нөөцийг нөөцлөн хадгалж шаардлага үүсэн үед ашиглахад бэлэн чанар стандарттай, түгээгдэх боломжтой газар зүйн байрлалд, дэд бүтцийн нөөц эх сурвалж тээвэр ложистикийн олон хувилбараар төлөвлөгдсөн байдлаар хуулийн хэрэгжилтийн үр дагавар тодорхойлогдоно.

Гамшгийн үед хэрэглэх орон нутгийн нөөц нь гамшиг, аюулт үзэгдэл гэнэтийн байдлаар агшин зуурт үүсэх, хүн амын амь насанд аюул тулгардаг гэдгийг ухамсарлан ойлгож, хүний амь насыг хамгаалах үүднээс яаралтай тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай хоол, ундны ус, эм, эмнэлэгийн хэрэгсэл, хаягдал бохирдлын уут зэрэг хүн бүрт зориулсан сав баглаа, хэмжээ бүхий байдлаар бэлтгэгдэх ёстой байна. */Япон зэрэг орны туршлагаас дэлгэрэнгүй үзнэ үү/* Энэ утгаараа орон нутгийн нөөцийн бараа, материалыг нөөцлөн хадгалах зориулалтын агуулах, сав, хашаа, талбай зэрэг дэд бүтэц байхаас гадна, мэдээллийн програм хангамж бүхий удирдлага менежментийн тогтолцоо, мэргэшсэн, болон сургагдсан ажилтнуудтай байх нь хуулийг хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага болно. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт “гамшгийн эрсдлийг ойлгох”-ыг тэргүүлэх чиглэл болгож уриалсан. */Сендайн хөтөлбөрийн тайлбараас дэлгэрэнгүй үзнэ үү /*

Өөрөөр хэлбэл гамшгийн эрсдлийг ойлгох гэдэг нь гамшиг, аюулт үзэгдлийн тухай нийтэд танин мэдүүлэх, сургалтаар хязгаарлагдахгүй илүү өргөн хүрээнд гэдгийг Сендайн үйл ажиллагааны хүрээнд тодорхойж, гамшгийн эрсдэл нь болзошгүй аюулын тохиолдол болон үзэгдэл, түүнд бэлэн байх чадавх, гамшиг, аюулд өртөх магадлал, эмзэг байдлын харилцан хамаарлыг бүхэлд нь хамруулан ойлгохыг чухалчилжээ. Энэ утгаараа, тухайлбал, гамшгаас хамгаалах төлөвлөгөө хийх үүрэг

бүхий субъект нь “гамшгийн эрсдлийн ойлголт”-ын хүрээнд гамшгийн нөөцийн тухай асуудлыг дээр дурдсанчлан хариуцлагатай авч үзэх учиртай.

Гамшгийн эрсдэл гэх ухагдахууны нэг элемент болох гамшиг эрсдэлд бэлэн байх чадавх нь бат бэх тэсвэртэй дэд бүтэц, гамшгийн тухай мэдлэг, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, олон нийт гамшигт бэлэн байх зэргээс шууд хамааралтай байна.

Нөөцийн тухай асуудал нь гамшгийн бэлэн байдлыг хангах болон гамшгийн үед яаралтай хариу арга хэмжээ авах, тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хувьд харилцан адилгүй байна.

Гамшиг, аюулт үзэгдлийн үед яаралтай арга хэмжээ авахад шаардагдах нөөцийн тухай асуудал нь зөвхөн нөөцлөн хадгалсан бараа, материалаар хязгаарлагдахгүй бөгөөд эдийн засгийн агуулга, зардлын хэмнэлт, бараа материалын онцлог байдал зэрэг олон хүчин зүйлээс хамааран дэлхийн улс орнуудад гамшгаас хамгаалах, гамшиг, аюулт үзэгдэл, тохиолдлын үед ашиглах нөөцийн бараа материалын хангалтыг нөөцлөн хадгалахаас гадна бусад байгууллага, аж ахуйн нэгжид хамтын ажиллагааны зарчмаар даалгах, гэрээ байгуулах замаар бэлэн байдлыг хангах удирдлага зохион байгуулалт-менежментийг хөгжүүлж байна.

Улсын Их Хурал 2007 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Улсын нөөцийн тухай хуулийг баталж, улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг тусгайлан зохицуулсан бие даасан анхны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн.

Улсын нөөцийн тухай хуульд 2014, 2015, 2016, 2017, 2022, 2023 онуудад бусад хуулийг батлахтай холбогдуулан түүнийг дагалдан гарах хуулиар нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Улсын нөөцийн тухай хууль батлагдсанаас хойш 15 жилийн хугацаанд түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг судлан тогтоох ажил хийгдээгүй байна.

Иймд хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “...хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно”³ гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан /6 дугаар хавсралт/ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгон үнэлгээ хийж, тайланг боловсруулав.

Мөн Онцгой байдлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, Монгол Улсын шадар сайд Онцгой байдлын ерөнхий газрын /цаашид ОБЕГ/ үйл ажиллагаатай танилцаад “Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаанд эрс шинэчлэлтийг хийх, үүний тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” үүргийг өгсөн⁴ байна.

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №25

⁴ ОБЕГ-ын УНГ-ын даргатай хийсэн уулзалт, ярилцлага

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээ нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдэнэ. Түүнчлэн хуулиар зохицуулсан харилцаа нь зорилгодоо хүрч чадаж буй эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэх тогтолцоо оновчтой эсэх талаар судалгаа хийж хуулийн хийдэл, давхардал, зөрчлийг илрүүлж, цаашид авах арга хэмжээ санал, зөвлөмжийг боловсруулахад чиглэгдэв.

ОБЕГ-аас 2021-2024 оны стратеги төлөвлөгөөндөө “Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, эсхүл шинэчлэн батлуулах хэрэгцээ, шаардлагын үндэслэлийг тодорхойлсны үндсэн дээр уг хуулийн төслийг боловсруулна” гэж тусгасан ба УНГ-аас тодорхой ажлуудыг төлөвлөн ажиллажээ. Түүний мөрөөр Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, цаашид хууль тогтоомжийн төсөл бэлтгэх ажилд дахин хамтран ажиллах саналыг судалгааны багт ирүүлсэн болно⁵.

Судалгааны баг “Улсын нөөцийн тухай хууль”-д бүхэлд нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг гаргасан болно.

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь буюу нийт 4 бүлэг 19 зүйлд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ба үүнээс улсын нөөцийн харилцаанд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, зохицуулалтын хувьд шууд уялдсан Монгол Улсын бусад хууль, УИХ, ЗГ-ын тогтоол түүнчлэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрүүдийг үнэлгээний хүрээнд хамруулан сонгосон болно.

Мөн үнэлгээний харьцуулсан дүн шинжилгээг хийхэд ач холбогдолтой гэж үзэн Улсын нөөцийн тухай хууль батлагдахаас өмнөх үеийн улсын нөөцийн чиг үүргийг гүйцэтгэж байсан байгууллагын эрх зүйн орчин⁶, зарим нэг гадаад орнуудын улсын нөөцийн тухай хууль, эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны менежмент, Сендайн үйл ажиллагааны хүрээ, гашгийн эрсдлийг бууруулах олон улсын хөтөлбөр баримт бичгийг судалгаанд хамруулав.

Хүснэгт 1-ээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд хамрагдаж буй Улсын нөөцийн тухай хуулийн зүйл хэсгийг, Хүснэгт 2-оор Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх бусад хууль, эрх зүйн зохицуулалтыг харуулав.

⁵ ОБЕГ-ын 2025 оны 04 сарын 01-ний өдөр Судалгааны багт ирүүлсэн 02/842 дугаартай албан бичиг

⁶ Тайлангийн ном зүй хэсгийг үзнэ үү

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2	Хоёрдугаар бүлэг. Улсын нөөц, түүний зохицуулалт	4 дүгээр зүйл. Улсын нөөц 5 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалын зориулалт 6 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх 7 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг хадгалах 8 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг шинэчлэх 9 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын зарцуулах нөхцөл 10 дугаар зүйл. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардал 11 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт
3	Гуравдугаар бүлэг. Улсын нөөцийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх	12 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 14 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 15 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх 17 дугаар зүйл. Улсын нөөцийн салбарын үүрэг
4	Дөрөвдүгээр бүлэг. Бусад зүйл	18 дугаар зүйл. Улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалахтай холбогдуулан гэрээ байгуулсан этгээдийн хүлээх эд хөрөнгийн хариуцлага 19 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

д/д	Хуулийн нэр	Зүйл заалт
1	Гамшгаас хамгаалах тухай	4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.14, 4.1.15, 4.1.19, 4.1.24, 10 дугаар зүйлийн 10.4.14 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.4, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.11 42 дугаар зүйлийн 42.1,
2	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2,
3	Онц байдлын тухай	16 дугаар зүйлийн 1 хэсгийн 8 дахь заалт
4	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	5 дугаар зүйлийн 5.2
5	Монгол улсын батлан хамгаалах тухай хууль	17 дугаар зүйлийн 17.1.7

1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь Улсын нөөцийн тухай хуулийн зорилго “...нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна” гэсэн хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж түүний хэрэгжилтийн явцыг тодорхойлоход оршино.

Шалгуур үзүүлэлтийг дараах хүчин зүйлүүдтэй уялдуулан тогтоов. Үүнд:

- Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хууль зүйн үндсэн шаардлага;⁷
- Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийгэм, эдийн засгийн харилцаанд гарсан өөрчлөлт;
- Улсын нөөцийн бараа, материалыг ашиглах эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэх хандлага;
- Онцгой байдлын ерөнхий газрын болон түүний зохион байгуулалтын бүтцийн нэгж буюу Улсын нөөцийн газрын үйл ажиллагаа /Цаашид УНГ гэх/-г улам бүр сайжруулах хэрэгцээ шаардлага;⁸
- бусад хүндрэл бэрхшээл.

Улсын нөөцийн тухай хуулийг хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ уг хуулийн зүйл, хэсэг, заалт нэг бүрд заагдсан хуулийн зохицуулалт хэрэгжиж чадаж буй эсэхийг тодорхойлохын тулд “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” гэсэн 3 үндсэн шалгуур үзүүлэлтийг хэмжих боломжтой хэмээн сонгов.

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёон тодорхойлолт	Зорилгод хүрсэн ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.
2	Хоёрдугаар бүлэг. Улсын нөөц, түүний зохицуулалт	4 дүгээр зүйл. Улсын нөөц 5 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалын зориулалт 6 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх 7 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг хадгалах 8 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг шинэчлэх 9 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын зарцуулах нөхцөл 10 дугаар зүйл. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардал	Зорилгод хүрсэн ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.

⁷ Хууль тогтоомжийн тухай хуулиар Хуулийн үр дагаварт хийх үнэлгээг 5 жил тутамд шаардлагатай бол түүнээс өмнө хийнэ. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, 2 дугаар хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”

⁸ Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

		11 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт	
3	Гуравдугаар бүлэг. Улсын нөөцийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх	12 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 14 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 15 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх 17 дугаар зүйл. Улсын нөөцийн салбарын үүрэг 18 дугаар зүйл. Улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалахтай холбогдуулан гэрээ байгуулсан этгээдийн хүлээх эд хөрөнгийн хариуцлага 19 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
4	Дөрөвдүгээр бүлэг. Бусад зүйл		Практикт нийцсэн байдал.

1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхдээ уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш /2007 он/ нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааны эерэг, сөрөг үр дагаврыг илрүүлэхийн тулд судалгааны хүрээнд хамрагдсан хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулав.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох нөхцөлийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас үнэлэх нь учир дутагдалтай тул тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгосон болно.

Улсын нөөцийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт бүрийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн аль тохиромжтойд нь тулгуурлан хуулийн хэрэгжилтийн бодит үр дагаврыг хуулийн зорилт /Хуулийн 1 дүгээр зүйл/-той харьцуулан үнэлэв. Ийнхүү харьцуулах тоо баримт нь хуулийг хэрэгжүүлэгч ОБЕГ-ын тайлан /мөн УНГ-ын тайлан орно/, статистик мэдээ байв.

Улсын нөөцийн тухай хуулийн зүйл, заалтуудад улсын нөөцийн хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт байхгүй /байвал зохих тоо үзүүлэлтийг хуульд шаардлага болгон тусгаагүй/ түүнчлэн улсын нөөцийн бараа, материалын тоо хэмжээ, төрийн нууцын зэрэгт хамаарах⁹ тул нөөцийн бараа, материалын тоог судлаагүй болно.

⁹ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.3.к-д “улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл;”

1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ /цаашид “Үнэлгээ” гэх/ хийхдээ тус хуулийн зүйл, хэсэг, заалт нэг бүрд оновчтой шалгуур үзүүлэлтийг гаргаж, түүнд тулгуурлан хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд хэрэгтэй асуултыг томъёолон тавих аргачлалыг ашиглав. Үнэлгээнд хуулиар нарийвчлан зохицуулаагүй, эсвэл бусдад эрх олгосон зүйл, заалтуудад тодорхой таамаглал дэвшүүлсэн асуулт тавьсан. Мөн хуулиар үүрэг болгосон буюу шууд үр дүнг нэхэх боломжтой зүйл, заалтуудад хариулт авах үүднээс тохирох асуултыг тухай бүрд нь томъёолсон болно.

Үүнээс гадна, судалгааны явцад ОБЕГ-ын УНГ-ын удирдлага, алба хаагчид болон улсын нөөцийн салбар, ангийн алба хаагч, ажилтнуудын дунд уулзалт-ярилцлага, нэг бүрчилсэн ярилцлагыг тус тус зохион байгуулав.

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр аргаас хамаарч мэдээлэл цуглуулах дараах аргыг сонгосон. Үүнд:

1. **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах.** Хуулийн хэрэгжилттэй холбоотой эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, статистик тоо баримт¹⁰, хуулийн үзэл баримтлал, хэвлэл мэдээллийн эх сурвалж;
2. **Холбогдох субъектүүдээс судалгаа авах.** Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хариуцах чиг үүрэг бүхий ОБЕГ-ын УНГ-ын удирдлага, алба хаагчидтай уулзаж ярилцах, асуулт тавьж хариулт авах;
3. Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаатай /объект дээр нь очих/ судлаачид биеэр очиж танилцах, алба хаагч, ажилтнуудтай уулзалт-ярилцлага зохион байгуулах;
4. ОБЕГ-ын УНГ-ын тайлан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журам, заавартай танилцах зэрэг болно.

ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээ хийх судалгаа шинжилгээний ажлын хэрэгжүүлэх үе шат 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс мөн оны 05 дугаар сарын 08 ны өдөр хүртэл хугацаанд календарийн 30 өдөр хоног байв.

Энэ үе шатанд холбогдох тоо баримт, эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэр, түүнтэй холбоотой дүрэм, журам, стандартыг судалж, судалгааны илэрцтэй холбогдуулан ОБЕГ-ын УНГ-ын удирдах албан тушаалтан, алба хаагч, ажилтнуудтай тодруулга уулзалт-ярилцлага хийв.

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай бусад цугларсан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийгдсэн болно.

Говьсүмбэр, Дархан-Уул аймаг дахь улсын нөөцийн салбар, Улаанбаатар хот дахь Онцгой байдлын ерөнхий газрын 112, 179, 185 дугаар ангийн удирдах албан

¹⁰ Статистик тоо баримтыг нууцтай харилцах олгогдсон эрхийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны тайлан болон алба хаагчдаас авсан.

тушаалтан, алба хаагч, ажилтнуудаас авсан санал асуулга, ярилцлага, тэдний үйл ажиллагаандаа мөрдөж байгаа баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийв.

2.1 Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний ажлын тогтоосон хүрээнд Монгол Улсын хууль 28, УИХ-ын тогтоол 7, Засгийн газрын тогтоол 120, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, Монгол Улсын Үндэсний хөтөлбөр, хэрэгжилтийн тайлан 1, Шадар сайдын тушаал 3, ОБЕГ-ын даргын тушаал 4, ЗГ-аас баталсан норм, дүрэм, журам 13, Шадар сайдын баталсан журам 8, ОБЕГ-ын даргын тушаалаар баталсан хөтөлбөр, жагсаалт, журам 6, ОБЕГ-ын бүтцийн нэгжийн даргын баталсан журам 1, ОБЕГ-ын стратеги төлөвлөгөө /2021-2024/ зэрэг мэдээллийг ашиглав.

Мөн Улсын нөөцийн тухай хууль батлагдан гарахаас өмнө үеийн эрх зүйн актуудыг судлав.¹¹

2.2 Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

ОБЕГ болон УНГ-ын алба хаагчид, улсын нөөцийн салбар, ангийн алба хаагч, ажилтнуудаас хуульд нарийвчлан тусгаагүй боловч үйл ажиллагааны практикт эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр зохицуулж байсан тохиолдол, хууль зүйн хийдлийг орлуулах замаар холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаалаар батлагдсан дүрэм, журам, зааврын талаар тайлбар тодруулгыг авч ажиллав.

Мөн зохих журмын дагуу нууц хадгалах баталгаа гаргаж, эрх бүхий байгууллага албан тушаалтнаас гаргасан тогтоол, тушаал, шийдвэр, ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын /тухайн үеийн нэршлээр/ зарим тайлан, үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журамтай танилцсан.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 Улсын нөөцийн тухай хуулийн 1 дүгээр зүйл. Хуулийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ:

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Улсын нөөцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг тодорхойлохдоо 1-рт, улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, 2-рт, хадгалах, 3-рт, тээвэрлэж хүргэх, 4-рт, шинэчлэх, 5-рт, захиран зарцуулах, 6-рт, санхүүжүүлэх гэсэн байна.

Тус хуулийн зорилгод тодорхойлсон дээрх асуудлыг дараах байдлаар хуулийн зүйлүүдэд зохицуулсан. Үүнд:

Хуулийн 6 дугаар зүйлд бараа, материалыг бүрдүүлэхийг, 7 дугаар зүйлд бараа, материалыг хадгалахыг, 8 дугаар зүйлд бараа, материалыг шинэчлэхийг, 9 дүгээр зүйлд бараа, материалыг зарцуулах нөхцөлийг, 10 дугаар зүйлд бараа, материалыг санхүүжүүлэх зардлыг тус тус тодорхойлсон боловч “тээвэрлэж хүргэх”, “объектын

¹¹ 2007 оноос өмнө Улсын нөөцийн асуудлыг зохицуулж байсан эрх зүйн актуудыг судалж, цахим хэлбэрээр эмхэтгэн судалгааны хавсралт болгон оруулав.

аюулгүй байдал буюу харуул хамгаалалт” зэрэг харилцааг орхигдуулсан нь хуулийн хийдэл үүссэн гэж үзэхээр байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах гол байгууллага ОБЕГ, түүний зохион байгуулалтын бүтцийн нэгж болох УНГ-аас нөөцийн бараа, материалыг энэхүү хуульд заасны дагуу зориулалт, нөхцлийн дагуу зарцуулах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргасан тохиолдолд удирдлага, зохион байгуулалт хийж гүйцэтгэсээр иржээ. Харин нөөцийн бараа материалыг хуульд заасны дагуу ашиглагдах нөхцөл үүссэн тохиолдолд тээвэрлэн хүргэхтэй холбоотой асуудлын зардал, тээвэр ложистиктэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг цаашид тодорхой болгох шаардлагатай байна.

Мөн түүнчлэн хуулийн зорилт хэсэг /1 дүгээр зүйл/-т тусгагдаагүй боловч “бараа, материалыг сэлгэх” гэсэн нэр томъёог 3.1.7-д тодорхойлж, энэхүү үйл ажиллагааны дотоод хяналтыг онцгой байдлыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр 15.1.4-д, Аймаг, нийслэлийн Засаг дарга сэлгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр 16.1.2-д, улсын нөөцийн салбар нь сэлгэх үйл ажиллагааг эрхлэхээр тус тус зохицуулжээ. Гэвч нөөцийн бараа, материалыг хэрхэн ямар журмаар сэлгэх талаар хуульд заагаагүй ба сэлгэх ажлын журам, стандартыг батлан гаргахыг эрх бүхий этгээдэд даалгасан зохицуулалт ч байхгүй байна.

Нөөцийн бараа материалыг нөөцлөн хадгалахад бараа бүтээгдэхүүний онцлогоос гадна хадгалтын горимыг тусгай мэргэжил, технологид тулгуурлах ба түүний зөвхөн нэг хэсэг нь бараа материалын сэлгэлт байх шаардлагатай. Нөгөө талаас бараа материалын сэлгэлт нь хүн, хүч, техникийн болон үйл ажиллагааны удирдлагын зардал шаардана. *(Гадаад орнуудын туршлага хэсгээс харна уу)*

Практик дээр нөөцийн бараа, материалыг сэлгэх талаар нэг мөр ойлголтгүй шахам байна. Нөөцийн бараа, материалыг сэлгэх ажиллагаатай холбоотой санхүүгийн зардал Улсын нөөцийн тухай хуульд тусгагдаагүй, үйл ажиллагааны журам, заавар хангалттай бус байгаа нь үүнд нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

Улсын нөөцийн зарим салбар, ангийн харуулын ажилтан, нярав хадгалагдаж байгаа нөөцийн бараа, материалыг сэлгэх ажлыг үндсэн ажлынхаа хажуугаар хийж гүйцэтгэж байна. Улсын нөөцийн тухай хуульд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд “... сэлгэх үйл ажиллагаанд” хяналт тавина, дэмжлэг үзүүлнэ” гэснээс өөр зохицуулалт, ялангуяа процессын хэм хэмжээний зохицуулалт байхгүй, хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасан аймаг, нийслэлийн Засаг дарга улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн заалт хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна.

Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам” баталсан. Гэвч энэ журмын 4 дэх хэсэгт Нөөцийн барааг шинэчлэх, **сэлгэх** гэж хамтад нь оруулж, мөн хэсгийн 4.5-т ...“сэлгэх үүргийг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч гүйцэтгэнэ” гэж зөвхөн үүрэг болгосон заалт тусгагджээ. Энэ нь агуулгын хувьд Улсын нөөцийн тухай хуульд “**сэлгэх**” ажлын талаар орхигдуулсан үүргийг журмаар зохицуулсан төдий байна. Тус журамд нөөцийн бараа, материалыг сэлгэх процессын талаар өөр заалт байхгүй байна.

3.2 Улсын нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ

2.1. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Улсын нөөцийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байна. Ялангуяа хуулийн зохицуулах харилцаа нь гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онц байдлын үед хүн амын эрүүл мэнд, амь насыг аврах, гамшгийн хохирлыг багасгах, бууруулахад зайлшгүй шаардлагатай бараа материалаар хангахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасантай бүрэн нийцэж байна.

Улсын нөөцийн тухай хуульд заасан нөөцийн бараа, материалын зориулалт, зарцуулах нөхцөл нь ялангуяа гамшгийн нөөцийн хувьд Гамшгаас хамгаалах тухай хуулиар тодорхойлогдох тул Гамшгаас хамгаалах тухай хуулийг улсын нөөцийн харилцааг зохицуулах хуульд тооцож оруулах нь зүйтэй гэж үзлээ. Цаашид улсын нөөцийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудын хүрээнд нөөцийн тухай асуудлыг системчлэн кодификацид оруулах шаардлагатай.

Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон бусад эрх зүйн бичиг баримтуудад тавигдах шаардлагаар нөөцийн бараа материалын асуудал гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй үүрэгтэй байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн нөөцийн талаар эрх бүхий субъектүүдэд эрх, үүрэг болгож заасан боловч орон нутгийн нөөцийн асуудал орхигдсон, хуулийн хэрэгжилтийг хангалттай гэх илэрц муутай байна.

Нөөцийн тухай асуудлыг зөвхөн ОБЕГ-ын УНГ-ын хариуцан зохион байгуулж байгаа нөөцлөн хадгалж (бусдад гэрээгээр хадгалуулж байгаа улсын нөөцийн бараа, материал орно) байгаа бараа, материалын хэмжээнд бус гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд авч үзэж хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Судалгаагаар ОБЕГ-ын стратеги хөгжлийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхдөө Гамшгаас хамгаалах тухай хуулийг баримталсан атлаа Улсын нөөцийн тухай хуулийг харгалзан үзээгүй байна. Улсын нөөцийн асуудал эрхэлсэн бүтцийн нэгж болох УНГ-ын зохион байгуулалтын бүтцэд байх улсын нөөцийн салбарууд аймгууд дахь онцгой байдлын газрын бүтцэд багтаж, ингэхдээ улсын нөөцийн салбар, анги, цэг гэх нэршлүүдтэй зохион байгуулагджээ. Магадгүй дээр дурдсанчлан гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн нөөцийг зохих хэмжээнд бүрдүүлэх, хадгалах тохиолдолд улсын нөөцийн салбаруудын үйл ажиллагааны цар хүрээ, үүрэг хариуцлага нэмэгдэхийн зэрэгцээ УНГ мэргэжлийн удирдлагаар өргөн хүрээд ажиллах шаардлага нь тодорч харагдах боломжтой.

Улсын нөөцийн тухай хуульд “улсын нөөцийн салбар” гэж тусгайлан зааж өгсөн байна. Үүнээс үзвэл Гамшгаас хамгаалах тухай хуулийг Улсын нөөцийн тухай хуультай уялдуулан үйл ажиллагааны болон бүтэц зохион байгууллалтыг боловсронгуй болгох хэрэгтэй.

Гэвч эдгээр зохион байгуулалтын бүтэц, орон тоотой хамааралтай асуудал нь Улсын нөөцийн тухай хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд сөргөөр нөлөөлж байна

гэсэн нотлох баримт олдоогүй ба харин хуулийн хэрэгжилтийг цаашид улам бүр сайжруулахад харгалзан үзэх асуудал юм.

3.3 Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны хэрэгжилтийн үнэлгээ

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “улсын нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг /цаашид “нөөцийн бараа, материал” гэх/;

3.1.2. “стратегийн нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материалыг;

3.1.3. “Батлан хамгаалах материаллаг нөөц” гэж Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 3.1.9-д заасныг;

3.1.4. “гамшгийн нөөц” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг;

3.1.5. “нөөцийн бараа, материалыг хадгалах” гэж худалдан авсан буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулахыг;

3.1.6. “нөөцийн бараа, материалыг шинэчлэх” гэж нөөцийн бараа, материалыг хадгалах хугацаа, холбогдох төрийн захиргааны байгууллага, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн борлуулж, нөхөн бүрдүүлэхийг;

3.1.7. “нөөцийн бараа, материалыг сэлгэх” гэж нөөцийн бараа, материалыг агуулах, талбайд хадгалах технологийн горимыг үндэслэн шилжүүлэн байршуулахыг;

3.1.8. “улсын нөөцийн салбар” гэж нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх үүргийг холбогдох шийдвэрээр гүйцэтгэгч байгууллагыг;

3.1.9. “гэрээт хадгалагч” гэж нөөцийн бараа, материалын хадгалалтын онцлог нөхцөлөөс шалтгаалан технологийн дагуу хадгалах, сэлгэн шинэчлэх

Улсын нөөцийн талаар

“Нөөц”¹² гэдэг үгийн утга нь чухал хэрэгцээтэй цаг үед хэрэглэхээр хураан хадгалсан зүйл, бэлтгэн хадгалсан зүйл¹³, “хүнсний нөөц гэж дараа хэрэглэхээр бэлтгэн хадгалсан хүнсний зүйл¹⁴”, гэж тайлбарласан байна. Нөөц гэдэг нэр томъёо нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд дотроо сангийн, эд хөрөнгийн, бэлчээрийн, усны, ашигт

¹² Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн, Физик Технологийн Хүрээлэнгийн Информатикийн салбарын судлаачид монгол үндэстний эрхэмлэн дээдэлж, уламжлан баяжуулсаар ирсэн эх хэлнийхээ үгийн сангаас 60000 гаруй толгой үг, 80000 гаруй холбоо үг бүхий “Монгол хэлний их тайлбар толь” бичиг

¹³ Монгол хэлний их тайлбар толь <https://mongoltoli.mn/dictionary/detail/63523>

¹⁴ Монгол хэлний их тайлбар толь <https://mongoltoli.mn/dictionary/detail/63527>

малтмалын, алт мөнгөний, хүнсний нөөц гэх зэргээр бусад хууль тогтоомжид тусгагджээ. Улсын нөөцийн тухай хуульд улсын нөөцийг:

- 1/нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах;
- 2/үндэсний аюулгүй байдал;
- 3/хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг,
- 4/эдийн засгийн хүндрэл бэрхшээл;

5/дайны байдал зэрэг онцгой байдлын үед хуульд заасан нөхцөл, зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг хэлнэ гэж тодорхойлсон. Энэхүү хуулийн нэр томъёоны тодорхойлолт агуулгын хувьд бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

Хууль хэрэгжилтийн практик дээр нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх буюу худалдан авах ажиллагаа зохион байгуулахад гамшгийн нөөц, стратегийн нөөц гэдгээр ялгагдаж байгаагаас нөөцлөн хадгалах бараа, материал нь агуулгын хувьд ялгарах онцлог бага байна. Мөн улсын нөөцийг ийнхүү стратегийн болон гамшгийн нөөц гэж тус тусад нэр төрөл, тоо хэмжээг зааж хуульд заасны дагуу бүрдүүлж байгаа хэдий ч гамшигт үзэгдэл буюу байгаль цаг агаарын хүндрэл үүсч, зуд, ган, үер усны аюул тохиох зэрэгт Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу зарцуулахдаа аль алинаас нь гарган ашиглаж байна.

Өөрөөр хэлбэл улсын нөөцийн бараа, материал нь хуульд заасан ангилалаар стратегийн нөөц, гамшгийн нөөц гэж ангилагдаж, нөөцлөгдөн хадгалагдаж байгаа боловч тэдгээр бараа, материалыг нөөцийн ангиллын дагуу зарцуулах үйл ажиллагааны практик тогтоогүй зөвхөн Улсын нөөцийн тухай хуульд заасан нөхцлөөр Засгийн газрын тогтоолоор гамшгийн нөөцийн болон стратегийн нөөцийн бараа аль алинаас нь зарцуулагдаж байгааг илэрхийлж байна. *УНГ-ын ажилтнуудтай хийсэн фокус ярилцлагын тэмдэглэлээс үзнэ уу/*

Харин “улсын нөөц” гэсэн хуулийн нэр томъёоноос шалтгаалан улсын нөөцийн харилцааг зохицуулах, хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн гэж үзэх үндэслэл бүхий илэрц алга байна.

Хуулийн 4 дүгээр зүйлд зориулалт, нөхцөлөөр “улсын нөөц”-ийг ангилж төрөлжүүлсэн байна. Энэ зүйлд тодорхойлсон “...дайны байдал...” зэрэг онц байдлын үед улсын нөөцтэй холбоотой харилцааг Дайны байдлын тухай хуулиар зохицуулагдахаар байна.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон¹⁵. Улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн гэж ангилсан хэдий ч батлан хамгаалах материаллаг нөөцтэй харилцааг хуулиар зохицуулна гэж зааж өгсөн бол хууль зүйн техникийн хувьд ч, мөн хуулийн зохицуулалт бүрхэг бус, илүү тодорхой байх зарчимд нийцэх байжээ. Гэвч үүнтэй холбоотой хүндрэл бэрхшээл Улсын нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлж буй практикт гараагүй байна.

Гадаад улс орнуудын нөөцийн бараа материалыг гамшгийн болон стратегийн гэж ангилдаг боловч стратегийн нөөцийг газрын хэвлий дэх баялаг буюу байгалийн түүхий эдийн нөөц зэрэг ихэвчлэн шууд гамшиг, аюулт үзэгдлийн үед хүний амь нас эрүүл мэндийг аврахад чиглэсэн бус нөөцийг хамруулж байна.

Гамшгийн нөөцийг улсын хэмжээнд болон орон нутагт нөөцлөн хадгалах ба гамшиг, аюулт үзэгдлийн үед орон нутгийн нөөц нэн тэргүүнд ашиглагдаж, гамшгийн цар хүрээ, гамшгаар учирсан хохирлын үнэлгээ, хэрэгцээ мөн орон нутгийн нөөц дуусах, нэмэлтээр нөөц бараа материал шаардагдах зэрэг нөхцөл байдлаас үндэслэн

¹⁵ Хуулийн 4 дүгээр зүйлийн тайлбараас дэлгэрэнгүй үзнэ үү.

улсын /холбооны улсын хувьд мужийн нөөц хөрөнгө дууссан үед холбооны засгийн газрын мэдлийн нөөцийг авах хүсэлт гаргах/ нөөцийн бараа материалыг ашиглаж байна.

Мөн гадаад орнуудад нөөцийн бараа, материалыг ангилахдаа газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, шуурга зэрэг аливаа байгалийн гамшиг, халдварт өвчин, цар тахал, нийтийг хамарсан осол зэрэг янз бүрийн аюулт нөхцөлийн үед хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнсний наад захын хэрэглээг хангахад бэлэн байлгах, гамшгийн хор уршгийг бууруулах, арилгах, нийгмийн амьдралыг хэвийн горимд оруулах зорилгын үүднээс тоо хэмжээг бууруулж үл болох нөөц, **бусад буюу** тоо хэмжээг бууруулж болох нөөц /энэ нь шаардлагагүй үед нөөцөөс хасаж болдог нөөц/ төрөл гэж ангилж байна.

Тэрчлэн өндөр хөгжилтэй зарим орнуудад нөөцийг төрөлжүүлэн хөгжүүлж аливаа гамшигт нөхцөл байдлын үед нөөцөө хэрэглэх зорилго, зорилтоо үр дүн сайтай ашиглаж байна. Тухайлбал, АНУ-д Стратегийн болон ховор түүхий эд материалын нөөцийн тухай хуульд нэгдсэн улсын нөөцийн тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой зааж өгсөн байна¹⁶. Энэ нь хуульд нэр томъёог хагас дутуу томъёолохоос илүүтэй хуулиар зохицуулж буй харилцаанд илүү анхаарч, хуулийг нарийн процессжуулж байгаагийн жишээ болж байна. АНУ-ын энэ хуульд стратегийн бараа, материалын захиран зарцуулах эрх нь зөвхөн Ерөнхийлөгчид байхаар заахын зэрэгцээ, харин нөөцийн бараа, материалын хадгалалт, арчлалт, хог хаягдлыг шийдэх зэрэг хуулийн хэрэгжилтийн гол субъект болох байгууллагуудын эрх хэмжээг тус тусад нь тодорхой зааж өгсөн байна.

Аливаа гамшиг, цар тахлын үеийн хор уршгийг арилгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүднээс эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх холбооны **нөөцийн** асуудлыг Эрүүл мэндийн яамны мэдэлд Үндэсний Стратегийн нөөцийн газар /SNS/ хариуцаж байна. Тус газрын эм, эмнэлгийн хэрэгслийн бараа, материал нь антибиотик, амьсгалын аппарат, өвчин намдаах эм, тариа зэргийг тусгай зориулалтын агуулахад хадгалж, тэдгээр /нөөцийн бараа, материалыг/-ийг тусламж хэрэгцээтэй нөхцөл байдал үүссэн үед *яг цагт* хүргэх боломжийг бүрдүүлсэн зохион байгуулалт хийж ажилладаг байна. Жишээ нь: АНУ-ын Вашингтон мужийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасны дагуу гамшгийн үед нөөцийн бараа, материал зарцуулагдаж дуусгавар болсон, эсхүл зарим нэр төрлийн бараа, материалын нөөц дуусгавар боллоо гэхэд Холбооны нөөцийн сангаас тусламж хүсч урьдаас тогтоосон процедурын дагуу ажилладаг байна.¹⁷

Холбооны нөөцөд хадгалагдаж буй эм, тариа зэрэг бараа, материалыг хугацаа дуусахаас өмнө эмнэлгүүдэд өгөх зэрэг менежмент /Inventory Rotation - FEFO and FIFO standard болон нөөцийн бараа, материалыг хадгалах, сэлгэх- PRR -ийн журмын бүтцийн заварыг нөөцийн бараа, материалыг хадгалах, сэлгэх хэсгээс тус тус үзнэ үү/-ийг сайн хөгжүүлж, эдийн засгийн аргаар үр ашигтай зохицуулж байна. Хамгийн сонирхолтой нь нөөцийн бараа, материалын нэр төрөл нууц байхдаа чухал биш харин

¹⁶ Strategic and Critical Materials Stock Piling Act [Chapter 190, Enacted June 7, 1939, 53 Stat. 811] [As Amended Through P.L. 117–81, Enacted December 27, 2021]/

Critical материал гэдэгт стратегийн бараа бүтээгдэхүүний технологид хэрэглэгддэг, өөр улс орноос нийлүүлж авдаг, хэрэв тасалдах, нийлүүлэлтэд эрсдэл үүсвэл амархан орлуулах боломжгүй аливаа бодис, деталь, орц найрлагын түүхий эдийг хэлнэ. Орч -судлаач

¹⁷ <https://mil.wa.gov/logistics-and-resources>

аль болох шаардлагатай үед бэлэн байлгах, тэдгээрийг шаардлага үүссэн газарт яаралтай түгээх боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг байна.

Зарим улсад тухайлбал, ОХУ, Гүрж зэрэг улсад нөөцийн бараа, материалыг шаардлага үүсэн үед гаргаж хэрэглэх гэдэг утгаараа нөөцийн бараа, материалын хууль гэж нэрлэсэн нь ажиглагдаж байна.

Дээрх гадаад орны жишээ дээрээс дүгнэж үзвэл “нөөц” нь тухайн зорилго, зориулалтаасаа шалтгаалан бодит материаллаг эд зүйл байхаас гадна нөөцлөн хадгалах, ашиглах үед бэлэн байх гэсэн ангилалаар авч үздэг байна. Тухайн улс орнуудын нийгэм эдийн засгийн байдал, үйлдвэржилт зэргээс хамаарч гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон нөөцийн бараа, материал хэрэгцээтэй үед хангах компаниуд нь ихэвчлэн томоохон хангамжийн /Inventory/ компаниуд байна. Өөрөөр хэлбэл угаас агуулахад бараа хадгалах шаардлагагүй өөрөө үйлдвэрлэгч буюу байнга их хэмжээний нөөцтэй байдаг компаниуд байна.

Орон нутгийн нөөц гамшгийн бэлэн байдлыг хангаж байгаа эсэх нь гамшиг, аюулт үзэгдлийн үед хүний амь насыг аврах, эрүүл мэндэд яаралтай тусламж үзүүлэх, хооллох, ундны усаар хангах, хөнжил гудас, хуурай дулаан хувцсаар хангах, майхан зэрэг түр орон байр, нэг бүрт хүрч үйлчлэх боломжоор илэрхийлэгдэнэ. Орон нутгийн нөөцийг шаардлага хангасан түвшинд бэлтгэсэн болон бэлэн нөөцөлсөн, эсхүл тухайн үед бэлэн гаргуулах үүргийг даалгасан байдлыг тогтмол шалгаж ажилладаг тогтолцоог бүрдүүлжээ.

Стратегийн нөөцийн талаар

Улсын нөөцийн тухай хуульд нөөцийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.2, улсын нөөцийн ангилал /4.1/-аас гадна 6.1 дэх хэсэгт “стратегийн нөөцийн бараа материалыг Засгийн газраас тогтоосон байршил, тоо хэмжээ, нэр төрлийн хэмжээнд бүрдүүлэх ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна” гэжээ. Хуулийн бусад зүйл, заалтуудад улсын нөөцтэй холбоотой харилцаанд эрх бүхий субъектийн эрх хэмжээг л тодорхойлон зааж ялангуяа стратегийн бараа, материалын талаар хуульчлан тогтоосон хэм, хэмжээ, стандарт, баримтлах шаардлага байхгүй байна. Тийм учраас стратегийн бараа, материалыг сонгож нэр төрөл, тоо хэмжээг тогтоож байгаа, мөн байршлыг сонгож байгаа үндэслэл, арга зүйг нь тодорхой болгох шаардлагатай.

“Стратегийн нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материалыг” гэж, харин Хүнсний тухай хуулийн 3.1.6-д **“”стратегийн хүнс”** гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг,” ойлгоно гэж тус тус тодорхойлсон.

Энэ утгаар нь авч үзвэл Улсын нөөцийн тухай хуульд стратегийн нөөцийг Хүнсний тухай хууль болон бусад хуультай уялдуулан томъёолох, мөн хуульд нэр томъёоноос гадна онцлог зохицуулалт, шаардлага, процедурыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэхээр байна.

Улсын Их Хурлаас стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийн жагсаалтыг 2 удаагийн шийдвэрээр¹⁸ 5 нэрийн 33 төрөлд баталсан байна. /1-рт, Хүнсний бараа, 2-рт, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, 3-рт, Түүхий эд, 4-рт, Шатахуун, тосолгооны материал, 5-рт, Хүний эм, багаж хэрэгсэл./

Хуульд стратегийн нөөцийн нэр төрлийг батлах эрхийг УИХ-д өгсөн боловч тэдгээрийг батлуулах ажлыг зохион байгуулахдаа “стратегийн нөөц”-д бараа, материалыг тооцохдоо ямар хуулийн журамласан хэм хэмжээ, ямар шалгуур шаардлагыг баримталж байгаа нь тодорхойгүй байна.

Хуулийн хэрэгжилтийн практик дээр ОБЕГ-аас улсын нөөцийн бараа, материалыг гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд гаргахад гамшгийн болон стратегийн нөөцөөс аль алинаас нь зарцуулдаг байна. Энэ нь нэг талаас хуульд заасан улсын нөөцийн ангилалд судалгаа шинжилгээний үндсэн дээр нөөцийн бараа материалын нэр төрлийг тогтоож бүрдүүлдэггүй, нөгөө талаас, улсын нөөцийн бараа, материалыг зарцуулах үйл ажиллагааны удирдлага менежментийн оновчтой, зохистой тогтолцоог бүрдүүлээгүйг илэрхийлж байна.

Нөөцийн бараа материалын онцлог нь зориулалтаар ашиглахад чиглэсэн, үүний тулд судалгаа шинжилгээнд суурилсан байдаг байна. Гадаад орнуудын туршлагаас үзэхэд нөөцийн бараа материалыг ангилал, улсын болон орон нутгийн нөөцийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд бүрдүүлж бэлэн байдлыг хангах, тэдгээр нөөцийн бараа материал шаардлага үүсэн тохиолдолд ашиглагдах, дутагдах, дуусах тохиолдолд дараагийн нөөц ашиглахаар эрх зүйн болон үйл ажиллагааны удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна. /АНУ, БНХАУ, Япон зэрэг орны туршлагыг гадаад орнуудын хэсгээс үзнэ үү /

Өөрөөр хэлбэл улсын нөөцийн барааг бүрдүүлэхдээ шинжлэх ухааны ямар арга зүй ашиглаж байгаа нь тодорхой бус, ОБЕГ-ын ажилтнуудын туршлага дээр суурилж байгаа нь хэт субъектив хандлагатай байна гэж судлаачид үзлээ.

Батлан хамгаалах материаллаг нөөцийн талаар

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 3.1.9-д “**“батлан хамгаалах материаллаг нөөц”** гэж цэргийн материал хэрэгслийн хэрэгцээг тайван цагт болон дайны байдлын үед хангах зориулалт бүхий нөөц” гэжээ. Мөн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар Засаг дарга нь “тайван ба дайны үед хүн амын зайлшгүй хэрэгцээнд шаардагдах гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;” үүрэгтэй гэж заасан.

Харин Улсын нөөцийн тухай хуулийн 16.1.1-т орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж хяналт тавих, 16.1.2-т улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн заалттай уялдахгүй, эрх мэдлийн давхцал, ойлгомжгүй хоёрдмол үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгосон төдийгүй, Засаг даргын эрх хэмжээгээ хэрэгжүүлэх процедур тодорхой бус байна. Нөгөө талаас Монгол Улсын батлах хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 хэсэгт “тайван ба дайны үед хүн амын зайлшгүй хэрэгцээнд шаардагдах гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;”-ыг Засаг даргын үүрэг болгосон нь “хүн

¹⁸ “Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 30 дугаар тогтоол, “Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөлд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2011 оны 42 дугаар тогтоол

амын зайлшгүй хэрэгцээнд” гэсэн тодорхойгүй хуульчлагдаагүй ойлголтыг ч үүсгэж байна.

Түүнчлэн гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж хадгалах, хамгаалах үүргийг хүлээнэ гэдэг нь Улсын нөөцийн тухай хуульд заасан орон нутгийн нөөцөөс хэрхэн ялгагдах тийнхүү хадгалж буй нөөцийн талаар нэгдсэн удирдлага хяналт хаана ямар субьектэд харьяалагдаж байгаа нь тодорхойгүй байна. /Орон нутгийн нөөцийн талаар тайлангийн 3.4 дэх хэсэг буюу Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үр дүн хэсгээс танилцана уу/. Гэвч Улсын нөөцийн тухай хуулиар батлан хамгаалах нөөцийг зохицуулах үүрэггүй тул энэхүү судалгаагаар дүгнэлт хийх боломжгүй гэж үзлээ.

Гамшгийн нөөцийн талаар

Улсын нөөцийн тухай хуульд “**гамшгийн нөөц**” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.7-д “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг” ойлгоно гэж тус тус заасан байна.

ОБЕГ болон улсын нөөцийн асуудал хариуцсан УНГ нь гамшгийн нөөц бүрдүүлэх, нөхөн бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, түгээх ажлыг зохион байгуулж байгааг одоо ажиллаж байгаа бүтэц зохион байгуулалт, орон тоондоо хуулийг зохих түвшинд хэрэгжүүлж байгааг нотолж байна.

Гэсэн хэдий ч гамшгийн нөөцийн нэр төрөл, түүний байвал зохих хэрэгцээг /нэр төрөл, тоо хэмжээг/ тодорхойлоход хууль, эрх зүйн үндэслэл, шинжлэх ухааны судалгааны арга зүй, дүн шинжилгээ дутмаг байгаа нь харагдаж байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс үйл ажиллагааны шинэчлэл хийх нь зүйтэй.

Гадаад орнуудад гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг хадгалах байршлыг тогтоох зэрэгт мэргэжлийн байгууллагуудын оролцоотой судалгаа шинжилгээнд тулгуурлаж байна.

Тухайлбал, Гүрж улсын нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Улсын нөөц болгон хуримтлуулах бараа, материалын жагсаалтыг Улсын нөөцийн газар нь *Эдийн засаг, тогтвортой хөгжлийн яамтай зөвшилцөн гаргаж*, Засгийн газраар батлуулахаар өргөн барина гэжээ. Түүнчлэн улсын нөөцөд бараа, материал хуримтлуулах буюу нөөц бүрдүүлэх зардлыг жил бүр улсын төсөвт тусгайлан батална гэж хуульчилсан.

Улсын нөөцийн тухай хуульд гамшгийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг ямар аргачлалыг баримталж хэрхэн тодорхойлох талаар зохицуулах нь цаашид анхаарах асуудлын нэг юм.

Нөөцийн бараа, материалыг хадгалах талаар

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “нөөцийн бараа материалыг хадгалах” гэж худалдан авсан буюу буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулахыг хэлнэ гэж томъёолжээ.

Улсын нөөцийн барааг хадгалах гэдэгт практик дээр нөөцийн барааг агуулах /хашаа, тусгайлан бэлтгэсэн талбай/-д хүлээн авснаас эхлэн түүнийг технологийн горимын дагуу арчлан хамгаалах, тухайлбал сэлгэх, цэвэрлэгээ үйлчилгээ хийх,

засварлах, хатаах, өрөх, ачих буулгах, бараанд үзлэг шалгалт хийх зэрэг олон ажлыг хамруулсан өргөн цар хүрээтэй ажлыг гүйцэтгэж байна.

Өнөөдрийн байдлаар аймгуудын онцгой байдлын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжид багтсан улсын нөөцийн салбарууд улсын нөөцийн бараа, материалыг хадгалах ажлыг эрхлэн гүйцэтгэхдээ дээр дурдагдсан үйл ажиллагааг явуулах бүтэц, орон тоо, хүн хүчний болон үйл ажиллагааны зардал хязгаарлагдмал хүрэлцэхгүй байгаа нь хуульд энэ талаар нарийн зохицуулалт шаардлагатайг илэрхийлж байна.

Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, стандарт, хадгалалтын технологийн мөрдөлтөд холбогдох төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина” гэсэн боловч нөөцийн бараа, материалыг хадгалах агуулах /хашаа, тусгайлан бэлтгэсэн талбай/ саванд тавигдах стандарт байхгүй, мөн тийм стандарт, технологийн горим, журмыг хаанаас хэн тогтоох талаар хуульд зохицуулалт байхгүй байна.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8-д “нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг...” Засгийн газар батлахаар заажээ. Үүний дагуу Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам” баталсан. Гэвч уг журмын нөөцийн бараа, материалыг хадгалах хэсэгт 6 зүйлийн зохицуулалт байгаагаас тал нь хуульд заасан зохицуулалтыг давхардуулан бичсэн нь эрх зүйн журмын зохицуулалтын шаардлагыг хангахааргүй байна.

Энэ нь практик дээр нөөцийн бараа материалыг хадгалах, шинэчлэх ажлыг мэдээллийн сангийн зориулалтын програмд суурилж технологийн түвшинд зохион байгуулдаггүй зөвхөн дээр дурдсан журмын шаардлага болох эрх зүйн хэм хэмжээний үг хэллэг заалтаар үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байна.

Улсын нөөцийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд нийцүүлэн гаргасан журам, зааврууд нь дийлэнхдээ эдгээр хуульд бичигдсэн зохицуулалтыг хуулбарлан дахин бичсэн байна.

Цаашид улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, гамшиг, онцгой байдлын үед ашиглахад шаардлага хангасан нөөцөлсөн бараа, материалтай байх үүднээс эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай.

Гадаад орнуудын хууль эрх зүйн бичиг баримтуудыг судалж үзэхэд нөөцийн бараа материалыг хадгалах үйл ажиллагаанд тухайн улс орны агуулахын стандарт болон олон улсын нийтлэг стандартад нийцүүлэн технологи горимыг дагаж мөрдөж байна. Тэгэхдээ гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд ашиглах нөөцийн зорилго, шаардлагаас хамаарч нөөцийн бараа материалыг удаан хугацаанд хадгалж, гамшгийн бэлэн байдлыг хангах учиртай тул хэд хэдэн стандартууд жишиг болон тогтжээ.

Нөөцийн бараа, материалыг агуулахад хадгалахад **Inventory Rotation- FEFO and FIFO standard** болон **Regular audits, Training and Protocols** жишиг болон тогтсон арга зүй, стандартуудыг ашиглаж байна.

FEFO- гэдэг нь **First-Expiry, First-Out** гэх англи үгний товчлол бөгөөд хадгалагдаж буй бараа, материалыг хадгалагдах хүчинтэй хугацаагаар дата үүсгэж эхэлж хугацаа нь дуусах бараа, материалыг түрүүлж агуулахаас гаргах (*Энд нөөцийн бараа, материалыг шинэчлэх зорилгоор болон улсын нөөцийн тухай хуульд заасан*

ашиглалтын зорилго, нөхцлийн дагуу захиран зарцуулахдаа баримтлах гэсэн үг) зарчмаар дижитал мэдээллийн программаар удирдах үйл ажиллагаа,

FIFO- гэдэг нь **First-In, First-Out** гэх англи үгний товчлол бөгөөд агуулахад эхэлж орсон бараа, материалыг агуулахаас гаргахад түрүүлж гаргах, агуулахын тавиур зэрэг байрлалд эхэлж орсон бараа, материалыг гаргах тээвэрлэхэд боломжтойгоор ойр байрлуулах буюу шинээр орсон бараа, материалыг цаана хадгалах стандарт горим,

Regular audits - Нөөцийн бараа, материалыг хадгалах, журам зааварт заасны дагуу, дээр дурдагдсан стандарт болон бусад арчилгаа стандартууд хэвийн мөрдөгдөж байгаа эсэхийг шалгах ажиллагаа ба илэрсэн зөрчлийг тухай бүр шийдэх, шалгалтын болон зөрчил арилгасан тухай дата-г тогтмол үүсгэж, програм дээр түүх үүсгэж ажиллахыг,

Technology Integration - нөөцлөгдөж буй барааг хадгалах хугацаа, нэр төрөл, байрлал, зарцуулагдсан тухай болон үлдэгдэл зэрэг олон үзүүлэлтээр гаргах дижитал програм хангамж, энэхүү программ хангамжийн тусламжтайгаар бараа, материалыг хадгалалт болон бусад шаардлагатай үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж мэдээлэл боловсруулах, хэрэглэх технологийн интеграци,

Training and Protocols гэдэг нь Нөөцийн бараа, материалыг хадгалах үйл ажиллагааны менежментийн журам, зааврыг боловсронгуй болгох, ажилтан, албан хаагчдыг сургах, дадлагжуулах зэрэг болно.

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ судалгаа хийх ажлын хүрээнд гадаадын зарим орны тэргүүн туршлага болохуйц мэдээллийг харьцуулан судлаж зарим шаардлагатай гэсэн хэсгийг түүвэрлэн оруулсан болно.

Харин манай улсын нөөцийн тухай хуульд нийцүүлэн гаргасан улсын нөөцийн бараа, материалыг хадгалах, шинэчлэх, сэлгэх үйл ажиллагааг зохицуулж буй журмууд нь хуульд заасныг давхардуулан бичсэн, хэт ерөнхий байгаа нь хуулийн эдгээр зохицуулалтын хэрэгжилт сул байгааг илэрхийлж байна.

ОХУ-ын “Холбооны нөөц материалын тухай хуульд”¹⁹ нөөцийн барааг хадгалах гэдэгт “...холбооны нөөцийн чанар, аюулгүй байдлыг хангаж...” хэмээн бараа, материалыг хадгалахтай хамт зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг цар хүрээг бүрэн гүйцэд тодорхойлжээ. Энэ нь “хадгалах” гэдэгт арчлах, засвар үйлчилгээ зэрэг олон төрлийн ажил хамрагдахыг харуулж байна.

Улсын нөөцийн тухай хуульд нөөцийн бараа, материалыг “хадгалах” гэх нэр томъёонд нэмэлт, өөрчлөлт оруулах, “стандарт, технологийн шаардлага хангасан агуулах” гэж юу болохыг шинээр тодорхойлох, хуулийн зохицуулах зүйл, хэсгүүдэд нөөцийн барааг хадгалах журмын шаардлагыг нарийвчлан тогтоох, хадгалах үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийн эрхийг хуульчлан тусгах шаардлагатай гэж үзлээ.

¹⁹ ОХУ-ын Улсын нөөцийн тухай /байгууллагын үүсэл/ хөгжил 15 дугаар зуунаас эхлэлтэй. ОХУ 1994 оны 11 дүгээр сарын 23-нд Улсын нөөц материалын тухай хуулийг баталж, 1999 онд Улсын нөөцийн агентлагийн байгуулжээ. 2004 онд ерөнхийлөгч /Путин/-ийн санаачилгаар холбооны улсын нөөцийн тухай шинэчлэл хийгдэж ОХУ-ын Худалдаа хөгжлийн яамны харьяанд Холбооны улсын нөөцийн агентлагийг шинэчлэн зохион байгуулсан байна.

Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж буй алба хаагчид “нөөцийн бараа, материалыг ихэвчлэн хадгалах хугацаанаас шалтгаалан шинэчилдэг, зарим удаан хадгалах нөөцийн чанар байдлыг харгалзан сонгоход эргээд худалдан борлуулахад цаг үеийн шаардлага, техник технологийн хөгжлөөс хоцрогдох зэргээс шалтгаалан үнэ буурах хүндрэл бэрхшээл учирдаг” гэж байлаа.

Нөөцийн бараа, материалыг шинэчлэх талаар

Хуульд “нөөцийн бараа, материалыг шинэчлэх” гэж нөөцийн бараа, материалыг хадгалах хугацаа, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн борлуулж, нөхөн бүрдүүлэхийг хэлнэ гэж заажээ.

Нөөцийн барааг шинэчлэхтэй холбоотой үйл ажиллагааг журамлаж нарийвчлаагүй ч хуулийн 13.1.8-д “нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг батлахыг Засгийн газарт даалгажээ. Энэ заалтыг хэрэгжүүлэн ЗГ-ын 2008 оны 199 дүгээр тогтоол /2 дугаар хавсралт/-оор журмыг баталжээ.

Гэвч уг журмаар нөөцийн бараа, материалын ангилал тус бүрд тохирсон зохицуулалт хийгдээгүй байна. Практик дээр нөөцийн бараа, материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулахад тухайн бараа, материалын зах үнийн өсөлт, бууралт, мөнгөний ханш зэрэг эдийн засгийн хүчин зүйл нөлөөлөхөөс гадна ялангуяа удаан хугацаанд хадгалах автомашин, техник хэрэгслийн хувьд хүндрэлтэй хэвээр байна.

ОБЕГ нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээд биш тул хадгалагдаж буй бараа, материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулахад НӨАТ үнийн дүнг хасаж тооцоход хүрч байна. Энэ нь нөөцийн барааны анхны худалдан авсан үнэ буурч, зөрүү гарах нь ялангуяа нефть, шатах тослох материал дээр гарч байна.

Нөөцийн бараа, материалыг шинэчлэх ажлыг тогтмол зохион байгуулж байгаа боловч ОБЕГ /хэрэгжүүлэгч нэгж нь УНГ/-т мэргэжлийн эдийн засагч, худалдааны мэргэжилтэн байхгүй нь хуулийн энэ зохицуулалт зохих ёсоор хийгдэж байна гэж дүгнэхэд учир дутагдалтай.

Нөөцийн бараа, материалыг шинэчлэх асуудал /нөөцийн бараа материалын хэрэгцээг тодорхойлон нэр төрөл, тоо хэмжээ тогтоох мөн адил/ нь цогц менежментийг шаардахаар байна. Тийм ч учраас зарим улсад нөөцийн асуудал хариуцсан агентлагийг худалдааны эсвэл эдийн засгийн яаманд харьяалуулан байгуулдаг ажээ. Улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх асуудалд, хөрөнгөөс гадна, шинэчлэх үйл ажиллагааг цогцоор нь харж тухайлбал, шинэчлэх шаардлагаар улсын нөөцөөс бараа материалыг гаргахад худалдааны менежментийн цогц шийдэл хайх шаардлагатай болжээ.

Нөөцийн бараа материалыг сэлгэх талаар

Хуульд “нөөцийн бараа, материалыг сэлгэх” гэж нөөцийн бараа, материалыг агуулах, талбайд хадгалах технологийн горимыг үндэслэн шилжүүлэн байршуулах гэж тодорхойлсон боловч нөөцийн барааг сэлгэх ажиллагааг журамлаагүй байна.

ЗГ-ын “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам”²⁰-ын дөрөв дэх хэсэгт “Нөөцийн барааг, шинэчлэх, сэлгэх”-ийг зохицуулсан. Өөрөөр хэлбэл, хуульд нөөцийн бараа, материалыг **сэлгэх** журам гаргах талаар заагаагүй боловч нөөцийн бараа, материалыг сэлгэх асуудлыг Засгийн газрын уг журамд **шинэчлэх-тэй** хамт журамласан байна. Гэхдээ мөн л сэлгэх асуудлын талаар журам-процедурыг хангалттай гаргаагүй зөвхөн бусдад үүрэг болгосон заалт л тусгагджээ. Ингэснээр эрх зүйн хувьд уг журам агуулгын болон процессын хэм хэмжээний дутагдалтай болжээ.

Практик дээр улсын нөөцийн салбарын харуул, нярав гэх цөөн тооны ажилтнууд бараа материалын чанар байдлыг алдагдуулахгүйн үүднээс өөрсдийн хүчээр ямар нэгэн санхүүжилтгүй, цалин хөлсгүй хийж гүйцэтгэж байгаа нь сэлгэх ажиллагааны зардлыг тусгасан хуулийн зохицуулалт, нарийвчилсан журам нэн шаардлагатайг илэрхийлж байна.

Улсын нөөцийн барааг буюу тусгай зориулалтаар нөөцлөн хадгалж буй бараа агуулахын стандарт журмыг боловсруулан батлан ажиллах нь хуулийн шинэ зохицуулалт шаардахгүй. Харин нөөцийн барааг сэлгэх үйл ажиллагааны зардал гаргах эрхийг хуульчлан өгвөл цаашид үйл ажиллагаагаа энэ асуудал дээр хөгжүүлэх, зохих ёсоор хэрэгжүүлэхэд хэрэгтэй.

Гадаад орнуудад нөөцийн бараа, материалыг нөөцлөн хадгалах, тэдгээрийг арчлан сэлгэх, чанар стандартыг алдагдуулахгүй байлгах нь үйл ажиллагааны стандарт журмаар зохицуулагдаж байна. Нөөцийн бараа материал нь гамшиг, аюулт үзэгдэл тохиолдол бий болоогүй нөхцөлд мэдээж эдийн засгийн агуулгаараа зардал өндөртэй хэдий ч гамшиг тохиолдсон үед хүний амь, нас эрүүл мэндийг цаг мөчтэй уралдан хамгаалах, хүн амын амьжиргааны наад захын шаардлага хангахуйц яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг өргөн утгаараа ямагт бэлэн байх, үүсэн буй болох хэрэгцээ бүрт найдвартай бэлэн байх ёстой.

Гадаад орны туршлагаас үзэхэд нөөцийн бараа, материалыг агуулахад хадгалагдаж байх үед арчлах сэлгэх ажлыг технологийн дагуу үйл ажиллагааны стандарт журмуудаар зохицуулж байна.

Нөөцийн бараа, материалыг сэлгэх ажилд **FULO, SURR, PRR, CRU** зэрэг аргачлалд суурилж сэлгэх үйл ажиллагааны журмаа боловсруулан баталж байна. Хамгийн сонирхолтой нь эдгээр журмууд нь ердийн байгууллагын буюу агуулахын үйл ажиллагаанд зориулагдан боловсруулж ердөө байгууллагын дарга баталж байгаа гэдгийг хаана, хаанаа анхаарвал зохилтой.

FULO- First Used, Last зарчим нь хадгалах хугацаа шаардлагагүй бараа, материал дахь шинж чанар, хадгалалтын процесст өөрчлөлт өгч байгаа эсэхээс шалтгаалан тэнцвэржүүлэх арга хэрэглэн, эхэлж агуулахаас гаргах, сүүлд гаргах дотоод зохион байгуулалтын менежмент дээр суурилан бараа, материалыг сэлгэх ажиллагаа зохион байгуулах,

SURR- Сэргээж сэлгэх ажлыг тогтмол хугацаатай хийх. Энэ ажилд бараа, материалын байрлалыг солих, нэг байран дээр нь дээш доош харуулах сэргээх сэлгэх зэрэг ажил хамрагдана,

²⁰ Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан.

CRU- Check-Rotate-Update. Бараа, материалд үзлэг шалгалтыг явуулах, биет байдлаар үзлэг хийж, сэлгэх ажиллагааг хийх, программд шинэчлэл хийх, бүртгэлийг сэргээн идэвхжүүлэх зэрэг ажлууд хамрагдана.

PRR- Periodic Rotation Rule гэдэг нь хугацаагаар бараа материалыг сэлгэх аргачлал юм. Энэ аргачлалаар бараа, материалыг өдөр, бүр, долоо хоног бүр, сар бүр гэх мэтчилэн хугацаа өгч сэлгэх ажлыг хийхийг хэлэх ба хадгалах хугацаа шаарддаггүй бараа, материал дээр ч хэрэгжүүлдэг байна.

Судалгааны багаас жишээ болгон нөөцийн барааны сэлгэх журмын “загвар”-ыг **/PRR- Periodic Rotation Rule/** боловсруулав.

ХҮНСНИЙ НӨӨЦИЙГ ХУГАЦААГААР СЭЛГЭХ ЖУРАМ

Лавлах код: SOP-FD-PRR-001

Хэрэглэх хүрээ: Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед улсын нөөцийн тухай хуулийн 5.1.1, 9.12т заасан нөхцлөөр

Агуулахад хүлээн авсан: огноо

Хянан шалгасан: огноо

001. Зорилго

Энэхүү үйл ажиллагааны журам (SOP)-ын зорилго нь хүнсний нөөцийг тогтмол хугацаагаар сэлгэх зохион байгуулалттай процессыг тогтоох явдал юм. Энэ нь хуучин нөөцийг эхэлж хэрэглэхийг шаардлагад суурилан хадгалалтын стандартын горимыг хангаж, чанар, болон гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үүрэгтэй.

002. Хамрах хүрээ:

Байнга хадгалах буюу түргэн муудахгүй хүнсний зүйлс (лаазалсан хүнсний хуурай бүтээгдэхүүн хатааж савласан хүнс гэх мэт

Гамшгийн бэлэн байдлын нөөцийн зориулалтаар хадгалагдаж байгаа бараа, материал.

003. Бараа, материалын тодорхойлолт

004. Хугацаагаар сэлгэх /технологийн тодорхойлолт/

005. Бараа, материалыг сэлгэх /энэ журамд сэлгэх ажиллагааны тодорхойлолт/

006. Бараа, материалыг сэлгэх журам /Дэг горим, процедур/

007. Хугацаагаар сэлгэх журамд тусгасан процедурын үе шатууд

008. Нэмэлт мэдээлэл:

FEFO зэрэг стандартын бусад ангилалаар програмд шилжилт хийлгэх, барааны бүртгэлийн дугаар, өөрчлөгдсөн эсэх

009. Ашиглагдах маягт

Нөөцийн бүртгэлийн хуудасны загвар

PRR сэлгэлтийн шалгалтын хуудас

Хүнсний чанарын шалгалт дүгнэсэн маягт

010. Хяналт ба Шинэчлэлт

Энэхүү SOP нь жил бүр хянагдаж, хүнсний нөөцийн хадгалалтын зааварт болон нөөцийн менежментийн практик шинэчлэгдэх тохиолдолд бүрт шинэчлэгдэх ёстой. Энэхүү журмын хэрэгжилтийн үе шат болгоны мэдээлэл болон шинэчлэгдсэн мэдээлэл, мэдээлэл шинэчлэгдэх шалтгааныг Дата-нд тусгана.

Улсын нөөцийн салбарын талаар

Хуулийн 3.1.8-т “Улсын нөөцийн салбар” гэж нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх үүргийг холбогдох шийдвэрээр гүйцэтгэгч байгууллагыг хэлнэ гэж бие даасан буюу байгууллагын түвшинд авч үзсэн.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42.2, 42.3 дахь хэсэгт “Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна”, мөн “Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-логистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.” гэж тус тус заасан.

Онцгой байдлын байгууллагын зохион байгуулалтын бүтэц Гамшгаас хамгаалах тухай хуульд суурилан өөрчлөгдсөнөөр Улсын нөөцийн тухай хууль зөрчигдсөн шинжтэй болжээ.

Улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөн хөгжүүлэх, хүрсэн түвшингээс жилээс жилд ахиулахад УНГ-ыг захиргааны болон санхүүгийн удирдлага зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх хэрэгтэй байна. Байвал зохих хүчин чадал, менежментээр ажилласны эцэст дараагийн төрөлжсөн нөөцийг бүрдүүлэх, хууль, эрх зүйн зохицуулалтыг ч шинэчлэн найруулах, эсхүл нөөцийн багц хуультай болгох эсэх асуудал яригдах учиртай нь энэ судалгаагаар харагдаж байна.

Гэрээт хадгалагчийн талаар

“Гэрээт хадгалагч” гэж нөөцийн бараа, материалын хадгалалтын онцлог нөхцөлөөс шалтгаалан технологийн дагуу *хадгалах, сэлгэн шинэчлэх* үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг” ²¹ гэж заасан.

Улсын нөөцийн зарим бараа, материалыг хадгалах үүргийг хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх нь энэ хууль болон бусад хуулиудад нийцэж байна. Харин практик дээр “*сэлгэн шинэчлэх*” гэх шинэ ойлголтыг бий болгожээ. Хуульд зааснаар “сэлгэх” гэснийг “нөөцийн бараа, материалыг агуулах, талбайд хадгалах технологийн горимыг үндэслэн шилжүүлэн байршуулахыг”, харин “шинэчлэх” нь “нөөцийн бараа, материалыг хадгалах хугацаа, холбогдох хяналт шалгалт хэрэгжүүлэх байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн борлуулж, нөхөн бүрдүүлэхийг” гэсэн хоёр өөр үйл ажиллагааны тодорхойлолт юм. */Нөөцийн бараа, материалыг сэлгэх талаар дээр дурьдсаныг үзнэ үү/* Мөн ямар тохиолдолд гэрээт хадгалагчид улсын нөөцийн бараа, материалыг хадгалуулах үндэслэл үүсэх, нөөцийн бараа, материалыг хадгалах агуулах, хашааны стандартыг тодорхойлох шаардлагатай.

Нөөцийн бараа материалыг хадгалах байршлыг гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын судалгаа шинжилгээнд тулгуурлаж тогтоох, түүний тавигдах шаардлагыг хууль, эрх зүйн бусад актаар тодорхой зааж өгөөгүй нь нөөцийн бараа,

²¹ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.”

материалын бүрдэл, бэлэн байдлыг хангах, шаардлагатай үед тэдгээрийг яаралтай түгээх боломжийг хангаж байгаа эсэх нь тодорхой бус байна. /Энэхүү судалгаа үнэлгээнд нууцад хамаарах мэдээлэл ороогүй, зөвхөн ил мэдээлэлд хийсэн/ Гэрээгээр бараа, материалыг хадгалуулахдаа зөвхөн “хадгалалтын онцлог нөхцөлөөс шалтгаална” гэсэн ерөнхий шалгуурыг тавьсан нь ашиг сонирхол үүсэх боломжийг нээх магадлалтай гэж үзэж болохоор байна. Нөгөө талаас улсын нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэгч гол субъект болох онцгой байдлын байгууллагын мэдэлд улсын нөөцийн агуулах, хашаа зэрэг бусад байгууламж нь дутагдалтай, гамшгийн эрсдлийн судалгаа шинжилгээнд суурилж, мөн газар зүйн байрлал, түгээгдэх дэд бүтцийн чадавхид тулгуурлаж буй болдоггүй, уламжилж ирсэн объект байрлалыг түшиглэдэг бол түүнийг бодлого, эрх зүйн хувьд шинэчлэн сайжруулвал зохилтой.

Улсын нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “нөөцийн бараа, материалыг хадгалах, стандарт, технологийн шаардлага хангасан агуулах бүхий хуулийн этгээдэд /цаашид “гэрээт хадгалагч” гэх/, гэрээний үндсэн дээр хадгалуулж болох бөгөөд энэхүү хадгалуулах нөөцийн бараа материалын жагсаалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан. Шадар сайдын 2008 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтаар “Бараа, материалын хадгалах стандарт, технологийн онцлог, нөхцлийг харгалзан гэрээт байгууллагад хадгалуулах барааны нэр төрлийн жагсаалт”-ыг баталжээ.

Гэтэл Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор “нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам болон гамшгийн нөөцөөс бараа, материалыг захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх” журмыг тус тус хавсралтаар баталсан байх ба “нөөцийн бараа материалыг хүлээн авах хадгалах” журмын 3.2-т “улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллагад хадгалах барааны жагсаалтыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно” гэж заасан нь улсын нөөцийн тухай хуулийг зөрчиж байна.

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ХЭСГЭЭС

...Улсын нөөцийн бараа, материал бүрдүүлэх зорилгоор тодорхой хэмжээний үнийн дүн бүхий цэвэр усыг худалдан авч хадгалалтын горимыг баримталж нийлүүлэгч талд хадгалуулсан, хадгалалтын явцад дотоод хяналт хийхэд бараа, материал тоо ёсоор байдаг байсан. Гэтэл уг хуулийн этгээд гэнэт үйлдвэрээ хаагаад эзэд нь гадаад улс руу явсан байсан. Онцгой байдлын ерөнхий газраас зохих байгууллагад хандаж уг этгээдийг эрэн сурвалжлуулсан боловч одоог хүртэл олдоогүй, хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй байгаа...

Дээр дурдагдсан судалгааны хэсгээс үзвэл нөөцийн бараа, материалыг гэрээгээр хадгалуулах, хадгалах асуудлын хууль, эрх зүйн зохицуулалт, стандарт, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатай.

Хадгалагдаж буй нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, бүрэн хангагдаж гамшгийн бэлэн байдлыг хангах нь чухал гэдгийг онцлон дурдах нь зүйтэй.

3.4 Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Улсын нөөцийн ангилал, түүний хэрэгжилтийн үнэлгээ

4.1. Улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн гэж ангилна.

4.2. Орон нутгийн нөөцөд тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах аймаг, нийслэл, сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагад байх нөөцийг хамааруулна.

~~4.3. Цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулах үүргийг холбоодох хууль тогтоомжийн дагуу батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.~~
~~/Энэ хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар улсын нөөцийг:

1. Стратегийн нөөц;
2. Батлан хамгаалах материаллаг нөөц;
3. Гамшгийн нөөц;
4. Орон нутгийн нөөц гэж 4 төрөлд ангилжээ.

Хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн нөөц гэж “бараа, материал, хэрэгсэл”-ийг тодорхой зааж өгсөн боловч “орон нутгийн нөөц” гэж юу болохыг тодорхойлж өгөөгүй байна.

Хуулийн 4.2-т тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах аймаг, нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагад байх нөөцийг хамааруулна гэж заасан. Хуулийн энэ заалтаар аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, хэрэв шийдвэрээ гаргасан бол тэрчлэн аж ахуйн нэгж, байгууллага хүртэл нөөц бүрдүүлэх үүрэг хүлээхээр байна. Хэдийгээр тус хуульд орон нутгийн нөөц байхаар заасан боловч Засаг даргын шийдвэрээр бүрдүүлсэн нөөцийн бараа, материал улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын бүртгэлд байхгүй энэ асуудлыг хариуцахгүй байна. Практик дээр тухайн аймагт байрлах улсын нөөцийн салбар дахь нөөцийн бараа, материалыг орон нутгийн нөөц гэж ойлгодог хэсэг ч байна.

Судалгааны явцад /судалгааны баг ажилласан Говьсүмбэр, Дархан-Уул аймаг/ удирдлагын шийдвэрээр малын өвс, тэжээл бэлтгэдэг нь харагдаж байсан хэдий ч судалгаанд хамрагдах объект биш тул энэ асуудлыг орхисныг тэмдэглэж байна. Гэсэн хэдий ч Улсын нөөцийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн нөөцийн асуудал тодорхойгүй байхын зэрэгцээ Батлан хамгаалах тухай хуулиар үүрэг болгосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын бүрдүүлэх нөөцийн асуудлын нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг тодорхой болгон шийдвэрлэх гарцаагүй шаардлага үүсжээ.

Харин Улсын нөөцийн тухай хуулийн 14.1.3-т орон нутгийн нөөцийн тоо хэмжээ, нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтан /Засаг дарга/-тай зөвшилцөж тогтоох бүрэн эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хуулиар олгосноос үзвэл орон нутгийн нөөцийг аймаг, нийслэлийн Засаг дарга бүрдүүлдэг гэж ойлгогдохоор байна.

“Орон нутгийн өвсний нөөц бүрдүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 210 дугаар тогтоолоор “жил бүр нийт малын 30 хувийг 1 хоногт тэжээхээр тооцон орон нутгийн нөөц бүрдүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг”²² болгоод орон нутгийн нөөц өвсийг хадгалах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг мөн аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан байна. Үүнээс үзвэл орон нутгийн нөөцийг улсын нөөцөөс салангид ойлгож хэрэгжүүлж байна. Засгийн газрын дээрх шийдвэрээс өөр орон нутгийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр судалгааны явцад олдоогүй болно.

Дээр дурдагдсан байдлаас дүгнэвэл орон нутгийн нөөцийн асуудал нь УНГ-ын үйл ажиллагаанд хамааралгүй байна. Иймд “орон нутгийн нөөц” гэх асуудлыг цаашид боловсронгуй болгож хуульчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах асуудлыг тусад нь авч үзэх шаардлагатай.

Хуулиар “Стратегийн нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материалыг;

“Батлан хамгаалах материаллаг нөөц” гэж Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 3.1.9-д заасныг буюу цэргийн материал хэрэгслийн хэрэгцээг тайван цагт болон дайны байдлын үед хангах зориулалт бүхий нөөцийг;

“Гамшгийн нөөц” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг²³ ойлгохыг тус тус тодорхойлж өгсөн.

Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйл болон Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн нэр томьёоны хэсэг дэх дээрх тодорхойлолтуудыг үзвэл стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материал нь нэр, төрлөөрөө бус нөөцөлж буй зориулалтаараа ялгагдахаар хуульчлагдсан байна.

Нөөцийн бараа, материалын нэр төрөл, хэмжээ, байршлыг тогтоох, бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, зарцуулах эрх, үүрэг болгосон хуулийн зохицуулалтуудыг нөөцийн ангилал тус бүрээр хүснэгтээр үзүүлбэл:

Улсын нөөцийн ангилал	Нэр төрөл тогтоох	Хэмжээ тогтоох	Байршил тогтоох	Бүрдүүлэх	Хадгалах	Хамгаалах	Сэлгэх	Шинэчлэх	Тээвэрлэх	Зарцуулах
Стратегийн нөөц	УИХ	ЗГ	ЗГ	ОБЕГ УНСалбар	УНСалбар Гэрээт хадгалагч	УНСалбар	УНСалбар	УНСалбар	УНСалбар	УНСалбар
Гамшгийн нөөц	ЗГ	ЗГ	ЗГ	ЗГ ОБЕГ УНСалбар	УНСалбар Гэрээт хадгалагч	УНСалбар	УНСалбар	УНСалбар	УНСалбар	УНСалбар
Орон нутгийн нөөц	Шадар сайд	Шадар сайд	-	ЗГ	УНСалбар	УНСалбар	-	-	-	-

/Жич: Хүснэгтийн (-) тэмдэглэгээтэй хэсэг нь холбогдох хуулийн зохицуулалтгүй байгааг илэрхийлнэ/

Улсын нөөцийн бараа, материалын ангиллыг хуульд тодорхой заасан боловч тэдгээрээс батлан хамгаалах материаллаг нөөцийн харилцаа нь Монгол Улсын батлан хамгаалах тухай, Дайны байдлын тухай болон бусад холбогдох хуулиар зохицуулагдаж байна. Харин орон нутгийн нөөцийн асуудлыг хаана хэрхэн хариуцаж

²² Хавсралтад заасан аргачлалын дагуу сүм, дүүрэгт өвсний нөөц бүрдүүлэх тоо хэмжээг тооцон баталж мөрдүүлэх, цаашид жил бүр нийт малын 30 хувийг 1 хоногт тэжээхээр тооцон орон нутгийн нөөц бүрдүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

²³ Улсын нөөцийн тухай хууль 2007 он

байгаа нь тодорхойгүй байна. Иймд ОБЕГ-аас гамшгийн болон стратегийн нөөцийн асуудлыг хариуцан ажиллаж байна.

Улсын нөөцийн тухай хуульд заасан улсын нөөцийн ангиллаас хоёр төрлийн буюу Стратегийн болон гамшгийн нөөцтэй холбоотой тоо баримт, мэдээ, тайлан нь ОБЕГ-ын УНГ-т нэгтгэгдэж байна.

3.5 Улсын нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Улсын нөөцийн бараа, материалыг ашиглах зориулалт, хэрэгжилтийн үр дагавар

5.1.Нөөцийн бараа, материалыг дараахь зориулалтаар ашиглана:

5.1.1.гамшгийн хор уршгийг арилгах;

5.1.2.эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.14 дэх заалтад ““гамшгийн хор уршиг” гэж гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг;” гэж, 4.1.15 дахь заалтад ““гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-т заасан үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг;” гэж тус тус тодорхойлжээ.

Харин “эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх” ойлголт нь Гамшгаас хамгаалах тухай хуульд дараах байдлаар тусгагджээ. Үүнд:

1-рт, Хуулийн 4.1.19-д "гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;

2-рт, Хуулийн 4.1.24-д "бэлэн байдал" гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг;

3-рт, Хуулийн 10.4.9-д нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;

4-рт, Хуулийн 10.4.14-д эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн зохицуулалтаас үзэхэд улсын нөөцийн бараа, материалыг ашиглах талаар Нэгдүгээрт, Гамшгийн хор уршгийг арилгахад чиглэж хойшлуулшгүй ажиллагааны зорилгоор, Хоёрдугаарт, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад ашиглахаар хуульд эрэмбэлж заажээ.

Улсын нөөцийн бараа, материал хуульд заасан үндэслэл журмын дагуу эрх бүхий субъектийн шийдвэрээр ашиглагдаж байгаа боловч дийлэнхдээ гамшгийн

зориулалтаар буюу гамшгийн хор уршгийг арилгах, ган зуд, гал түймрийн аюул, болон үерийн улмаас хохирсон иргэд, орон нутагт, эсхүл онцгой нөхцөл байдалд ажилсан байгууллага, албан хаагчдын техник, хэрэгсэл зэрэгт зарцуулагджээ.

Улсын нөөцийн тухай хуулиар “эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх”-ийг эхний ээлжид эрэмбэлэн хуульчилсан боловч тус хуульд энэхүү эдийн засгийн тогтвортой байдалтай уялдаа холбоо бүхий хуулийн зүйл заалт, процессийн хэм хэмжээний зохицуулалт байхгүй байна.

Судалгааны баг Онцгой байдлын ерөнхий газрын УНГ-т хөтлөгдөж буй улсын нөөцийн бараа, материалын зарцуулалтын товч хүснэгтэн мэдээлэл /2017-2024/-тэй танилцаад дараах анхаарах зүйл байгааг судалгааны тайланд тусгалаа. Үүнд:

1. ОБЕГ-ын УНГ-ын алба хаагчид хариуцсан чиглэлийн дагуу улсын нөөцийн бараа материалын бүртгэлийг MS.Excel программ дээр хөтөлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэ нь нууцлал, аюулгүй байдал болоод өнөөгийн цаг үе, нийгмийн хөгжлийн шаардлагад үл нийцнэ гэж үзлээ. Учир нь өнөөдөр наад захын сүлжээ дэлгүүр, бөөний худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд өөрсдийн бараа бүтээгдэхүүн /нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, борлуулалтын хэмжээ зэрэг/-ий мэдээлэл бүхий программ хангамжийг иж бүрэн ашиглаж байна.
2. Улсын нөөцийн бараа, материалын нэр төрөл /стратегийн, гамшгийн, орон нутгийн/, тоо хэмжээ, байршил, нөөцөд авсан хугацаа, хадгалах хугацаа, хадгалагдаж буй хугацаа, сэлгэх шаардлагатай хугацаа, зарцуулалт зэрэг шаардлагатай мэдээллийг агуулсан улсын хэмжээний нэгдсэн цахим бүртгэл /программ/-ийг ОБЕГ, УНГ-аас үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зайлшгүй шаардлага нэн түрүүнд бий болжээ гэж дүгнэлээ. Энэ нь улсын нөөцийн бараа, материалын шилжилт хөдөлгөөн, зарцуулалт, хадгалалт хамгаалалтын байдалд УНГ-аас хяналт тавих, бүртгэл судалгааг үнэн зөв, нарийвчлан гаргах зэрэг олон төрлийн чухал ач холбогдолтой төдийгүй УНГ-ын цаашдын хөгжлийн чиг хандлагад нийцнэ. Нөгөө талаас энэ нь дараа жилийн гамшгийн болон орон нутгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг бодитоор тооцоолж гаргах үндэс суурь болох боломжтой юм.
3. Улсын нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д нөөцийн бараа, материалыг 1-рт “гамшгийн хор уршгийг арилгах”, 2-рт Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим, бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зориулалтаар ашиглана гэж заасан. УНГ-т хөтлөгдөж буй дээрх хүснэгтэн мэдээлэл /бүртгэл/-ээр зарцуулагдсан улсын нөөцийн бараа, материалын 43.5 хувийг төрийн байгууллагуудад олгожээ. Тодруулбал “**олгосон байгууллага**” хэсэгт “...засаг даргын тамгын газар”, “аймаг, сумын эмнэлгийн байгууллага”, “Хил хамгаалах газар, анги, нэгжүүд”, “цагдаагийн байгууллага, газар, хэлтсүүд”, “цэргийн анги, нэгтэл”, “ОБЕГ”, “ОБЕГ-ын анги, нэгжүүд”, “...аймгийн онцгой комисс” “... ЕБС” зэргээр бичигджээ. Дээрх төрийн байгууллагуудад улсын нөөцөөс олгосон бараа, материалын 69 хувь нь “автомашин” байжээ.
4. Төрийн байгууллагуудад “автомашин”-ыг улсын нөөцөөс ийнхүү олгож байгаа явдал нь улсын нөөцийн тухай хууль /5.1 зүйл: Нөөцийн бараа, материалын зориулалт/-д нийцэж байгаа эсэхийг цаашид анхаарах нь зүйтэй.

Судалгааны явцад цуглуулсан бичиг баримтад 2010 он “Агаарын тээврийн хэвийн үйл ажиллагаа тасалдсан 700.00 тонн”, 2011 он “Шатахууны хомсдол бий болсон 2,050.00 тонн”, 2012 он “Хангамжийг нэмэгдүүлэх 8200.00 тонн”, 2013 он “Газрын тосны газарт шилжүүлэх 400.27, 436.00 тонн” 2021 он “Шатахууны хомсдол 1510.00 тонн” гэж жагсаалтын хэрэглэгчийн, хүлээн авагчийн нэр хэсэгт тус тус тэмдэглэн улсын нөөцөөс газрын тосны бүтээгдэхүүнийг зарцуулсан нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд чиглэгджээ. ЗГ-аас гаргасан улсын нөөцийг зарцуулах, нөхөн бүрдүүлэх бусад шийдвэрүүд нь гамшгийн хор хохирлыг арилгах, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай холбоотой байна. Иймд улсын нөөцийг зориулалтаар нь бүрдүүлэх, зарцуулах дүрэм журмыг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлт хэрэгжүүлэлтийн менежментийг сайжруулах шаардлагатай

3.6 Улсын нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар

6.1.Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

6.2.Улсын нөөцөд авах бараа, материалыг чанар, аюулгүйн шаардлага хангасан тухай холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан нөхцөлд хүлээн авч бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээ авна.

6.3.Стратегийн болон батлан хамгаалах материаллагаас бусад улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулна.

6.4.Онцгой тохиолдолд гамшгийн болон орон нутгийн нөөцийн бараа,

Хуулийн 6 дугаар зүйлд Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээний дагуу ОБЕГ нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, ингэхдээ хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэнэ. Нөөцийн бараа, материалын ангиллаас шалтгаалж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг явуулах бөгөөд онцгой тохиолдолд гамшгийн болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульчилжээ.

ОБЕГ улсын хэмжээнд хадгалбал зохих нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг тооцоолон гаргах баталгаажсан аргачлалгүй байна. Нөөцийн бараа, материалын тооцоог мэргэжлийн эдийн засагчдаар хийлгэх, улсын хэмжээний дотоодын үйлдвэрлэлийн болон импортын бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтэд дүн шинжилгээ хийх, гамшгийн үед хүн амын эрүүл мэнд, ам насыг аврахад шаардагдах хүнс болон эм, эмнэлгийн хэрэгсэл, автомашин бусад техник технологийн хэрэгцээг тодорхойлохдоо холбогдох төрийн захиргааны байгууллагын болон шаардлагатай мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх бололцоог нээсэн хуулийн зохицуулалт шаардлагатай нь харагдаж байна.

Хуулийн 6.2-д “Улсын нөөцөд авах бараа, материалыг чанар, аюулгүйн шаардлага хангасан тухай хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан нөхцөлд хүлээн авч бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээ авна” гэж заасны дагуу бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулж улсын нөөцөд бараа, материал хүлээн

авах зөвшөөрөл, бүтээгдэхүүний чанар байдлын талаар хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн бараа, материалыг улсын нөөцийн анги, салбаруудын агуулахад хадгалахаар хүлээн авч байна.

Үүнтэй холбоотой харилцааг “Журам батлах тухай” ОБЕГ-ын даргын 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 217 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого хийх, тооцоо бодох журам”-аар зохицуулж байна. Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар “Улсын нөөцөд бараа, материал хүлээн авсан акт”, 2 дугаар хавсралтаар “Гэрээ дүгнэсэн тэмдэглэл”, 3 дугаар хавсралтаар “Улсын нөөцөд бараа, материал гаргах тухай акт”, 4 дүгээр хавсралтаар “Бүтээгдэхүүн нуруулдах схем”, 5 дугаар хавсралтаар “Бүтээгдэхүүний хаяг”, 6 дугаар хавсралтаар “Улсын нөөцийн салбарт хадгалагдаж байгаа нөөцийн бараа, материалын хөдөлгөөний тайлан”-гийн загвар маягтыг баталжээ.

Нөөцийн бараа, материалыг агуулахад хүлээн авахтай холбоотой үйл ажиллагааны хүрээнд бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлттэй нийцэхгүй буюу чанарын шаардлага хангахгүй байх тохиолдол нэг бус удаа гардаг бөгөөд бараа материалыг хүлээн авах болон хүлээн авсны дараа чанарын шалгалтыг дүгнэлт гаргасан байгууллагаас өөр эрх бүхий байгууллагаар хийлгэж байх, хадгалагдаж буй нөөцийн бараа, материал нь шаардлагатай /хуульд заасан нөхцөл үүссэн/ үед чанартай, хэрэгцээ хангаж чадахуйц байгаа эсэхийг судалж дүгнэлт гаргах замаар хяналтын тогтолцоог дээшлүүлэх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42.3-д “Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг... судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, ...бусад нэгжтэй байна.” гэж заасан нь зохион байгуулалтын бүтцэдээ лабораторитой байх эрх зүйн үндсийг тодорхойлж байна.

Мөн улсын нөөцийг бүрдүүлэх, нөхөн бүрдүүлэхтэй холбоотой ЗГ-

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

...Бэлтгэн нийлүүлэгч нь зохих хууль, журмын дагуу бүх материалаа бүрдүүлээд гэрээгээ байгуулаад бараагаа агуулахад өгөхөөр ирдэг. Удирдлагаас бидэнд хүлээн авч байгаа бараа, материалын тоо, хэмжээ, чанар аюулгүй байдлыг шалгаж авах үүргийг өгдөг. Ялангуяа хүнсний бүтээгдэхүүн дээр маш сайн шалгаж хүлээн авах хэрэгтэй энэ нь бидний хуулиар хүлээсэн үүрэг. Зарим тохиолдолд чанарын шаардлага хангаж байна гэсэн мэргэжлийн хяналтын дүгнэлт барьчихсан мөртлөө нийлүүлж байгаа бараа нь нүдээр харахад илт шаардлага хангахгүй бүтээгдэхүүн ирдэг. Ийм үед бараа, материалыг солиулах, эсхүл дахин шинжилгээнд оруулахаас өөр аргагүй болдог. Миний бодлоор бэлтгэн нийлүүлэгч нь чанартай бараа шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулж гэрээ байгуулаад агуулахад буулгахдаа чанаргүй бараа авчраад байна гэж харддаг. Хүнсний чиглэлээр мэргэшиж олон жил ажилласан болохоор ийм тохиолдол практикт гардаг гэдгийг сайн мэднэ. Ийм учраас бид хүлээн авч байгаа бараа, материалыг чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах лабораторитой болохоор ажиллаж байна.

ын шийдвэрийг гаргуулахтай холбоотой төсөл бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хуулиар эрх олгох замаар ОБЕГ-т хариуцуулж хууль зүйн үндэстэй болгох нь зүйтэй. Улсын нөөцийн тухай хуульд энэ талаар ямар нэг зохицуулалт байхгүй. Нөөцийн бараа,

материалыг улсын нөөцөөс гаргах, ялангуяа гамшгийн үед яаралтай горимоор буюу хойшлуулшгүй тохиолдлоор гаргах нөхцөлийн хууль зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.5-д Онцгой байдлын байгууллага нь “улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах” үндсэн чиг үүрэгтэй гэж заасан байх бөгөөд ОБЕГ-ын алба хаагчид гамшгийн хор хохирлыг тооцоолох, цаг үеийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх зэргээр тэргүүн ээлжид нүүр тулж ажиллаж байгаа учир нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, гаргах, нөхөн бүрдүүлэх шийдвэрийг гаргуулах процессыг хэрэгжүүлэх нь зүйтэй

3.7 Улсын нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйл. Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар

7.1.Нөөцийн зарим бараа, материалыг хадгалах стандарт, технологийн шаардлага хангасан агуулах бүхий хуулийн этгээдэд /цаашид “гэрээт хадгалагч” гэх/, гэрээний үндсэн дээр хадгалуулж болох бөгөөд энэхүү хадгалуулах нөөцийн бараа, материалын жагсаалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.2.Нөөцийн бараа, материалыг хадгалах гэрээнд нөөцийн бараа, материалын чанар, стандарт, хадгалах хугацаа, төлбөр, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанар, талуудын хүлээх хариуцлага, мэдээ тайлангийн талаар тодорхой тусгасан байна.

7.3.Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагчийн агуулахад технологийн горимын дагуу хадгална.

Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах хуулийн хэрэгжилт зохих журмын дагуу явагдаж байна. Гэсэн хэдий ч дээр дурдсанчлан /Тайлангийн 3.3 дахь хэсэгт/ хадгалах үйл ажиллагааны процессын хэм хэмжээ дутагдалтай байна. Улсын нөөцийн бараа, материалыг хадгалах агуулах /хашаа/-ын стандартын шаардлагыг хуульчлах хэрэгтэй байна. Хуулийн 7.1-т “...стандарт, технологийн шаардлага хангасан агуулах бүхий хуулийн этгээд... гэрээний үндсэн дээр хадгалуулж болно...” гэж заасан ч ямар стандартыг хүлээн зөвшөөрөх нь талаар зохицуулалт алга байна.

Хадгалах үйл ажиллагаа нөөцийн бараа, материал нь тохирсон цаг үе, нөхцөлд хэрэгцээ шаардлагаа хангахуйц байх нөхцөлөөр тодорхойлогдвол зохилтой. Тухайлбал, гамшиг тохиолдсон үед олон хүн бэртэж гэмтсэн, тэдний амь насыг яаралтай аврах, ус хоол хүнсээр хангах шаардлагатай боллоо гэж үзэхэд нөөцийн бараа, материал нэг бүрийн хангамжаар савлагдаж хадгалагдаж байхыг шаарддаг байна²⁴.

Говьсүмбэр, Дархан-Уул аймаг дахь улсын нөөцийн салбарын өвс хадгалах цэгийг ердийн хашаагаар хүрээлүүлж, үүдэндээ 1 харуулаар хамгаалуулсан, өвсийг саравчинд болон ил задгай байдлаар нуруулдаж хадгалж байна. Нөөцийн салбар нь улирал тутам харуулын ажилтнаар, хөдөлмөр хамгааллын хувцас, техник хэрэглэлийн хангалтгүйгээр сэлгэх ажиллагааг хийлгэж байгаа нь 1-рт, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн гэрээнд заагдаагүй ажил үүргийг гүйцэтгүүлж хууль зөрчих, 2-рт, ажиллах явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

²⁴ АНУ-ын Эм, эмнэлгийн материалын хангамж нөөцийн агуулах

Мөн улсын нөөцийн бараа, материалыг хадгалах хуулийн хэрэгжилт нь аюулгүй байдал буюу харуул хамгаалалттай шууд холбогдоно. Улсын нөөцийн бараа, материал нь хамгийн найдвартай, эрсдэлгүй, онцгой байдлын үед захиран зарцуулагдахад бэлэн байх учиртай.

Улсын нөөцийн бараа, материалыг хадгалж буй объект нь гамшиг, гэмт халдлага, хорлон сүйтгэх ажиллагаа, терроризмын болзошгүй аюул, хүний буруутай үйл ажиллагаанаас учирч болох аливаа эрсдэлээс ангид байх хэмжээнд хамгаалагдах ёстой.

Гэвч өнөөдрийн байдлаар улсын нөөцийн бараа, материалыг хадгалж буй агуулахыг төрийн үйлчилгээний албан тушаал дээр томилогдсон энгийн ажилтан хамгаалж байна. Улсын нөөц хадгалж буй агуулах, хашаа нь улсын онц чухал объектод тооцогдоогүй байна. Улсын нөөцийн тухай хуульд нөөцийн бараа, материалын хамгаалалтын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Иймд улсын нөөцийн аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах боломжийг бүрдүүлэх үүднээс хуульд тусгайлсан зохицуулалт хийх хэрэгтэй.

Гэрээт хадгалагчийн агуулахын стандарт, технологийн горимыг шалгах, анх гэрээ байгуулахад мөрдлөг болгож тавих үзүүлэлт бүхий стандарт, журам хангалтгүй байгаа нь хуулийн хийдэлтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн Улсын нөөцийн анги, салбаруудын харуул хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулсан онцгой байдлын байгууллагын хэмжээнд мөрдөх нарийвчилсан зохицуулалт бүхий журам байхгүй, хууль, эрх зүйн зохицуулалт сул, байна. Улсын нөөцийн агуулах, /хашаа/-ны харуулын ажилтнаар ихэвчлэн 45-аас дээш насны хүн ажиллаж байна.

Улсын нөөцийн бараа, материалыг хадгалж буй агуулах, объект нь улсын тусгай хамгаалалтын зэрэглэлд авагдаагүй, зөвхөн ОБЕГ-ын даргын шийдвэрээр баталсан журмын хүрээнд “маш нууц буюу улсын онц чухал объект” гэж практикт өөрсдөө үзэж байгаа боловч албан ёсны Засгийн газраас тогтоосон шийдвэр байхгүй байна. Иймээс уг асуудлыг тусгайлан зохицуулж, бодлогын хувьд эрс өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Нөөцийн бараа, материалыг шаардлага хангасан гэрээт хадгалагчийн агуулахад хадгалуулахдаа ОБЕГ-ын даргын 2008 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 224 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын нөөцийн бараа, материалын хадгалалтын гэрээ”-ний загварыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Улсын нөөцийн тухай хуулийн 18.2-д заасан гэрээнд заавал тусгах нөхцөлийг уг загварын 7, 18 дугаар зүйлд ерөнхий байдлаар тусгасан байх бөгөөд загварт хэрэглэсэн хуулийн зарим нэр, томъёолол нь өөрчлөгдсөн байх тул шинээр гэрээний загвар гаргах, гэрээний үлгэрчилсэн загвар гаргах эрхийг ОБЕГ-т олгох замаар хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Гэрээгээр хадгалуулах нөөцийн бараа, материалын нэр төрлийн жагсаалтыг Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 12 дугаар тушаалаар нууцын зэрэглэлтэйгээр баталж, мөрдүүлж байна. Цаашид уг шийдвэрийг төрийн нууцын зэрэглэлд авах нь хуульд нийцэх эсэх талаар тагнуулын байгууллагад хандаж, зөвлөмж авах, төрийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд нээлттэй, ил тод байх зарчимд нийцэх эсэхийг үнэлэх шаардлагатай. Төрийн нууцын зэрэглэлд оруулсан бараа, материалыг хувийн

хэвшлээр гүйцэтгүүлэх нь нууцлал, аюулгүй байдал баталгаатай хангагдсан байх талаасаа хэр зохистой эсэхийг анхаарах нь зүйтэй.

3.8 Улсын нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйл. Улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дагавар

8.1.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинэчлэх шаардлагатай стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 13.1.8-д заасан журмын дагуу борлуулж, орлогоор нь нөхөн бүрдүүлнэ.

13.1.Засгийн газар нь улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.8.нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг батлах;

Онцгой байдлын байгууллага нь хуульд зааснаар шинэчлэх шаардлагатай стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг Засгийн газрын баталсан журмын дагуу борлуулж, орлогоор нь нөхөн бүрдүүлж байна.

Энэхүү харилцаанд Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам”-ыг мөрдөж байна. Хуулийн 3.1.6 дахь заалт, журмын Дөрөвдүгээр зүйлд “Нөөцийн барааг шинэчлэх, сэлгэх” харилцааг:

4.1.Нөөцийн бараа, материалын чанарын талаарх мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, тухайн барааны хадгалах хүчинтэй хугацаа зэргийг харгалзан улсын нөөцийн барааны 20 хүртэлх хувийг улирал тутам борлуулж тоо хэмжээ, чанарыг нь бууруулалгүйгээр тухайн бараагаар нь эргүүлэн авах нөхцөлтэйгөөр улсын нөөцөөс гаргаж шинээр нөхөн бүрдүүлнэ.

4.2.Улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулахыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх бөгөөд худалдан авагч этгээдийн төрийн сангийн зохих дансанд төлбөр хийсэн баримтыг үндэслэн барааг олгоно.

4.3.Нөөцийн барааны хадгалалтын хугацаа, чанар байдлын өөрчлөлт, мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлт зэргийг үндэслэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шинэчлэх, сэлгэх барааны нэр төрөл, тоо хэмжээ, хугацааг тодорхой тусгасан хуваарийг тухайн жилийн эхэнд батална.

4.4.Баталсан нөөцийн бараа, материалыг шинэчлэх хуваарийн дагуу барааг улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллагаас гаргах зөвшөөрлийг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын улсын нөөцийн асуудал хариуцсан нэгжийн дарга олгоно.

4.5.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон албан ёсны зөвшөөрлийн дагуу нөөцийн барааг шинэчлэх, сэлгэх үүргийг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч гүйцэтгэнэ гэжээ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд нөөцийн бараа, материалын чанар, хадгалах хугацаатай холбогдуулан 20 хүртэлх хувийг улирал тутамд борлуулж, тоо хэмжээ, чанарыг бууруулахгүйгээр тухайн барааг эргүүлэн авах нөхцөлтэйгөөр улсын нөөцөөс гаргаж, шинээр нөхөн бүрдүүлж байна.

Шинэчлэх үйл ажиллагааг нөөцийн бараа, материалын чанар байдлыг алдагдахаас урьдчилан сэргийлэх болон тухайн бараа, материалын хадгалах хугацаатай холбогдуулан хийж гүйцэтгэж байна. Гэвч улсын нөөцийн анги, салбарын агуулахад зарим нэр төрлийн нөөцийн бараа, материалыг маш удаан хугацаагаар хадгалагдаж байна.²⁵

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ХЭСГЭЭС

... Нөөцийн агуулахад 1980-аад онд улсын нөөцөд авсан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, олон нэр төрлийн бараа, материалууд одоог хүртэл хадгалагдаж байна. Эдгээрээс зарим тоног төхөөрөмж, тодорхой нэр төрлийн бараа, материалуудыг хуульд зааснаар шинэчлэх /борлуулж, нөхөн бүрдүүлэх/ боломжгүй гэж үзэж байгаа. Учир нь тухайн тоног төхөөрөмж, бараа, материалууд хэрэглээнээс гарчихсан. Бид энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр удаа дараа санал, хүсэлт гаргасан боловч шийдвэрлэгдээгүй ...

Улсын нөөцийн асуудлыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн зохион байгуулах ёстой. Түүний үндэс суурь нь тухайн харилцааг зохицуулсан хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартууд ойлгомжтой, тодорхой, хоорондын уялдаа холбоотой, хууль өөрөө процессын зохицуулалт сайтай /процессын хэм хэмжээ/ байх явдал юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29.1.1-д Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих”, 29.1.11-д “гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх” чиг үүрэгтэй гэж, Улсын нөөцийн тухай хуулийн 8.1-д “Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинэчлэх шаардлагатай стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 13.1.8-д заасан журмын дагуу борлуулж, орлогоор нь нөхөн бүрдүүлнэ” гэж заажээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.2-д “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий 1-рт, Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний борлуулалт хийсэн, 2-рт, бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, 3-рт, бараа, ажил, үйлчилгээг экспортод гаргасан этгээд албан татвар суутган төлөгч байна гэж тодорхойлжээ.

Практикт нөөцийн бараа, материалыг НӨАТ-тэй үнээр бүрдүүлээд, түүнийг шинэчлэх буюу борлуулахдаа /НӨАТ-гүй үнээр/ худалдаж орлогоор нь нөхөн бүрдүүлэлтийг хийж байна. Энэ нь нөхөн бүрдүүлэлтээр тухайн нэр төрлийн барааны тоо, хэмжээг багасах гол хүчин зүйл болж байна. Ялангуяа үнэ ихтэй бараа, материал дээр их хэмжээний зөрүү гарах, төсвийн хөрөнгө алдагдал хүлээх нэг шалтгаан нөхцөл нь болж байна.

Тогтмол шинэчлэх шаардлагатай, нэгж үнэ өндөр, тоо хэмжээ ихтэй нөөцийн бараа, материалын тухайд сөрөг үр дагавар төдий чинээ их бий болно.

²⁵ ОБЕГ-ын 185 дугаар ангийн алба хаагчтай хийсэн ярилцлага

3.9 Улсын нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Улсын нөөцийн бараа, материалыг зарцуулах нөхцөл, хэрэгжилтийн үр дагавар

9.1.Нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 5.1-д заасан зориулалтын дагуу улсын нөөцөөс гаргахдаа тэдгээрийг хүлээн авах этгээдэд дараахь нөхцөлөөр олгоно:

9.1.1.улсын нөөцөд эргэн төлөгдөх нөхцөлөөр;

9.1.2.буцалтгүй тусламж болгон улсын нөөцөд эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр.

9.2.Энэ хуулийн 4.2, 4.3-т зааснаас бусад нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 9.1-д заасан нөхцөлөөр улсын нөөцөөс гаргах шийдвэрийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

9.3.Засгийн газрын шийдвэрт нөөцийн бараа, материалыг хүлээн авах этгээд, нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан байна.

9.4.Нөөцийн бараа, материалыг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгохдоо онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд нөөцийн бараа, материалын тоо хэмжээ, үнэ, нөхөн бүрдүүлэх хугацаа, хүлээх хариуцлага зэргийг тусгана.

9.5.Нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 5.1-д зааснаас өөр зориулалтаар улсын нөөцөөс гаргах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй бусдад шилжүүлэх, барьцаалах, хандивлахыг хориглоно.

Нөөцийн бараа, материалыг 1-рт, гамшгийн хор уршгийг арилгах, 2-рт, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс улсын нөөцөөс гаргахдаа эргэн төлөгдөх, эсхүл эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр гаргахаар заасан.

Хуулийн 9.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.2,²⁶ 4.3-т²⁷ зааснаас бусад нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 9.1-д заасан нөхцөлөөр улсын нөөцөөс гаргах шийдвэрийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар гаргана.” гэж зарцуулах шийдвэр гаргах нөхцөлийг тогтоосон.

Харин иш татсан 4.3 дахь хэсгийг Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарсан Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцож, цэргийн дайчилгааны нөөцтэй холбоотой асуудлыг Улсын нөөцийн тухай хуулиар зохицуулахгүй болжээ. Гэвч хуулийн 9.1.2 2-т дээр дурдсан хүчингүйд тооцсон 4.3 заалтыг иш татсан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.5-д “...зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” гэсэн нийтлэг шаардлагыг хангаагүй байна.

Улсын нөөцийн тухай хууль батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш буюу 2007-2024 онд улсын нөөцөөс бараа, материалыг зарцуулах, бүрдүүлэх

²⁶ 4.2.Орон нутгийн нөөцөд тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах аймаг, сум, нийслэл, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагад байх нөөцийг хамааруулна.

²⁷ 4.3.Цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

/Энэ хэсгийг Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарсан Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

болон нөхөн бүрдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газраас тогтоол 110, хурлын тэмдэглэл 3 нийт 113²⁸ шийдвэрийг гаргажээ. Эдгээр шийдвэрүүдийн дагуу нөөцийн бараа, материал нь эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр зарцуулагджээ.

ОБЕГ-ын даргын 2008 оны 224 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “нөөцийн бараа, материалыг зээлээр олгох болон хадгалалтын гэрээний загвар”-д Улсын нөөцийн тухай хуульд заавал биелэгдэх шинжтэй заасан нөхцөлүүдийг /хуулийн 18.2.1-18.2.7/ бүрэн тусгаагүй нь хууль зөрчсөн шинжтэй захиргааны хэм хэмжээний акт байна.

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс гаргах түүнчлэн нөөцийн бараа, материалыг шинэчлэхдээ уг асуудлыг эдийн засаг, худалдааны асуудал эрхэлсэн төрийн болон мэргэжлийн бусад байгууллага, эдийн засагчдын дэмжлэг оролцоотой эрхлэн гүйцэтгэх зэрэг эдийн засгийн удирдлагын /менежмент/ асуудлыг Улсын нөөцийн тухай хууль болон холбогдох бусад хуульд тусгах асуудлыг анхаарч үзэх зүйтэй юм.

3.10 Улсын нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Улсын нөөцийн улсын төсвийн санхүүжилт, хэрэгжилтийн үр дагавар

10.1.Улсын нөөцтэй холбогдсон дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1.нөөцийн бараа, материалыг шинээр бүрдүүлэх, энэ хуулийн 9.1.2-т заасны дагуу зарцуулсан нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх;

10.1.2.нөөцийн бараа, материалыг шинэчлэхэд гарсан үнийн зөрүүг нөхөн олгох;

10.1.3.нөөцийн бараа, материалыг тээвэрлэн байршуулах, хадгалах, хэвийн хорогдлыг нөхөхтэй холбогдон гарах зардал;

10.1.4.гэрээт хадгалагчдад нөөцийн бараа, материал хадгалуулсны төлбөр;

10.1.5.даатгалын зардал.

Улсын нөөцийн тухай хуульд зааснаар нөөцийн барааг шинээр бүрдүүлэх, эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр зарцуулсан бараа, материалыг нөхөн бүрдүүлэх, шинэчлэхэд гарсан үнийг зөрүүг нөхөх, тээвэрлэн байршуулах, хадгалах, хэвийн хорогдлыг нөхөх, даатгалд хамруулах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Энэхүү харилцааг “Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 199 дүгээр тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтаар баталсан “Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”, “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам”-аар нарийвчлан зохицуулж байна.

Гэсэн хэдий ч улсын нөөцийн бараа, материалыг хадгалах зориулалтын агуулах /хашаа/ шинээр барих, өртгөн засварлах, бусад засвар үйлчилгээний зардал заавал биелэгдэх шинжтэйгээр хуульчлагдах хэрэгтэй нь судалгаанаас харагдаж байна.

²⁸ Засгийн газрын шийдвэрийг ангилж үзвэл: Гамшгийн хохирлыг барагдуулах тухай 2, Малын гоц халдварт өвчин, хээрийн түймэр гарсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 3, Өвөлжилтийн бэлтгэл хангах, өвөлжилттэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай-11, Өвс, тэжээл олгох, гаргах, хөнгөлөлттэй үнээр борлуулах, нөхөн бүрдүүлэх тухай - 9, Автомашин олгох, гаргах, нөхөн бүрдүүлэх тухай-5, Бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай-2, Улаан буудайн үр гаргах, нөхөн бүрдүүлэх тухай - 12, Хөрөнгө гаргах тухай- 67, Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай -1, Буцалтгүй тусламж үзүүлэх тухай -1, Хилийн зарим боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай -1 тус тус байна.

Нөөцийн бараа, материалыг “зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулах”, “...стандарт, технологийн шаардлага хангасан агуулах...”-д хадгалуулна гэж заасан боловч судалгааны явцад улсын нөөцийн бараа, материалын агуулах /хашаа/ шаардлага хангах түвшинд хүрээгүй байна. Агуулах /хашаа/-ийн стандарт ямар байхыг хуульчлан тогтоогоогүй талаар өмнө нь дурдсан билээ.

УНГ-ын удирдлага, алба хаагчидтай уулзахад агуулах /хашаа/-ийн засвар үйлчилгээ хийх төсөв, хөрөнгө байнга дутагдалтай байдгийг онцолж байв. Жишээ нь Говьсүмбэр аймаг дахь улсын нөөцийн салбарын өвс хадгалж байгаа хашаа нь энгийн модон хашаа байх ба түүнд зориулалтын саравч зэрэг нэмэлт тоноглол байхгүй. Гэтэл хадгалж буй нуруулдсан өвсийг бороо цас, уснаас хамгаалах наад захын шаардлага хангахгүй байгааг нөөцийн салбарынхан ярьж байлаа. Агуулах /хашаа/-ийн тоноглол тухайлбал хамгаалалтын систем, бараа өргөгч зөөгч механикжсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ч байхгүй байна. Эдгээрээс авч үзвэл хуульд заасан улсын нөөцийн санхүүжилттэй холбоотой зүйл, заалтын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэхээс илүүтэй хуулийн зохицуулалтыг сайжруулах нь чухал байна.

Иймээс практикт тулгарч буй байдлыг харгалзан аюулгүй байдал буюу харуул хамгаалалт, агуулахын болон тусгай хашаа /талбай/-ны засвар үйлчилгээ, нөөцийн бараа, материалын хадгалалт, арчлалт, сэлгэх, сэлбэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж²⁹ зэрэг хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, технологийн горимыг хангахтай холбоотой зардлыг тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

Судалгааны баг Улсын нөөцийн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах ажлын хүрээнд нөөцийн бараа, материалын бүрдүүлэлтийн нөөц, худалдан авалтын болон санхүүгийн материал, тоо баримттай танилцах эрхийг ТЕГ-аас олгоогүй тул санхүүжилттэй холбоотой хуулийн хэрэгжилтийн байдалд бүрэн гүйцэд үнэлгээ өгөх боломжгүй байсныг дурдах нь зүйтэй.

3.11 Улсын нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйл Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт, хэрэгжилтийн үр дагавар

11.1.Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, стандарт, хадгалалтын технологийн мөрдөлтөд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.

11.2.Улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч нь нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журмыг гаргаж мөрдөнө.

Хуулиар хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, стандарт, хадгалалтын технологийн мөрдөлтөд хяналт тавих үүргийг олгожээ. Улсын нөөцийн салбарууд нь техникийн ерөнхий шаардлагын хүрээнд 29, лабораторийн шинжилгээний хүрээнд 47 төрлийн /MNS/ Монгол Улсын стандартыг³⁰ мөрдөн ажиллаж байна.

Харин практикт нөөцийн барааны чанарыг алдагдуулахгүй байх тал дээр ямар стандарт, технологийг ашиглаж байгаа нь тодорхойгүй. Нөөцийн барааны аюулгүй байдал гэж юуг хамруулан ойлгож байгааг дүгнэх бололцоогүй байна. Нөөцийн бараа,

²⁹ Улсын нөөцийн салбар, газрын алба хаагч, ажилтантай хийсэн уулзалт, ярилцлагаар энэ талаарх зардал төсөвт тусгагддаг эсэх талаар тодруулахад ямар нэгэн зардал байхгүй талаар тайлбарласан болно.

³⁰ Ном зүй хэсгээс үзнэ үү

материалын аюулгүй байдалд юуны түрүүнд харуул хамгаалалтын үйл ажиллагаа орох ёстой боловч энэ асуудалд хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байна. /Энэ талаар хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангаас үзнэ үү/

Улсын нөөцийн асуудал хариуцсан байгууллага нь зохион байгуулалтын бүтэцдээ чанарын лабораторитой, харуул хамгаалалтын албатай тэдгээр нь хуульд заасан үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дүрэм, журам, заавартай байж хуулийн энэхүү заалт хэрэгжих ёстой. Түүнээс биш хуульд заасан эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн хэм хэмжээний актын дутагдалтайгаас тухайлсан стандарт нь батлагдан гараагүй байхад хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалт хэрэгжүүлэх байгууллага шалгаснаар асуудал шийдэгдэхгүй гэдэг нь ойлгомжтой.

Судалгаагаар улсын нөөцийн анги, салбаруудад ашиглагдаж байгаа олон тооны агуулах, тоног төхөөрөмж /элеватор/-ийн ашиглалтын хугацаа дууссан, барилгын бүтэцэд эвдрэл гэмтэл гарч ашиглах боломжгүй болсон /Агуулах хоосон ашиглах боломжгүй/ байна. Одоо ашиглаж байгаа агуулахууд нь нөөцийн бараа, материалын хадгалалтын горимын шаардлага хангахгүй /агааржуулах системгүй, дулааныг тогтоосон хэмд барих автоматжуулалт г.м/ байгаа нь нөөцийн бараа, материал, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний чанарт нөлөөлөхгүй гэх баталгаа алга байна.

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ХЭСГЭЭС

...Сүүлийн 2 жилийн хугацаанд улсын нөөцөд хадгалагдаж байгаа хүнсний бараа, бүтээгдэхүүн, үрийн буудайгаас 15 дээж, Сэлэнгэ, Дорнод, Ховд, Завхан аймгуудын улсын нөөцийн салбар, цэгүүдэд хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнээс 20 дээжийг авч шинжилгээнд хамруулан чанар аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулсан. Мөн мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн 2 зөвлөмжийн дагуу шатахууны агуулахын барилга, байгууламжид засварын ажлыг хийж гүйцэтгээд байна...

Хуулийн 11.2-д “Улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч нь нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журмыг гаргаж мөрдөх.” гэж заасан боловч “Журам батлах тухай” Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/397 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам”-ыг³¹ баталж, мөрдүүлжээ. Өөрөөр хэлбэл, улсын нөөцийн салбар, анги, гэрээт хадгалагч нь өөрсдөө бие даан дотоод хяналтын журам гаргаж мөрдөх, түүний хэрэгжилтэд ОБЕГ-аас хяналт тавихаар³² хуулиар зохицуулсан боловч практикт ОБЕГ-ын дарга дээрх журмыг баталж, хяналт тавих байдлаар хуулийн 11.2 дахь хэсгийн хэрэгжилт хангагдаж байна гэж үзлээ.

³¹ “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам”-ыг 5 хэсэг 60 заалттайгаар баталсан бөгөөд Нийтлэг үндэслэл /3 заалт/, Дотоод хяналтын чиглэл, хамрах хүрээ /2 заалт/, Дотоод хяналтыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт /5 заалт/, Дотоод хяналтыг зохион байгуулах чиглэл /49 заалт/ Хариуцлага /1 заалт/-аар баталжээ..

³² Улсын нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсэг “улсын нөөцийн салбарт бараа, материал бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохион байгуулах”.

ОБЕГ-ын даргын баталсан дээрх журмаар гэрээт хадгалагчийн үйл ажиллагааг буюу гадагш чиглэсэн харилцааг зохицуулж байх тул Захиргааны ерөнхий хууль³³ /59 дүгээр зүйл/-д нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх нь нь зүйтэй.

3.12 Улсын нөөцийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар

12.1.Улсын Их Хурал нь улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

12.1.2.стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг тогтоох;

12.1.3.орон нутгийнхаас бусад улсын нөөцийн зарцуулалтын тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх;

12.1.4.газрын тосны стратегийн нөөцийг хадгалах хэмжээ, байршлыг тогтоох асуудлаар Засгийн газарт чиглэл өгч захиран зарцуулах эрх нээх.

Энэхүү зохицуулалтаар Улсын Их Хурал нь улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг тогтоох, орон нутгийнхаас бусад улсын нөөцийн зарцуулалтын тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх, газрын тосны стратегийн нөөцийг хадгалах хэмжээ, байршлыг тогтоох асуудлаар Засгийн газарт чиглэл өгч захиран зарцуулах эрх нээх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг шууд тодорхойлсон, тусгайлан зохицуулсан бодлогын баримт бичиг батлагдан гараагүй байх тул бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаар батлуулах замаар хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлбэл зохистой юм.

Харин төрөөс баримтлах бодлогын бусад баримт бичигт улсын нөөцийн асуудал дараах байдлаар тусгагджээ. Тухайлбал,

Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, хоёрдугаар хавсралтаар “Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Гуравдугаар зүйл /Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ/-ийн 3.1.8-д “төв, орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлж, гамшгийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай эд материал, аврах багаж, техник хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх.”, 3.5.6-д “улсын нөөцийн бараа, материалыг хадгалах нөхцөл, технологийг дээшлүүлэх.”³⁴

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны Долоо /Амар тайван, аюулгүй нийгэм/-н 7.3.15-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх,

³³ Захиргааны ерөнхий хуулийн 59.1-т “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.”

³⁴ “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ.” гэжээ.

Хуульд стратегийн нөөцийн нэр төрлийг батлах эрхийг УИХ-д олгосон боловч тэдгээрийг батлуулах ажлыг зохион байгуулахдаа, тодорхой хэлбэл стратегийн нөөц гэх шаардлагыг тодорхойлж байгаа арга зүй тодорхой бус хэт субъектив хандлагатай гэж дүгнэхээр байна. Улсын нөөцийн /гамшиг, стратегийн/ зарцуулалтын тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлээгүй байх тул³⁵ хуулийн хэрэгжилтийг хангаж тайланг хэлэлцүүлэх нь зүйтэй юм.

Мөн газрын тосны стратегийн нөөцийг хадгалах хэмжээ, байршлыг тогтоох асуудлаар Засгийн газарт чиглэл өгч захиран зарцуулах эрх нээх чиглэлээр эрх зүйн баримт бичиг гарсан эсэх нь тодорхойгүй байна.

Харин Засгийн газар хууль /Газрын тосны бүтээгдэхүүний тухай/-д зааснаар "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам"-ыг 2021 онд баталж, үүгээр Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хомстол, үнийн хөөргөдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийг тогтвортой байдлыг хангах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, түүнийг хадгалах, зарцуулах, нөхөн бүрдүүлэх, сэлгэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа нь харьцангуй сайн хэрэгжиж байна.

3.13 Улсын нөөцийн тухай хуулийн 13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар

- 13.1. Засгийн газар нь улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:*
- 13.1.1. улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;*
 - 13.1.2. стратегийн нөөцийн бараа, материалын байршил, тоо хэмжээг тогтоох;*
 - 13.1.3. гамшигийн нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;*
 - 13.1.4. улсын нөөцөөс бараа, материалыг зориулалтын дагуу гаргах, нөхөн бүрдүүлэх шийдвэр гаргах;*
 - 13.1.5. энэ хуулийн 13.1.9-т заасан журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх гамшигийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;*
 - 13.1.6. улсын нөөцийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;*
 - 13.1.7. даатгалд хамрагдах бараа, материалын нэр төрөл, санхүүжилтийн хэмжээг батлах;*
 - 13.1.8. нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг батлах;*
 - 13.1.9. гамшигийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журмыг батлах;*
 - 13.1.10. орон нутгийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*

Судалгаагаар улсын нөөцийн талаар хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрх зохих хэмжээнд хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл Улсын нөөцийн тухай хуульд заасан хуулийн зохицуулах зүйлүүдээс Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой тасалдсан, Засгийн газрын бүрэн эрхээс шалтгаалсан зүйл байхгүй байна.

³⁵ ОБЕГ-ын УНГ-ын алба хаагчдаас энэ талаар нэмэлт тодруулга, баримт бичиг хүсэхэд байхгүй тухай мэдэгдсэн болно.

Харин Засгийн Газрын бүрэн эрхийг улам сайжруулах, нэн ялангуяа хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой журмыг батлан гаргах эрхийг улам тодруулах хэрэгтэй нь харагдаж байна. Тухайлбал, нөөцийн бараа, материалыг гэрээт хадгалагчид хадгалуулах эрхийг хуулиар олгосон боловч, гэрээт хадгалагчид тавих агуулах /хашаа/, бусад улсын нөөц хадгалах барилга байгууламж, тоног төхөөрөмж, чанар, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд мөрдөх хэм хэмжээний актыг батлан гаргах эрхийг Засгийн газарт хуульчлан өгөх шаардлагатай.

Улсын нөөцийн харилцаа, үйл ажиллагааг тус хуулиар нэг мөр шийдэх хууль зүйн боломжгүй тул нийтээр дагаж мөрдөх шинжтэй Засгийн газрын баталбал зохих дүрэм, журам, стандартыг тодорхой болгох шаардлага байна.

Улсын нөөцийн харилцааг зохицуулах процессын шинжтэй зохицуулалт дутмаг ЗГ-аас баталсан журмын хүрээнд тухайн харилцааг бүрэн зохицуулах боломжгүй, тодорхой бус байгаагаас шалтгаалан тэрхүү хийдлийг нөхөхийн тулд практик дээр нарийвчилсан журам гарган мөрдөж байгаа тохиолдол байна. Жишээлбэл, ОБЕГ-ын даргын 2010 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 217 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого явуулах дотоод журам”-ыг 2 дугаар хавсралтаар “Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам”-ыг, мөн тус газрын даргын “Журам батлах тухай” 2010 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 494 дүгээр тушаалын хавсралтаар “Улсын нөөцийн бараа, материалын удаан хадгалах журам”-ыг тус тус баталсан байна.

3.14 Улсын нөөцийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар

14.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. нөөцийн бараа, материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байршил, нэр төрөл, тоо хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах, нөхөн бүрдүүлэх талаархи саналыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.2. энэ хуулийн 13.1.5-д заасан хэмжээнд гамшгийн нөөцийн бараа, материалыг захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх;

14.1.3. орон нутгийн нөөцийн тоо хэмжээ, нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн тогтоох.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг³⁶, Улсын нөөцийн тухай хуулийн 14 дүгээр зүйл нь улсын нөөцийн асуудлаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх бүрэн эрхийг /цаашид “Шадар сайд” гэх/ тодорхойлно.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 199 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх”, “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах,

³⁶ Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 20 угаар зүйлийн 5 хэсэгт “ Монгол Улсын Шадар сайд “гамшгаас хамгаалах асуудал, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал...” -ын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэхээр заасан.

хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдад үүрэг болгосон.

Улсын нөөцийн асуудлаар Шадар сайдын тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажилд дэмжлэг үзүүлэх, улсын нөөцтэй холбоотой Засгийн газрын шийдвэрийг гаргуулах бэлтгэл ажилд ОБЕГ оролцож ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, улсын нөөцөөс хуульд заасан нөхцөл журмын дагуу бараа, материал гаргах болон нөөцийн бараа, материал бүрдүүлэхэд нэр төрөл тоо, хэмжээ зэргийг ОБЕГ-аас хариуцан бэлтгэж Шадар сайдад танилцуулах зэрэг захиргааны үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн 14.1.1-т Шадар сайд “нөөцийн бараа, материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байршил, нэр төрөл, тоо хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах, нөхөн бүрдүүлэх талаарх саналыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавина” гэжээ. Практик дээр ОБЕГ-аас хариуцан нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ /Шадар сайдаар уламжлагдан Засгийн газраар шийдвэрлэгдэх/-ний судалгааг хийж, шийдвэрийн төслийг бэлтгэж байгаа нь хууль зүйн хувьд алдаатай юм.

ОБЕГ нь хуулиар нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах шинэчлэх, Засгийн газрын шийдвэр гарсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй. Харин улсын нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээний талаар гарах Засгийн газрын шийдвэрийн төслийг бэлтгэх, тооцоо судалгаа хийх зэрэг бодлогын үйл ажиллагаа явуулах эрх хуулиар олгогдоогүй болохыг анхаарах нь хэрэгтэй. Иймд практикт хийгдэж хэвшсэн дээрх үйл ажиллагааг хуулиар эрх олгох замаар ОБЕГ-т хариуцуулж хууль зүйн үндэстэй болгох нь зүйтэй.

Улсын нөөцийн талаар Шадар сайдын авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг цаашид сайжруулах замаар хуулийн болон үйл ажиллагааны зөв жишгийг тогтоох шаардлага үүссэн байна гэж үзлээ.

3.15 Улсын нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, хэрэгжилтийн үр дагавар

15.1. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг нөөцийн салбаруудаар дамжуулан хэрэгжүүлэх;

15.1.2. улсын нөөцийн салбаруудын бараа, материалын хөдөлгөөний талаархи мэдээ болон санхүүжилтийн тайланг улсын нөөцийн салбаруудаас авч нэгтгэн, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

15.1.3. гэрээт хадгалагчтай гэрээ байгуулж, нөөцийн бараа, материал хадгалах үйл ажиллагаанд нь хяналт тавих;

15.1.4. улсын нөөцийн салбарт бараа, материал бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохион байгуулах.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн”, 42.3 дахь хэсэгт “Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-логистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.” гэж хуульчилсан нь Улсын нөөцийн тухай хуульд заасан бүрэн эрхийг Онцгой байдлын ерөнхий газар хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болж байна.

Нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг нөөцийн салбаруудаар дамжуулан хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд бие даасан агентлаг болсноос хойш 4.7 тэрбум төгрөгийн 443,520 гаруй тн хүнсний бараа материал, 22.5 тэрбум төгрөгийн 145,892 орчим тн өвс, 26.4 тэрбум төгрөгийн 104,352 орчим тн тэжээл, 2.3 тэрбум төгрөгийн 1,232 гаруй иж бүрэн гэр, 8.1 тэрбум төгрөгийн 354 орчим автомашин, 4.8 тэрбум төгрөгийн эрчим хүчний тоног төхөөрөмж, хэрэгсэл зэргийг гамшгийн үед болон хойшлуулшгүй сэргээн босгоход зарцуулжээ.³⁷

Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах болон урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 43,5 тэрбум төгрөгийн 141,164 гаруй тонн үр тариа гарган тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн ба 158.9 тэрбум төгрөгийн 71,673 гаруй тонн шатахуун тосолгооны материалыг улсын нөөцөөс гарган Иргэний агаарын тээвэр, аж үйлдвэрийн салбаруудыг хангах зэргээр улсын хэмжээний шатахууны хангамжийг нэмэгдүүлэхэд зарцуулжээ.

Мөн энэ хугацаанд хүмүүнлэгийн тусламжийн асуудлаар үүрэг хүлээн дотоодын болон гадаадын хуулийн этгээд, иргэнтэй хамтран хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сум, өрхөд хүргэн ажиллажээ.

Үүний зэрэгцээ хуульд заасан улсын нөөцийн бараа, материалын /гамшгийн/ нэр төрөл, тоо, хэмжээ, байршлыг тогтоох, бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой холбогдох журам, стандартуудыг батлуулах ажлыг зохион байгуулжээ. /Дүрэм, журам стандартуудыг судалгааны ажлын ном зүй хэсгээс үзнэ үү./

Улсын нөөцийн салбаруудын бараа, материалын хөдөлгөөний талаарх мэдээ болон санхүүжилтийн тайланг нэгтгэхдээ ОБЕГ-ын даргын 2020 оны А/173 тушаалын хавсралтаар батлагдсан “Онцгой байдлын ерөнхий газар болон салбар нэгжийн хугацаат тайлан мэдээг тайлагнах, дүгнэх журам”-ын холбогдох заалт, мөн газрын даргын 2010 оны 217 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”, “Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам”-ыг тус тус үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.

³⁷ УНГ-ын статистик тоо баримт

Улсын нөөцийн бараа, материалын мэдээ, тайланг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд ОБЕГ-аас тогтмол танилцуулдаг бөгөөд энэхүү мэдээ, тайлан нь онц чухал нууцийн зэрэглэлд хамаарч байгаа тул судалгааны баг уг мэдээ тайлантай танилцаагүй болно.

“Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам”-ын³⁸ дагуу дотоод хяналтыг, “Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”³⁹-ын хавсралтаар гэрээт хадгалагчтай байгуулах гэрээний загварыг баталсан бөгөөд холбогдох анги, салбар, ОБЕГ-ын чиглэл хариуцсан мэргэжилтэн гэрээ болон журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр улсын нөөцийн бараа, материалыг гаргахаар хууль болон журамд тодорхой заасан. Харин яаралтай, хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд улсын нөөцөөс бараа, материалыг хэрхэн яаж гаргах /зарцуулах/-тай холбоотой зохицуулалт Улсын нөөцийн тухай хууль болон холбогдох журамд байхгүй байна.

Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед улсын нөөцөөс бараа материалыг гаргах /зарцуулах/ шийдвэрийг яаралтай гаргах, богино хугацаанд шийдвэрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага цөөнгүй тохиолддог бөгөөд ийм үед эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүргийн хүрээнд улсын нөөцийн бараа, материалыг гарган Засгийн газрын шийдвэрийг нөхөн албажуулдаг талаар ОБЕГ-ын алба хаагчид ярьж байсныг судалгааны тайланд дурдах нь зүйтэй. Жишээлбэл: дэлхий нийтийг хамарсан цар тахал коронавируст халдвар /Ковид-19/-ын үед хамгаалах хувцас хэрэгсэл, эм ариутгалын бодис, эмнэлгийн зориулалттай автомашин техник, шатахуун гэх мэт олон төрлийн бараа, материалыг цаг, минут алдалгүйгээр улсын нөөцөөс гаргаж байсан байна. Практикт цөөнгүй тохиолддог энэ үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн зорилтыг⁴⁰ хангаж байгаа боловч Улсын нөөцийн тухай хуулийг зөрчсөн үйлдэл болно.

Иймд яаралтай, хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд улсын нөөцөөс бараа, материал гаргах /зарцуулах/-тай холбоотой зохицуулалтыг улсын нөөцийн тухай хуульд тусгах нь зүйтэй гэж дүгнэлээ.

3.16 Улсын нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих;

16.1.2.улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

16.1.3.орон нутгийн нөөцийг бүрдүүлэх талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал өгөх.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 60, 63 дугаар зүйлд Аймаг, Нийслэлийн засаг даргын засаг даргын бүрэн эрхийг хуульчилж өгсөн.

Уг хуулийн 60.1.1-д “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах; 60.1.13-д гамшиг, осол,

³⁸ ОБЕГ-ын даргын 2019 оны А/397 тушаалын хавсралт

³⁹ ОБЕГ-ын даргын 2010 оны 217 дугаар тушаалын хавсралт

⁴⁰ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 хэсэг

аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, **хүнс тэжээлийн нөөцийг дайчлах...**” бүрэн эрхийг аймгийн засаг даргад, 63.1.1-д хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах бүрэн эрхийг Нийслэлийн засаг даргад тус тус олгожээ.

“Хүнс тэжээлийн нөөцийг дайчлах” бүрэн эрхийг аймаг, сумын Засаг даргад хуулиар олгосон нь Улсын нөөцийн тухай хуульд заасан гамшгийн болон орон нутгийн нөөцийн бараа, материалд хамаарах эсэхийг тодорхойлж өгөөгүй нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

Мөн Улсын нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих” эрхийг олгосон боловч уг эрхийг хэрхэн яаж хэрэгжүүлэх нь мөн адил тодорхойгүй байна.

Улсын нөөцийн тухай хуульд нөөцийн ангилалд орон нутгийн нөөцийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх ажлыг зохицуулсан заалт байхгүй байна. /тайлангийн “улсын нөөц, түүний зохицуулалт” хэсгээс үзнэ үү/

Хуулийн 16.1.3-т орон нутгийн нөөцийг бүрдүүлэх талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал өгөх гэж тусгасан авч үүний мөрөөр хийгдсэн ажил, статистик дүн мэдээ байхгүй байгаа нь орон нутгийн нөөцийн асуудлын эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны менежментэд онцгой анхаарах шаардлагатайг илэрхийлж байна. Учир нь орон нутгийн нөөц гэдэг нь зөвхөн малын өвс, тэжээл биш гэдэг нь улсын нөөцийн тухай хууль тогтоомжоос тодорхой харагдаж байгаа болно.

3.17 Улсын нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйл. Улсын нөөцийн салбарын үүрэг, хэрэгжилтийн үр дагавар

17.1.Улсын нөөцийн салбар дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1.нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах;

17.1.2.онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх, тээвэрлэж хүргэх үйл ажиллагааг эрхлэх;

17.1.3.нөөцийн бараа, материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээ, санхүүжилтийн тайланг сар, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

17.1.4.нөөцийн бараа, материалыг зарцуулах, бүрдүүлэхийн өмнө болон хадгалалтын явцад жилд 1-2 удаа чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг гаргуулж, холбогдох арга хэмжээ авах;

17.1.5.нөөцийн бараа, материалыг хадгалах барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг гаргуулсан байх.

Хуулиар нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах үүргийг⁴¹ улсын нөөцийн салбар буюу ОБЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж хүлээсэн.

“Журам батлах тухай” Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/397 дугаар тушаалын хавсралтаар “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод журам”-ыг баталсан.

Уг журмын 4.6 дахь хэсэгт “Гадна болон дотор харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэл, хяналтын камер, гэрэлтүүлэг, сум, галт зэвсэг болон түүнтэй адилтгах хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт” зэрэг харуул, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулсан доорх заалтууд байна. Үүнд:

4.6.1.Харуул нь агуулах, сав, тоног төхөөрөмжийн лац, холбоо дохионы хэрэгсэл, камер, гэрэлтүүлэг, сум, галт зэвсэг, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд хогшлыг нэг бүрчлэн хүлээлцэж, тэмдэглэл хөтөлсөн байдал;

4.6.2.Галт зэвсэг болон тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалт хамгаалалт;

4.6.3.Объектын 24 цагийн камерын хяналтын бүртгэл хөтлөлт;

4.6.4.Объект руу нэвтэрсэн хүн, автомашин, техник хэрэгсэл, бараа, материалын хөдөлгөөний бүртгэл хөтөлсөн байдал;

4.6.5.Харуулын рапортын дэвтэрт 24 цагийн үүрэг гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тэмдэглэсэн байдал гэх зэргээр дотоод хяналттай холбоотой асуудлыг зохицуулсан боловч, улсын нөөцийн бараа, материалыг хадгалж буй объект, байршил дахь харуул хамгаалалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Өөрөөр хэлбэл харуулын улсын нөөцийн бараа, материалыг хамгаалах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам албаны хэмжээнд байхгүй байна.

Тухайлбал: Харуул нь хэдэн цагаар үүрэг гүйцэтгэх, хэрхэн ээлж солилцох, хэн ээлжийг хүлээлцүүлэх, яаж хяналт тавих, аливаа халдлага учирсан тохиолдолд харуул ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, өөрийгөө болон объектын аюулгүй байдлыг хамгаалахад биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхтэй эсэх зэрэг асуудал зохицуулалтгүй орхигджээ.

Харин улсын нөөцийн салбарын харуулын ажилтанд ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт байна.

Дархан-Уул аймаг дахь Онцгой байдлын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/08 дугаар тушаалын хавсралтаар “Онцгой байдлын газрын 3 дугаар ангийн Харуулын албаны дүрэм”-ийг батлан мөрдөж байна. Хэдийгээр аймгийн Онцгой байдлын газрын даргад харуулын албаны дүрмийг батлан гаргах эрх хуулиар олгогдоогүй ч нөөцийн бараа, материалын аюулгүй байдлын хангах хуулийн үзэл баримтлалтай нийцэх, санаачилгатай ажил гэж үзэхээс өөр аргагүй юм. Харин эрх зүйн хэм хэмжээг хуульд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтан батлан гаргах, ийм төрлийн журмыг батлан гаргах эрхийг хуулиар эрх бүхий этгээдэд даалгах асуудлыг анхаарч, судлан шийдвэрлүүлэх хэрэгтэй.

Улсын нөөцийн тухай хуулиар нөөцийн бараа, материалыг аливаа халдлага, эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах асуудлыг нарийвчлан зохицуулаагүй

⁴¹ Улсын нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэг

тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нөөцийн агуулах, барилга байгууламжийг улсын онц чухал объектод авах эсэхийг шийдвэрлүүлж болох юм.

Судалгааны баг нөөцийн бараа, материалын хамгаалалтыг сайжруулах бодит хэрэгцээ, шаардлагатай байна гэж үзсэн бөгөөд судалгааны тайлангийн дүгнэлт, зөвлөмжид дурдсан арга хэмжээг зохион байгуулснаар нөөцийн бараа, материалын хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлын түвшин тодорхой хэмжээгээр хангагдах ач холбогдолтой.

ОБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/173 дугаар тушаалаар “Онцгой байдлын ерөнхий газар болон салбар, нэгжийн хугацаат мэдээг тайлагнах, дүгнэх журам”-ыг баталжээ.

Уг журмын 2.24-д Улсын нөөцийн тайлан мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2010 оны 217 дугаар тушаалаар батлагдсан “Улсын нөөцийн бараа материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого явуулах журам”, “Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам”-нд заасны дагуу Улсын нөөцийн салбар тайлангаа УНГ-т ирүүлж байна.

Улсын нөөцийн салбар, анги нь нөөцийн бараа, материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээ, санхүүжилтийн тайланг хуульд заасан хугацаанд гаргаж төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүргээ зохих ёсоор гүйцэтгэж хэвшсэн зэрэг нь хуулийн энэ зүйлийн хэрэгжилтийг хэвийн гэж үзэх үндэстэй.

Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаа одоогийн хууль, эрх зүйн орчинд сайн ажиллаж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн цөм асуудлын хүрээнд хууль, эрх зүйн болон дэд бүтэц, орон тоо, зохион байгуулалтын бүтцийг чадавхжуулах шаардлагатай.

3.18 Улсын нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Улсын нөөцийн бүрдүүлэх, хадгалахтай холбогдуулан гэрээ байгуулсан этгээдийн хүлээх эд хөрөнгийн хариуцлага, хэрэгжилтийн үр дагавар

18.1.Нөөцийн бараа, материал нийлүүлэх болон эргэн төлөгдөх нөхцөлөөр авах хуулийн этгээд, гэрээт хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол энэ хууль болон тухайн гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

18.2.Гэрээнд хариуцлага хүлээлгэх дор дурдсан нөхцөлийг заавал тусгасан байна:

18.2.1.нөөцийн бараа, материалыг заасан хугацаанд нийлүүлээгүй бол;

18.2.2.нөөцийн бараа, материалыг дутуу нийлүүлсэн бол;

18.2.3.стандартын шаардлагыг хангаагүй бараа, материал нийлүүлсэн бол;

18.2.4.нөөцийн бараа, материалын сав, баглаа, боодол нь гэмтсэн буюу шаардлага хангаагүй бол;

18.2.5.нөөцийн бараа, материалыг эргэн төлөгдөх хугацаанд нь нийлүүлээгүй бол;

18.2.6.нөөцийн бараа, материалыг үрэгдүүлсэн, чанар байдлыг нь муутгасан бол;

18.2.7.талууд тохиролцон гэрээнд тусгасан бусад нөхцөл зөрчигдсөн бол.

“Улсын нөөцийн бараа материалын хөдөлгөөнд тавих дотоодын хяналтыг зохион байгуулах тухай” ОБЕГ-ын даргын 2008 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 224 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар нөөцийн хэлтсийн чиглэл хариуцсан мэргэжилтнүүдийн хариуцах салбар, гэрээт хадгалагч байгууллагуудын жагсаалтыг, 2

дугаар хавсралтаар Улсын нөөцийн бараа материалыг сэлгэн шинэчлэх гэрээний жишиг загварыг, 3 дугаар хавсралтаар Улсын нөөцөөс бараа материал зээлээр олгох гэрээний жишиг загварыг, 4 дүгээр хавсралтаар Улсын нөөцийн бараа материалын хадгалалтын гэрээний жишиг загварыг, 5 дугаар хавсралтаар Улсын нөөцийн өвс, тэжээлийг тээвэрлэн байршуулах гэрээний жишиг загварыг, 6 дугаар хавсралтаар Улсын нөөцөөс бараа материал гаргах болон хүлээн авах зөвшөөрлийн хуудасны загварыг, 7 дугаар хавсралтаар Нөөцийн бус бараа материалыг гаргах болон хүлээн авах зөвшөөрлийн хуудасны загварыг, 8 дугаар хавсралтаар Гэрээ, зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулах албан тушаалтныг тус тус баталсан байна.

Уг тушаалаар улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх, тээвэрлэн хүргэх үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийн дагуу Улсын нөөц, сэргээн босголтын газраас/ хуучин нэршлээр/ олгосон зөвшөөрлийг үндэслэн хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутаг дахь улсын нөөцийн салбарын дарга нарт үүрэг болгожээ.

Стратегийн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэхдээ нийлүүлэгч талтай Онцгой байдлын ерөнхий газрын дарга “худалдах, худалдан авах” маш нууц гэрээг байгуулан авч байгаа бөгөөд уг гэрээнд хуульд заасан нөхцөлүүдийг агуулгын хувьд тусгасан байна.

Гамшгийн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх гэрээг төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журмын дагуу бусад баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж хуулийн 18.2-т заасан нөхцөлүүдийг агуулгын хувьд тусгажээ.

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

“... Жилд 5 орчим этгээдэд холбогдох 200 орчим сая төгрөгийн гэрээний үүргээ биелүүлээгүйтэй холбоотой маргаан гардаг, ихэвчлэн урьдчилгаа 30% ийн төлбөр төлж барааг авсан боловч үлдэгдэл 70%-ийг төлөөгүй эсхүл хугацаандаа бараагаа сэлгэн шинэчлээгүйтэй холбоотой байдаг. Иймд...гэрээний заалтуудыг нарийвчилж тодорхой болгох шаардлагатай...” гэжээ.

ОБЕГ-ын даргын 2008 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 224 дүгээр тушаалын хавсралтаар баталсан нөөцийн бараа, материалыг зээлээр олгох болон хадгалалтын гэрээний загваруудад хуульд тодорхой заасан нөхцөлүүдийг нэг бүрчлэн тусгаагүй байгаа тул гэрээний загварыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлах нь зүйтэй гэж дүгнэлээ.

3.19 Улсын нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтийн үр дагавар.

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Улсын нөөцийн тухай хуульд хууль зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан. Гэвч хууль өөрөө хэрэгжих нөхцөлөө бүрдүүлсэн процессын хэм хэмжээний зохицуулалтаар дутмаг байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаагаар тогтоогдож байна. Тэрчлэн улсын нөөцийн хууль тогтоомж нь зөвхөн энэ хуулиар хязгаарлагдахгүй тул хуулийн 19 дүгээр зүйлийг “Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэх нь тохиромжтой.

Хуулийн 19.1-т хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заажээ. Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл нь улсын нөөцийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт, байгууллагын үйл ажиллагааны журам байх учиртай. Хуулийн хэрэгжилтийг хангах төрийн захиргааны байгууллага нь хууль эрх зүйн бусад актаар хүлээсэн чиг үүргийг дотоодоо хэрхэн гүйцэтгэх, алба хаагч албан тушаалтны эрх үүргийг тодорхой зааж, хориглосон, зөвшөөрсөн үйлдэл, үйл ажиллагааны дарааллыг тогтоосон иж бүрэн үйл ажиллагааны журам /системчилсэн/ гаргаснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэнэ. ОБЕГ-ын хувьд улсын нөөцтэй холбоотой хууль тогтоомжийн хүрээнд захиргааны дотогшоо чиглэсэн дүрэм, журам, заавар хангалтгүй байна.

Хуулийн 19.1.2-т Улсын нөөцийн хуулийг зөрчсөн хүн хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Тус хууль батлагдан гарснаас хойш улсын нөөцийн тухай хууль зөрчсөн гэж __ хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн, __ хүнд Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн тоо статистик байна. Энэ нь хууль зөрчигдөх нөхцөл харьцангуй бага байгааг илэрхийлж байна.

ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ХЭСГЭЭС

Сүүлийн 2 жилийн хугацаанд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж улсын нөөцийн бараа, материалыг хувьдаа завшсан 2 хэрэг хуулийн байгууллагаар шалгагдаж 1 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, 1 хэрэг прокурорын шатанд хянагдаж байгаа...

ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТААС...

Гамшиг, аюулт үзэгдлийн /байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй, үзэгдэл тохиолдол болон ноцтой осол багтана/ үед ашиглах нөөцийн бараа, материалын хууль тогтоомж, гамшгаас хамгаалах улс орнуудын бодлогын бичиг баримт, тогтоосон менежментийн талаарх судалгаанд хамруулж чадсан материалаас зарим шаардлагатай гэж үзсэн мэдээллийг оруулав.

Гадаад улс орнуудын нийгэм эдийн засгийн байдал, газар зүйн байрлал, улс төр, хууль эрх зүйн тогтолцоо, хүн ам, үйлдвэрлэл технологийн хөгжил зэрэг олон хүчин зүйл онцлогоос хамааран Улсын нөөцийн тухай хууль, эрх зүйн тогтолцоо өөр хоорондоо харилцан адилгүй байна. Өөрөөр улсын нөөцийн талаар зарим улс бие нэг хуультай байхад зарим нь хэд хэдэн хуультай байх, зарим улсад гамшгаас хамгаалах тухай хуульд, зарим улсад гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд хүн амд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, гамшигт хариу арга арга хэмжээ авах хуулиар нөөцийн асуудлыг давхар зохицуулсан байна. Холбооны улс, эсвэл газар нутаг хүн ам ихтэй улсуудад нийгмийн салбар тус бүрт нь, эсхүл засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжээр нь гамшгийн нөөцийг хариуцуулсан байна.

Нөөцийн бараа материалын хууль, эрх зүйн зохицуулалтын хувьд хэдийгээр ижил формат байхгүй ч гамшгийн бэлэн байдлыг хангах болон гамшгийн үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх гэсэн хоёр ухагдахуун дор зохицуулагдаж байна. Өөрөөр хэлбэл Гамшгийн бэлэн байдлыг хангах ухагдахуун **Disaster preparedness** болон **Disaster response or Emergency response** гамшгийн үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх ухагдахуун гэсэн 2 төрөл дээр нөөцийн бараа, материалын хууль

эрх зүйн болон менежмент үйл ажиллагаа ижил төстэй олон улсын стандарт, нийтлэг эрх зүйн зохиуулалтын хэв шинжтэй болжээ.

Үүнийг нотлох олон жишээг бие даасан улс орнуудын гамшгаас хамгаалах тухай хуулиас харж болохоос гадна олон улсын хамтын нийгэмлэг, байгууллагуудаас гаргаж буй гамшгаас хамгаалахтай холбоотой олон бичиг баримтуудаас харах боломжтой. Түүний нэг нь Нэгдсэн үндэсний байгууллагын гамшгийн эрсдлийг бууруулах газраас зохион байгуулсан Гамшгийн эрсдлээс бууруулах дэлхийн 3 дугаар бага хурлаас гаргасан Сендайн үйл ажиллагааны хүрээ хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрөөр улс орнуудыг 2015-2030 он хүртэл гамшгийн эрсдлийг бууруулах хүрээнд хийх ажлын тэргүүлэх чиглэл, зорилтуудыг тодорхойлж өгсөн нь улс орнуудын гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгаас хамгаалах ажлыг хүрсэн түвшнээс дахин нэг урагш алхах, нэг ойлголт, стандартаар гамшигт бэлэн байх ажлыг зохион байгуулж байгаа билээ. Манай улсын хувьд Сендайн үйл ажиллагааны хүрээ бичиг баримтын дагуу тодорхой ажлуудыг хийж тодорхой ахиц дэвшлийг гаргаж байна.

Олон улсын жишгээр гамшгийн нөөц нь гамшигт бэлэн байдлыг хангах **/proactive/** гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх хариу арга хэмжээ авах **/reactive/** үед ашиглах зориулалтаар бэлтгэгдэж, хадгалагдах гамшгийн бэлэн байдлыг хангаж байна.

Улс орнууд гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд бэлэн байх нөөцийг дээр дурдсан хоёр ухагдахууны хүрээнд авч үзэн тус тусад нь эрх зүй, үйл ажиллагааны удирдлага, менежментийн тогтолцоог хөгжүүлж байна.

Америкийн нэгдсэн улсын /USA/ жишээг авч үзвэл:

Гадаад орнуудад нөөцийн бараа, материалыг ангилахдаа нэгдүгээрт: байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай аливаа гамшиг, цар тахлын үед хүний амь нас эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнсний наад захын хэрэглээг хангахад бэлэн байлгах, хоёрдугаарт: гамшгийн хор уршгийг бууруулах, арилгах, нийгмийн амьдралыг хэвийн горимд оруулахыг гол зорилго болгон тоо хэмжээг бууруулж үл болох нөөц, гуравдугаарт: бусад буюу тоо хэмжээг бууруулж, нэн шаардлагагүй үед нөөцөөс хасаж болох төрөл гэж ангилж байна. Онцгой байдлын байгууллага нь гамшгийн үед хүн амыг зайлшгүй хэрэгцээт хүнсээр хангах үүднээс нөөц бүрдүүлж, мөн Хүнс, эмийн агентлагтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд нөөцийн бараа, материалыг бүрдүүлдэг байна.

Нөөцийн тухай ойлголт, түүний тодорхойлолтоор гамшгийн бэлэн байдлыг хангаж, гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдолд яаралтай тусламж үйлчилгээнд зориулагдсан, тэргүүлэх зорилго нь хүн амын амь, эрүүл мэндийг аврах, амьдралын наад захын хэрэгцээг хангах зүйлсээс эхлэн харилцаа холбооны хэрэгсэл, тээвэр ложистик, хүний нөөцийн буюу гамшгийн үед ажиллах мэргэшсэн алба хаагч, эмч, эмнэлгийн ажилтнууд, тээвэр, хүргэлтийн зохицуулагч, сайн дурын туслах ажилтнуудыг оруулж байна. Эдгээрээс бараа материалтай хамраалтай хэсгийг зориулалт ангилалын тодорхойлолтоор авч үзвэл:

Нэн шаардлагатай хангамж: Хүнс, ус, эм, эрүүл--ахуйн багц дулаан, түлшний эх үүсвэр болох зүйлс тухайлбал хоргодох байранд нэрвэгдэгсдийг байрлуулсан үед хоол, унд хийхэд шаардлагатай хийн зуух, халаагуур гэх мэт,

Аврах болон эм, эмнэлгийн материал: дамнуурга, дефибрилятор--зүрхэнд цахилгаан цохилт өгөгч төхөөрөмж, хүн бүрт өгөх эмийн багц зэрэг,

Хоргодох байрны /газрын/ хангамж майхан, хөнжил, гудас, зөөврийн жорлон зэрэг бараа, материалууд орж байна. /Shelter Materials гэдэг, зөвхөн хоргодох байранд байхад хэрэглэгдэхгүй/

Гамшгийн бараа, материалыг нөөцлөн хадгалахад:

– Эрсдлийн үнэлгээ, болон эрсдэл, аюулын зураглал (Тухайлбал, газар хөдлөлт, үер, халдварт өвчин, цар тахал зэрэг)

Хүн амын судалгаанд үндэслэсэн хэрэгцээ (хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлт иргэдийн судалгаа тоо зэргийг)

Нөөцлөн хадгалсан бараа ямар хугацаанд хангалт, тусламж үйлчилгээ болж чадахыг тооцсон байдал зэрэг судалгаа, хэрэгцээг тодорхойлсон тооцоололд үндэслэж нөөцийн бараа материалын нэр төрөл, тоо хэмжээг тогтоож байна.⁴²

Нөөцлөн хадгалах бараа, материалыг АНУ-ын Засгийн газрын хөрөнгөөр Холбооны нөөцийн бараа материалыг, Муж бүр өөрийн орон нутгийн засгийн газрын хөрөнгөөр гамшгийн буюу орон нутгийн нөөцийг, Төр-хувийн хэвшлийн түншлэлээр (үүнд ханган нийлүүлэгч үйлдвэрлэгч, бөөний худалдааны компани аж ахуй нэгж, мөн агуулахын биенес эрхлэгч компаниуд орно)

Нөөцийн агуулахыг гамшгийн эрсдэлтэй газар нутаг, байгууламжын ойролцоо, мөн гамшгийн үед нөөцийн бараа материал (ер нь яаралтай тусламж үйлчилгээ орох замын орц) орох замыг тооцоолох зэргээр нөөцийн бараа материалын байршлыг тогтоож байна.

Гүрж /Georgia⁴³/ улсын жишээг сонгон авч үзвэл:

Тус улс нөөцийн бараа, материалыг нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг хадгалах байршлыг тогтоох зэрэгт мэргэжлийн байгууллагуудын оролцоо тодорхой, судалгаа шинжилгээнд тулгуурладаг байна. Гүржийн улсын нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Улсын нөөц болгон хуримтлуулах бараа, материалын жагсаалтыг Улсын нөөцийн газар нь Эдийн засаг, тогтвортой хөгжлийн яамтай зөвшилцөн гаргаж, Засгийн газраар батлуулахаар өргөн барина” гэжээ. Түүнчлэн улсын нөөцөд бараа, материал хуримтлуулах буюу нөөц бүрдүүлэх төсвийг тухайн жилийн улсын төсөвт тусгайлан батална” гэж хуульчилсан байна.

Тус улсын нөөцийн тухай хуулийн 6-р зүйлд “Улсын нөөцийн хөгжүүлэх болон арчлалт, үйлчилгээний зардлыг нь улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан. Мөн улсын нөөцийн харилцаанд гарах зардлыг нөөцийн бараа материалыг зээлдүүлснээс болон торгууль, гэрээний алдангиас орж ирсэн орлогоор төсөв, санхүүгийн бусад хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ. Улсын нөөцийн бараа материалыг хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох, арчлалт үйлчилгээ, хамгаалалт, чанар байдлыг хангуулахтай холбоотой бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж тус заасан нь онцлог байна.

Гүрж улсын нөөцийн тухай хуульд тусгагдсан бараа, материалын арчлалт үйлчилгээ гэдэг нь бусад улс орны ялангуяа барууны улс орнуудын нөөцийг сэлгэх

⁴² АНУ-Вашингтон мужын <https://mil.wa.gov/emergency-management-division>

⁴³ Эх сурвалж: <http://extwprlegs1.fao.org/docs/pdf/geo200042.pdf>

журам /нөөцийн бараа, материалыг хадгалах, сэлгэх хэсгээс олон улсын стандарт тайлбарыг үзнэ үү/ стандарттай адилхан гэж ойлгогдож байна.

БНХАУ-ын /China/ жишээг сонгон авч үзвэл:

БНХАУ-д гамшиг, аюулт үзэгдэл, хамрах хүрээ өргөнтэй том ослоос урьдчилан сэргийлэх, яаралтай хариу арга хэмжээ, тусламж үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн хэд хэдэн хуулиуд үйлчилж байна.

Гамшгаас хамгаалах, гамшгийн бэлэн байдлыг хангах, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, аврах ажиллагааг зохицуулсан хууль болох Emergency Response Law of China⁴⁴ 2007 онд батлагдсан ба хамгийн сүүлд 2023 онд нэмэлт өөрчлөлт оржээ. Уг хуулиар гамшиг, аюулт үзэгдлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, гамшиг тохиолдсон үед аврах, эрэн хайх зэрэг үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллага, засаг, захиргаа нутаг дэвсгэрийн эрх мэдэл, Хятадын төв засгийн газрын эрх, үүрэг зэргийг тодорхой хуульчилсан байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн төрөл бүрээр боломжит хувилбар болгоноор гаргах, тэрхүү төлөвлөгөөндөө гамшгийн нөөцийг бэлтгэх, хадгалах, бэлэн байх үүргийг муж, орон нутгийн болон хотуудын удирдагуудад үүрэг болгожээ. Онцлог нь тосгон, /сумтай ойролцоо/ нэгжүүдэд түүнчлэн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад гамшгийн нөөцтэй байхыг хуулиар үүрэг болгоогүй, харин нөөцтэй байх, гамшигт бэлэн байх асуудлыг уриалан дэмжсэн, тийнхүү нөөц бэлтгэх, хадгалах зэргээр гамшгийн бэлэн байдлыг хангасан иргэд, хуулийн этгээдийг төрөөс урамшуулж байхаар хуульчилсан байна.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдлийг бууруулах тухай хууль /Law on the Protection Against and Mitigation of Earthquake Disasters⁴⁵ (1997)/ Үерийн хяналтын хууль (1997) /Flood Control Law⁴⁶/, үйлдвэрлэлийн болон ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай /Production Safety law⁴⁷/ зэрэг хуулиудаар гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшгийн үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бараа, материалыг нөөцлөн хадгалах үүргийг нийгмийн салбар, засаг захиргааны муж, хот тус бүрт үүрэг болгон хуульчилжээ.

Харин дээрх хуулиудын зорилго, зохицуулах харилцаа нь гамшгийн төрөл бүрээр ялгагдах учраас нөөцийн бараа, материалын нэр төрлийн шаардлагыг хуульд нийцүүлэн бэлтгэх үүрэгтэй байна. Жишээ нь: Үерийн хяналтын хуульд томоохон гол мөрний ойролцоо, эсвэл эрсдлийн үнэлгээгээр шаардлага нь тодорхой болсон газрын ойролцоо аврах завь, усны насосууд, аврах материалууд, элсний уут, шуудай зэргийг нөөцийн бараа материалын нэр төрөлд оруулан гамшгийн бэлэн байдлыг хангадаг байна.

Япон /Japan/ улсын жишээг сонгон авч үзвэл:

Гамшгийн эрсдлийг бууруулах тухай хууль /Japan's Disaster Relief Act⁴⁸/ болон Гамшгийн менежментийн хууль /Basic Act on Disaster Management⁴⁹/ хуулиудаар

44

https://english.mee.gov.cn/Resources/laws/envir_elatedlaws/201705/t20170514_414040.shtml?utm_source=chatgpt.com

45 <https://www.asianlii.org/cn/legis/cen/laws/paamed498/>

46 <https://www.asianlii.org/cn/legis/cen/laws/fcotproc394/>

47 <https://www.lawinfochina.com/display.aspx?lib=law&id=2387>

48 <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4174/en>

49 <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4171>

гамшгийг бэлэн байдлыг хангах, гамшгийн нөөц бүрдүүлэх, хадгалах харилцааг зохицуулж байна. Мөн их хэмжээний, хүчтэй газар хөдлөлтийн эсрэг тусгай арга хэмжээний тухай хууль /Act on Special Measures for Large-Scale Earthquakes⁵⁰ /-иар гамшгийн бэлэн байдал, яаралтай тусламж үйлчилгээ, нөөц бэлэн байдлыг хангах талаар зохицуулсан байна.

Япон улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь маш сайн боловсруулалттайд тооцогддог ба гамшгийн бэлэн байдлын нөөцийг ялангуяа хүн амын амь нас, эрүүл мэндийг аюулаас аврах яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх тооцоолол сайтай бараа, материалыг нөөцөлдөг байдал нь хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартуудын сайн туршлагаас интернэт орчноос мэдээлэл авах боломжтой байна. Тухайлбал, далайн хүчтэй шуурганы гамшиг, газар хөдлөлтөөс үүссэн гамшгийн яаралтай тусламжийн бэлтгэл нөөцөд цагаан будаа, хатаасан хүнс хоол, лаазалсан хүсний бүтээгдэхүүнийг 1 хүнд 7-10 хоногийн хэрэгцээгээр, 1 хүнд өдөрт 3 литр ундны цэвэр ус гэж тооцож гамгийн нөөцийн бараа, материалын нөөцийг хадгалж байна.

Япон бусад орны хууль, тэдгээрт нийцүүлсэн гаргасан журам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой гарын авлага материалаас үзэхэд гамшгийн нөөцийг гадаад улс орнуудад ижил төстэй ангилал, категорин дагуу нөөцлөн хадгалж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 Дүгнэлт, зөвлөмж

Улсын нөөцийн бараа, материал нь гамшиг, аюулт үзэгдлийн үед хүн амын амь нас эрүүл мэндийг нэн тэргүүнд аврах, хохирол цар хүрээг тэлэхээс хязгаарлан, гамшгийн хор уршгийг арилгах яаралтай хариу арга хэмжээ авах үед болон гамшиг, аюулт үзэгдлийн дараа тухайн газар орон зайд нэрвэгсдэд тусламж үйлчилгээг үзүүлэх, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад ашиглагдах учиртай. Монгол Улсын УИХ-аас батлан, мөрдүүлж буй Улсын нөөцийн тухай хуульд улсын нөөц, түүний ашиглах нөхцлийг тодорхой хуульчлан заажээ.

Улсын нөөцийн бараа, материалын ангилал /батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад/-аар стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийн ашиглалт, түүний бүрдүүлэлт буюу нөөцлөн хадгалах, шинэчлэх, сэлгэх зэрэг үйл ажиллагааны тогтолцоо, үйл ажиллагааны удирдлагыг хууль эрх зүй, үйл ажиллагааны менежмент, шинжлэх ухаанд суурилсан инновац, технологийг цаашид тогтвортой хөгжүүлж ажиллах нэн шаардлагатай байна.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд гамшиг, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, эрэн хайх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбоотой их үйлст багагүй ахицтай ажиллаж, зарим тохиолдолд ялангуяа дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үед багагүй сорилттой нүүр тулж, мөн тэр хэмжээгээр туршлага хуримтлуулж ажилласан.

Ялангуяа гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд гамшгаас хамгаалах тогтолцоо, төр, олон нийтийн оролцоо, нутгийн захиргааны байгууллагуудын хүлээх

⁵⁰ <https://agupubs.onlinelibrary.wiley.com/>

үүрэг, оролцоо, үйл ажиллагааны дэг журам харьцангуй хэмжээнд ололт амжилттай гэж судлаачид үзлээ.

Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги болох Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн зорилгыг “Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх”⁵¹ гэж тодорхойлсон.

Мөн УИХ-аас гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн хуульд өөрчлөлт оруулсантай шууд хамааралтайгаар болон гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд чухал ач холбогдолтой эрх зүйн акт, бичиг баримтууд гарчээ. Тухайлбал Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг баталжээ. (2018 оны 02 дугаар сарын 07-ны 120 тоот тушаал)

Гэвч гамшгаас хамгаалах талаар гаргаж батлагдан гарч буй хууль тогтоомж, эрх зүйн бусад актууд практик амьдрал дээр хэрхэн хэрэгжих боломжтой, эсвэл хэрэгжиж байгаа вэ гэдэг нь хамгийн түрүүнд анхаарах асуудал байна.

Дэлхийн улс орнууд гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах тал дээр цаг алдалгүй зарлан мэдээлэхээс эхлэн өөр хоорондоо үялдаа үр дагавар бүхий олон талт хамтын ажиллагаа, нэгдмэл зорилготой, хичээл зүтгэлтэй ажиллахыг улам бүр уриалж байна. Түүний нэг нь Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг мөн. Энэхүү баримт бичгээр улс орнууд гамшгийн эрсдлийг бууруулахад хууль эрх зүйг хөгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийж сайжруулахыг орон нутгийн болон үндэсний түвшинд хийх, түүнчлэн бусад эрх зүйн акт, журам зааврыг боловсруулах, бодлогын болон эрх зүйн шинэчлэл хийх нь чухал ач холбогдолтойг уриалсан.

Хэдийгээр гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдлийг бууруулах ажил нь өргөн хүрээний ажил боловч улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд харилцан хамааралтай байх тул судлаачид энэ талаар хязгаарлагдмал хүрээнд давхар судалгаа хийж ажилласан болно.

Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх тухай асуудал дээр авч үзэхэд гамшгийн бараа, материалыг ямар шалгуур үндэслэл, судалгаанд тулгуурлаж бүрдүүлэн авч, нөөцлөн хадгалахдаа баримталдаг шинжлэх ухааны, бодлогын болон эрх зүйн арга зүйд суурилсан менежмент сул байна.

Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар зэрэг эрх зүйн бичиг баримтын хүрээнд тухайлбал, гамшгийн эрсдлийн тойм судалгаа, ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийдэг эрх зүйн орчин, практик тогтож эхлээд байна. Гэвч тэдгээр гамшгийн эрсдлийн үнэлгээнд суурилж тодорхой нутаг дэвсгэрт, аймаг, нийслэлд гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлж байгаа журам, заавар, аргачлал болон үйл ажиллагааны практик алга байна. Өөрөөр хэлбэл гамшгийн эрсдлийн удирдлагыг хөгжүүлэх шаардлагатай. Гамшгийн эрсдлийн удирдлага гэдэг

⁵¹ /https://drive.google.com/file/d/1jw8a-BI_0fpuofoqygnxK239_gds5uAS/view?usp=sharing/

нь хууль, эрх зүйн, дүрэм, журам, улсын болон, засаг, захиргааны нутаг, дэвсгэрийн, шинжлэх, ухааны болон боловсролын, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн оролцоо зэргийн оролцоо бүхий үйл ажиллагааны хүрээ, тогтолцоо юм.

Улсын нөөцийн тухай хууль 2007 онд батлагдсанаас хойш 15 жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй байна. ОБЕГ-ын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодит хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг судлах ажлыг төлөвлөн ажиллажээ.

ОБЕГ-нь улсын нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг нөөцийн салбаруудаар дамжуулан зохих түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч практик үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг улам бүр сайжруулах үүднээс “Улсын нөөцийн тухай хууль-”ийн хэрэгжилтийн үр дагаварт Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу үнэлгээ хийн Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж, дараах дүгнэлт зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Улсын нөөцийн тухай хуулиар улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах, гамшгийн болон орон нутгийн гэж ангилсан. Эдгээрээс батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийг энэ хуулиар зохицуулсан ба стратегийн нөөцийн нэр төрлийг тогтоох эрхийг УИХ-д, гамшгийн нөөцийн нэр төрлийг тогтоох эрхийг Засгийн газарт, орон нутгийн нөөцийн нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн тогтоох эрхийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн /Монгол Улсын Шадар сайд/-д тус тус олгосон байна. Гэвч хуулиар олгогдсон эрх ямар арга замаар хэрэгжих нь тодорхойгүй, нарийвчлан зохицуулаагүйгээс практик дээр ОБЕГ / бүтцийн нэгж УНГ-аар дамжуулан/ улсын нөөцийн бараа, материалын нэр төрлийн саналыг гаргаж, шийдвэр гаргах эрх бүхий субъектэд өгөх үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Ийнхүү нөөцийн бараа, материалын нэр төрлийг гаргахдаа хуульчилсан дүрэм, журам, аргачлалгүй түүнчлэн эдийн засгийн мэргэжлийн байгууллагын хамтын оролцоогүй ажиллаж байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах боломжийг хязгаарлаж байна гэж дүгнэлээ.
2. Нөөцийн бараа, материалын байршил, тоо хэмжээг тодорхойлох, тооцоо судалгаа хийх үйл ажиллагааг ОБЕГ-аас гүйцэтгэн, Монгол Улсын шадар сайдад танилцуулж, уламжлуулан Засгийн газрын шийдвэр гаргуулж байгаа үйл ажиллагаа нь улсын нөөцийн тухай хуульд заасан онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахгүй байна. Мөн тогтоосон аргачлалгүй, шинжлэх ухааны судалгааны арга зүйгүй, мэргэжлийн эдийн засагч болон худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоогүйгээр гүйцэтгэж байна. Иймд нөөцийн бараа, материалын хэрэгцээ шаардлага нэр төрөл, тоо хэмжээ, байршлын талаар тооцоо судалгаа хийх, албажуулах үйл ажиллагааг хариуцах этгээд, түүний процессыг хуульчлан тогтоох нь хуульд нийцнэ.
3. Ийнхүү тухайн хариуцсан этгээд нь улсын нөөцийн бараа, материалын байвал зохих тоо, хэмжээ, нэр төрөл, байршлыг судлан шийдвэрийн төсөл бэлтгэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран судлан боловсруулж байх хууль, эрх зүйн үндсийг тодорхой болгох нь зүйтэй.

4. Улсын нөөцийн салбарууд /одоогийн практикт улсын нөөцийн салбар, анги, цэг гэсэн нэршилтэй/ нөөцийн бараа, материалыг хадгалах үйл ажиллагаанд бараа материалыг сэлгэх, агуулах, /хашаа/ барилга, байгууламжийг арчлах, засвар үйлчилгээ хийх, харуул хамгаалалт зохион байгуулах, ачиж буулгах, зөөх зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэж байна. Гэвч энэ нь ОБЕГ-ын бүтэц, орон тоо, санхүүгийн эх үүсвэр дутмагаас шалтгаалж ихэвчлэн нөөцийн салбаруудын нярав, харуулын ажилтны хүчээр хийж гүйцэтгэж байна. Өөрөөр хэлбэл хуульд дээр дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэхэд орон тоо, санхүүжилтийн эрхийг буй болгосон зохицуулалт хийдэлтэй байна гэж дүгнэлээ. Иймд “нөөцийн бараа, материалыг хадгалах” гэх хуулийн ойлголтыг өөрчлөн найруулах замаар ойлголтыг өргөжүүлэх, хуульд нөөцийн бараа, материалыг хадгалах үйл ажиллагаанд хамрагдах бусад ажиллагааг зохицуулах, шаардлагатай зүйл заалтыг нэмэх шаардлагатай гэж үзлээ.
5. Хуульд зааснаар нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад, стандарт, технологийн горимын дагуу хадгалах, шаардлагатай бол тийм шаардлага хангасан агуулах бүхий гэрээт хадгалагчид гэрээгээр хадгалуулах эрхийг ОБЕГ-т олгосон. Гэвч Улсын нөөцийн тухай хуульд болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актаар улсын нөөцийн зориулалтын агуулах /хашаа/ барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн тусгай стандартыг зааж өгөөгүй байх ба мөн тийм стандартыг батлан гаргах эрхийг эрх бүхий этгээдэд даалгаж эрх олгосон зохицуулалт байхгүй байна. Практик дээр нөөцийн бараа, материалыг хадгалж байгаа агуулах /хашаа/, барилга, байгууламжийн дэд бүтэц, чанар муудсан, насжилт ихтэй, засвар үйлчилгээ тогтмол шаардсан байдалтай байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, түүнчлэн улсын нөөцтэй холбоотой төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт биелэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд улсын нөөцийг хадгалах агуулах, барилга, байгууламжийн стандартын тусгай шаардлагын хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх,
6. Улсын нөөцийн бараа, материалыг сэлгэх үйл ажиллагаа нь өнөөдрийн практик дээр улсын нөөцийн салбаруудын хувьд хууль, эрх зүйн зохицуулалт сул, сэлгэх ажиллагаатай холбоотой хүний нөөц, орон тоо, санхүүжилтийн тодорхойгүй байдалд байна. Улсын нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар улсын нөөцийн салбар нь нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцна. Бараа, материалын чанарыг алдагдуулахгүй байхад сэлгэх ажиллагаа нь хадгалалтын технологийн нэг хэсэг байхын зэрэгцээ түүнд тусгай стандарт, журам, заавар мэргэжилтний байнгын үзлэг шалгалт, зөвлөгөө багтах ёстой. Гэвч нөөцийн барааг сэлгэх ажиллагаанд тэдгээрийг зохицуулсан хуулийн заалт, журам, стандарт байхгүй зөвхөн сэлгэх ажиллагааг агуулах /хашаа/-д байгаа бараа, материалын байршлыг сольж зөөх төдий биеийн хүчээр гүйцэтгэх төдийд ойлгож хэрэгжүүлж байна. Иймд “**сэлгэх**” үйл ажиллагааг хуулийн зорилт хэсэг /хуулийн 1 дүгээр зүйл/-т нэмж оруулах, хуульд сэлгэх үйл ажиллагааны журмыг тусгах,
7. ОБЕГ-аас нөөцийн бараа материалыг шинэчлэх ажиллагааг зохих түвшинд зохион байгуулж байна. Гэвч улсын нөөцийн бараа материалыг **шинэчлэх** ажлын менежментэд эрс өөрчлөлт хийж шинэчлэгдэх зорилгоор нөөцөөс гарч байгаа нөөцийн бараа, материалыг худалдан борлуулах үүргийг зөвхөн ОБЕГ хариуцах бус улсын хэмжээнд худалдаа, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар гадаад улсын тэргүүн туршлагыг судалж нэвтрүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх,

8. Улсын нөөцтэй холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх талаар улсын нөөцийн хууль болон уг хуулийн үзэл баримтлалд тодорхой заасан. Нөөцийн бараа материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулах, нөхөн бүрдүүлэхэд НӨАТ-ын зөрүү гарч байгаа асуудлыг эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, хуульд зааснаар улсын төсвөөс шийдвэрлүүлэх, улсын нөөцийн агуулах, барилга байгууламжийг эдийн засгийн үр ашигтай ажиллуулах, нөөцийн бараа, материалыг бусдад зээлдүүлэх, агуулах савыг түрээсэлж өөрийн орлого бүрдүүлэх замаар зарим зардлыг санхүүжүүлэх хууль, эрх зүйн үндсийг судалж, шийдвэрлэх,
9. Улсын нөөцийн чанар аюулгүй байдлыг хангах, хадгалалтын хугацааг уртасгах судалгаа хийх, үр дүнг практикт нэвтрүүлэх, чанарын болон судалгааны лабораторийг байгуулж, түүний үйл ажиллагааны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх,
10. Улсын нөөцийн тухай хуульд орон нутгийн нөөцийг улсын нөөцийн нэг ангилалд хамруулж, уг нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тухайн шатны эрх бүхий албан тушаалтай зөвшилцөн батлах эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний бүрэн эрх болгон заасан. ОБЕГ-т орон нутгийн нөөцийн асуудлыг мэргэжлийн удирдлагаар хангах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг эрх хэмжээ хуульд байхгүй байгаа нь орон нутгийн нөөцийн талаарх хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн гол шалтгаан болж байна гэж дүгнэж байна. Иймд хуульд орон нутгийн нөөцийн асуудлаар тавих шаардлагыг тодорхой болгох, нэр төрөл, тоо хэмжээ байршил зэрэгт үнэлгээ шинжилгээ хийж зохих эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, удирдлага менежментийг тодорхой болгох,
11. Улсын нөөцийн тухай хуульд уг хуулийн хэрэгжих нөхцөлийг хангасан процессын заалтуудыг нэмж хуульчлах, Үүнд: нөөцийн агуулах /хашаа/ барилга байгууламжийн стандартын үндсэн шаардлагыг тусгах, стандарт болон түүнийг мөрдүүлэх үйл ажиллагааны журмыг батлан гаргахыг эрх бүхий этгээдэд даалгах, нөөцийн агуулах /хашаа/ барилга байгууламж бүхий объектын харуул хамгаалалтын журмыг батлан гаргахыг эрх бүхий этгээдэд даалгах, нөөцийн бараа материалыг сэлгэх, шинэчлэх журмын үндсэн шаардлагыг болон бусад үйл ажиллагааны процедурыг тодорхой болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

Нэг: Монгол Улсын хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Газрын тосны тухай хууль,
3. Гамшгаас хамгаалах тухай хууль,
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
5. Татварын ерөнхий хууль,
6. Төрийн болон орон нутгийн өмчөөр ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
7. Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
8. Төсвийн тухай хууль,
9. Хүнсний тухай хууль,
10. Дайны байдлын тухай хууль,
11. Захиргааны ерөнхий хууль,
12. Зөрчлийн тухай хууль,
13. Зэвсэгт хүчний тухай,
14. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилсан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,
15. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль,
16. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
17. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
18. Олон улсын гэрээний тухай хууль,
19. Онц байдлын тухай хууль,
20. Төрийн болон албаны нууцын тухай хууль,
21. Байгууллагын нууцын тухай хууль,
22. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
23. Усны тухай хууль,
24. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
25. Хөдөлмөрийн тухай хууль,
26. Хууль тогтоомжийн тухай хууль,
27. Цэргийн албаны тухай хууль
28. Эрүүгийн хууль,

Хоёр: УИХ, ЗГ-ын тогтоол, Шадар сайдын тушаал /Бодлогын баримт бичиг, Хөтөлбөр, Аргачлал, Журам/

1. УИХ-ын 1994 оны МУ-ын ЗГ-ын дэд бүтцийн бүдүүвчийг батлах тухай “МУ-ын иргэний хамгаалалтын газар” 14 дүгээр тогтоол,
2. УИХ-ын 2002 оны Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай 58 дугаар тогтоол,
3. УИХ-ын 2003 оны тогтоолын хавсралтад “Засгийн газрын тохируулагч агентлаг гэсэн хэсэгт Гамшгаас хамгаалах ерөнхий газар” ... өөрчлөлт оруулах тухай тогтоол,
4. УИХ-ын 2008.05.09-ны өдрийн “Монгол Улсын стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай” 30 дугаар тогтоол
5. УИХ-ын 2011.10.06-ний өдрийн “Монгол Улсын стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай” 30 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” тогтоол

6. УИХ-ын 2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоол, 1-р хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, 2-р хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, 3-р хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”
7. УИХ-ын 2011.05.11-ний өдрийн хөтөлбөр батлах тухай 22 дугаар тогтоол, хавсралт “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр” /Хүчингүйд тооцсон 2021.11.21/
8. ЗГ-ын 1999.11.17-ны өдрийн журам батлах тухай тогтоол, хавсралт “Үрийн улсын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах журам”
9. ЗГ-ын 2006.12.27-ны өдрийн 316 дугаар тогтоол, хавсралт “Газрын тосны бүтээгдэхүүний ангилал, хэвийн хорогдлын норм”
10. ЗГ-ын 2008.05.28-ний өдрийн журам батлах тухай 199 дүгээр тогтоол, 1-р хавсралт “Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”
11. ЗГ-ын 2008.05.28-ний өдрийн журам батлах тухай 199 дүгээр тогтоол, 2-р хавсралт “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдлыг тооцох журам”
12. ЗГ-ын 2016.05.24-ний өдрийн а/80 тогтоол, хавсралт “Хүнсний буудайг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал”
13. ЗГ-ын 2018.11.28-ний өдрийн “Улсын нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” 364 дүгээр тогтоол /маш нууц/
14. ЗГ-ын 2020.10.07-ны өдрийн журам шинэчлэн батлах тухай 133 дугаар тогтоол, хавсралт “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”
15. Шадар сайдын 2017.07.05-ны өдрийн журам батлах тухай 66 дугаар тушаал, хавсралт “Улсын нөөцийн эд хөрөнгийн хариуцлагын журам”
16. Шадар сайдын 2012 оны жагсаалт батлах тухай 12 дугаар тушаал, хавсрал гэрээт хадгалагч байгууллагад хадгалах бараа, материалын нэр төрөл” /нууц/
17. Шадар сайдын 2018.12.27-ны өдрийн хөтөлбөр батлах тухай 136 дугаар тушаал, хавсралт “Онцгой байдлын байгууллагын төв, орон нутаг дахь улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, улсын нөөцийн салбар, цэгийн агуулахын барилга, байгууламж, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах дунд хугацааны хөтөлбөр /2019-2023 он/”

Хоёр: Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал /Журам/

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008.04.11-ний өдрийн Улсын нөөцийн бараа, материалын хөдөлгөөнд тавих дотоод хяналтыг зохион байгуулах тухай 224 дүгээр тушаал, 1-р хавсралт “Улсын нөөцийн бараа, материалыг сэлгэн шинэчлэх гэрээний жишиг загвар”, 2-р хавсралт “Улсын нөөцийн бараа материалыг сэлгэн шинэчлэх гэрээний жишиг загвар”, 3-р хавсралт “Улсын нөөцөөс бараа материал зээлээр олгох гэрээний жишиг загварыг”, 4-р хавсралт “Улсын нөөцийн бараа материалын хадгалалтын гэрээний жишиг загвар”, 5-р хавсралт “Улсын нөөцийн өвс, тэжээлийг тээвэрлэн байршуулах гэрээний жишиг загвар”, 6-р хавсралт “Улсын нөөцөөс бараа материал гаргах болон хүлээн авах зөвшөөрлийн хуудасны загвар”, 7-р хавсралт “Нөөцийн бус бараа материалыг гаргах болон хүлээн авах зөвшөөрлийн хуудасны загвар”, 8-р хавсралт “Гэрээ, зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулах албан тушаалтан”-ны загвар маягтууд
2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2010.06.09-ны өдрийн журам батлах тухай 217 дугаар тушаал, 1-р хавсралт “Улсын нөөцийн бараа материал хүлээн

- авах, хадгалах, зарцуулах, тооллого явуулах журам”, 2-р хавсралт “Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам”
3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2010.11.22-ны өдрийн журам батлах тухай 494 дүгээр тушаал, хавсралт “Улсын нөөцийн бараа, материалын удаан хадгалах журам”
 4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013.09.12-ны өдрийн а/681 дүгээр тушаал, хавсралт “Улсын нөөцийн бараа, материалыг ачих, буулгахад гар ажиллагаатай ажлын үнэлгээ”

Гурав: Ном, гарын авлага, сурах бичиг

1. Ж.Амарсанаа, “Монгол Улсын нөөцийн түүхэн замнал”, 2016 он, УБ хот

Дөрөв: Интернэт орчин дахь эх сурвалж

1. Улсын Их Хурлын цахим хуудас /УИХ/ <http://www.parliament.mn/>
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>
3. Албан ёсны цахим хуудас /ОБЕГ/, <https://nema.gov.mn/>
4. Албан ёсны цахим хуудас /ҮАГ/, <https://audit.mn/>
5. Албан ёсны цахим хуудас /ТЕГ/, <https://mta.mn/>
6. Эрх зүйн онцлог зохицуулалт /Гүрж/
<http://extwprlegs1.fao.org/docs/pdf/geo200042.pdf>
7. Эрх зүйн онцлог зохицуулалт /ОХУ/
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_5435/0a760859a4f81002ba4752eb11891a5988a5c7d0/
8. Эрх зүйн онцлог зохицуулалт /АНУ/
<https://www.phe.gov/about/sns/Pages/products.aspx>

Тав: Монгол Улсын стандарт /MNS/

д/д	Стандартын нэр	Стандартын дугаар
ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГЫН СТАНДАРТЫН АГУУЛГА		
1	Худалдааны агуулахын ерөнхий шаардлага	/MNS 5364:2011/
2	Худалдааны агуулахын ерөнхий шаардлага	/MNS 5364:2004/
3	Хүнсний нийлэг сав баглаа боодол	/MNS 5547:2005/
4	Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага	/MNS 6648:2016/
5	Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэрвч	/MNS 5624:2006/
6	Толгой хамгаалах хэрэгсэл. Дуулга	/MNS 5621:2006/
7	Хамгаалалтын бээлий	/MNS 5522:2011/
8	Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал	/MNS 5623:2006/
9	Буудайн гурил	/MNS 0244:2009/
10	Цагаан будаа	/MNS ISO 7301:2000/
11	Ургамлын гаралтай тос	/MNS 6646:2016/
12	Элсэн чихэр	/MNS CAC 212:2014/
13	Шахмал ногоон цай	/MNS 5864:2008/
14	Хүнсний зориулалттай иоджуулсан байгалийн давс	/MNS 5046:2001/
15	Хатаамал сүү	/MNS 2842:2011/
16	Нөөшилсөн махан бүтээгдэхүүн	/MNS 1563:2007/

17	Савласан ус	/MNS 5007:2007/
18	Лаа	/MNS 4743:99/
19	Шүдэнз	/MNS 0093:1986/
20	Малын мах	/MNS 129 83/
21	Үрийн буудай	/MNS 0246:2010/
22	Хүнсний буудай	/MNS 0097:2010/
23	Өвс	/MNS 0592:2008/
24	Буудайн хивэг	/MNS 0961:2008/
25	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, технологийн байгууламж	/MNS 5476:2007/
26	Шатахуун түгээх станц, техникийн ерөнхий шаардлага	/MNS 4628:2013/
27	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи үйл ажиллагааны аргачлал	/MNS 4633:2006/
28	Хөдөлгүүрийн түлш, этилжүүлээгүй бензин	/MNS 0217:2017/
29	Дизелийн түлш Евро техникийн шаардлага	/MNS 0216:2017/
НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТЫН АГУУЛГА		
1	Хүнсний микробиологи – Хүнсний бүтээгдэхүүн, Мөөгөнцрийг таньж, тодорхойлох арга	/MNS 5132:2002/
2	Үр тариа, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд нян, хөгц мөөгөнцөр тодорхойлох “Rida count”-ийн арга	/MNS 6052:2009/
3	Нян судлал – Халдваргүйтгэлийн бодисын нянд үйлчлэх идэвхийг тодорхойлох нян судлалын арга	/MNS 6236:2011/
4	Микробиологи – <i>Listeria monocytogenes</i> -ийг илрүүлэх, тоог тогтоох, 1-р хэсэг. Илрүүлэх арга	/MNS ISO 11290-1:1999/
5	Микробиологи – <i>E Coli</i> тоог тодорхойлох ерөнхий арга	/MNS ISO 7251:1995/
6	Колиформын тоог тогтоох – Колони тоолох арга	/MNS ISO 4834:99/
7	Микробиологи – <i>Salmonella</i> илрүүлэх ерөнхий заавар	/MNS ISO 6579:99/
8	Микробиологи – <i>Salmonella</i> илрүүлэх ерөнхий заавар	/MNS ISO 4891:99/
9	Хүнс, малын тэжээлийн микробиологи – Гэдэсний бүлгийн бактерийг илрүүлэх болон тоолох аргууд, 1-р хэсэг. Баяжуулах орчинд илрүүлэх ба тоолох /боломжит их тоог олох арга/	/MNS ISO 21528-1:2016/
10	Усны чанар – Амьдрах чадвартай бичил биетний тоог тогтоох, Тэжээлт орчин дотор буюу гадаргад нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох	/MNS ISO 6222:1998/
11	Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй Байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ	/MNS 6308:2012/
УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫН АГУУЛГА		

1	Хөдөө ах ахуй – Өвчний халдварыг тодорхойлох арга	/MNS 2783:2005/
2	Хөдөө аж ахуй – Буудай, арвайн үрийн гадаргуу дахь хатуу харуу өвчин үүсгэгчийн спорын тоог бичил харуураар тодорхойлох арга	/MNS 3991:2005/
3	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн	/MNS 2786:79/
4	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээс хог ургамал илрүүлэх арга	/MNS 2787:2015/
5	Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн Бактерийн өвчнийг илрүүлэх арга	/MNS 2787:2015/
6	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн хортон шавьжийг илрүүлэх арга	/MNS 2782:79/
7	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээс хөнөөлт шавьж илрүүлэх арга	/MNS 2782:2014/
8	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээс хөнөөлт хачиг илрүүлэх арга	/MNS 2782:2014/
9	Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээс агуулахын хөнөөлт шавьж, хачгийн хор хөнөөл тодорхойлох арга	/MNS 6481:2014/
10	Буудайн технологийн чанарыг шинжлэх арга	/MNS 3116:2001/
11	Тариа – Өнгө, үнэр, амт тодорхойлох арга	/MNS 0254.4:1987/
12	Тариа – Эзэлхүүн жин тодорхойлох арга	/MNS 0254.5:87/
13	1000 үрийн жинг тодорхойлох	/MNS 254.2:79/
14	Хүнсний буудай – Гэмтсэн үрийг тодорхойлох арга	/MNS 254-9:2019/
15	Буудай ба буудайн бүтээгдэхүүн – Чийглэгийн агуулгыг тодорхойлох /Үндсэн лавлагаа арга/	/MNS ISO 711:2000/
16	Тариа – Чийг тодорхойлох	/MNS 254.3:79/
ХИМИ, ХОР СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТЫН АГУУЛГА		
1	Хүнсний нийлэг сав баглаа, боодлын шинжилгээний арга	/MNS 5548:2005/
2	Гурил ба хивэг шинжлэх арга	/MNS 0245:1989/
3	Буудайн гурил. Хуурай цавуулгийн агууламжийг тодорхойлох	/MNS ISO 6645:2003/
4	Гоймонгийн шинжилгээний арга	/MNS 2233:1975/
5	Хүнсний давсны шинжилгээний арга	/MNS 2220:1986/
6	Иоджуулсан давсны иодын агууламжийг тодорхойлох эзлэхүүний арга	/MNS 5168:2002/
7	Элсэн чихрийн шинжилгээний арга	/MNS 1752:1973/
8	Ургамлын хүнсний тос. Шар буурцаг	/MNS CAC 20:98/
9	“Баялаг” цайны шинжилгээний аргууд	/MNS 4137:1992/
10	Хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1 В2, G1 G2-ийн	/MNS 5549:2005/

	Агууламжийг тодорхойлох нимгэн үеийн хроматографийн арга /Хэвшмэл арга/	
11	Сүүний консервууд шинжилгээний арга агууламжийг тодорхойлох нимгэн үеийн хроматограцийн арга /Хэвшмэл арга/	/MNS 3411:94/
12	Сүү сүүн бүтээгдэхүүнд афлотоксин М1 М2-ийн	/MNS 4477:2005/
13	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал – Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	/MNS 0900:2018/
14	Ундны ус. Хлоридын агуулгыг тодорхойлох арга	/MNS 4430:2005/
15	Ундны ус. Төмрийн агуулгыг тодорхойлох арга	/MNS 4430:2005/
16	Усны чанар. Кальци ба магнийн нийт агуулгыг тодорхойлох – Трилон Б-ээр титрлэх арга	/MNS ISO 6059:2005/
17	Усны чанар. Кальци ионыг тодорхойлох. Титрийн арга	/MNS ISO 2572:99/
18	Ундны ус. Нитритийн агуулгыг тодорхойлох арга	/MNS 4431:2005/
19	Усны чанар. Нитратыг тодорхойлох. 3-р хэсэг. Сульфосалицилийн хүчил ашигласан спектрометрийн арга	/MNS ISO 7890-3:2001/
20	Тарих үрийн чанарыг тодорхойлох арга	/MNS 0487:2001/

Зургаа: Эрх бүхий байгууллага, албан тушаалтны улсын нөөцийн зарцуулалттай холбоотой шийдвэр

д/д	Огноо	Шийдвэрийн төрөл	№	Шийдвэрийн утга
1	2007	ЗГ тогтоол	104	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргах тухай
2	2007.07.04	ЗГ тогтоол	167	Улсын нөөцөөс автомашин гаргах тухай
3	2007.10.10	ЗГ тогтоол	261	Мал өвөлжилтийн бэлтгэл хангах нэмэлт арга хэмжээний тухай
4	2007.10.10	ЗГ хуралдааны тэмдэглэл	48	Мал өвөлжилтийн бэлтгэл хангах нэмэлт арга хэмжээний тухай
5	2007.10.17	ЗГ хуралдааны тэмдэглэл	49	Улсын нөөцөөс гэр гаргах тухай
6	2007.12.12	ЗГ тогтоол	317	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
7	2008.01.30	ЗГ тогтоол	34	Хөрөнгө гаргах тухай
8	2008.03.12	ЗГ тогтоол	90	Хөрөнгө гаргах тухай
9	2008.03.12	ЗГ тогтоол	91	Хөрөнгө гаргах тухай
10	2008.05.29	ЗГ тогтоол	200	Хөрөнгө гаргах тухай
11	2008.06.02	ЗГ тогтоол	225	Хөрөнгө гаргах тухай
12	2008.09.05	ЗГ тогтоол	333	Улсын нөөцөөс автомашин олгож нөхөн бүрдүүлэх тухай
13	2008	ЗГ тогтоол	143	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
14	2009.01.14	ЗГ тогтоол	15	Улсын нөөцөөс өвс тэжээл гаргах тухай
15	2009.01.21	ЗГ тогтоол	17	Улсын нөөцөөс өвс, тэжээл хөнгөлөлттэй үнээр худалдах тухай
16	2009.02.11	ЗГ тогтоол	41	Улсын нөөцөөс өвс, тэжээл хөнгөлөлттэй үнээр худалдаж нөхөн бүрдүүлэх тухай

17	2009.03.25	ЗГ тогтоол	83	Улсын нөөцөөс өвс, тэжээл хөнгөлөлттэй үнээр худалдаж нөхөн бүрдүүлэх тухай
18	2009.04.08	ЗГ тогтоол	101	Хөрөнгө гаргах тухай
19	2009.04.24	ЗГ тогтоол	127	Хөрөнгө гаргах тухай
20	2009.07.22	ЗГ тогтоол	219	Хөрөнгө гаргах тухай
21	2009.11.04	ЗГ тогтоол	334	Улсын нөөцөөс автомашин олгож нөхөн бүрдүүлэх тухай
22	2009.12.11	ЗГ тогтоол	367	Зарим аймагт өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
23	2009	ЗГ тогтоол	124	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
24	2010.01.11	ЗГ тогтоол	7	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
25	2010.02.03	ЗГ тогтоол	27	Улсын нөөцөөс автомашин олгож нөхөн бүрдүүлэх тухай
26	2010.05.12	ЗГ тогтоол	112	Хөрөнгө гаргах тухай
27	2010.07.07	ЗГ тогтоол	169	Хөрөнгө гаргах тухай
28	2010.07.26	ЗГ тогтоол	198	Хөрөнгө гаргах тухай
29	2010.09.08	ЗГ тогтоол	229	Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зарим арга хэмжээний тухай
30	2010.10.01	ЗГ тогтоол	257	Мал амьтны гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
31	2010.10.06	ЗГ тогтоол	259	Хөрөнгө гаргах тухай
32	2010	ЗГ тогтоол	101	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
33	2010	ЗГ тогтоол	215	Улсын нөөцөд малын тэжээл бүрдүүлэх тухай
34	2011.01.25	ЗГ тогтоол	21	Зарим аймагт өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
35	2011.03.12	ЗГ тогтоол	78	Япон улсын Засгийн газарт буцалтгүй тусламж үзүүлэх тухай
36	2011.04.06	ЗГ тогтоол	99	Хөрөнгө гаргах тухай
37	2011.04.27	ЗГ тогтоол	135	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
38	2011.06.08	ЗГ тогтоол	177	Хөрөнгө гаргах тухай
39	2012.01.04	ЗГ тогтоол	3	Хөрөнгө гаргах тухай
40	2012.01.18	ЗГ тогтоол	16	Улсын нөөцөөс өвс, тэжээл худалдаж нөхөн бүрдүүлэх тухай
41	2012.05.23	ЗГ тогтоол	174	Хөрөнгө гаргах тухай
42	2012.05.30	ЗГ тогтоол	189	Хөрөнгө гаргах тухай
43	2012.07.04	ЗГ тогтоол	219	Хөрөнгө гаргах тухай
44	2012.09.22	ЗГ тогтоол	42	Хөрөнгө гаргах тухай
45	2012.12.22	ЗГ тогтоол	185	Хөрөнгө гаргах тухай
46	2012	ЗГ тогтоол	149	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай

47	2013.01.12	ЗГ тогтоол	14	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
48	2013.04.27	ЗГ тогтоол	151	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
49	2013.05.30	ЗГ тогтоол	195	Хөрөнгө гаргах тухай
50	2013.06.16	ЗГ тогтоол	211	Улсын нөөцөөс автомашин гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
51	2013.07.06	ЗГ тогтоол	252	Хөрөнгө гаргах тухай
52	2013.07.09	ЗГ тогтоол	257	Хөрөнгө гаргах тухай
53	2013.11.02	ЗГ тогтоол	361	Хөрөнгө гаргах тухай
54	2014.02.28	ЗГ тогтоол	66	Хөрөнгө гаргах тухай
55	2014.04.12	ЗГ тогтоол	119	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
56	2014.07.09	ЗГ тогтоол	226	Хөрөнгө гаргах тухай
57	2015.02.02	ЗГ тогтоол	32	Хөрөнгө гаргах тухай
58	2015.04.20	ЗГ тогтоол	155	Зарим аймагт хээрийн түймэр, малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
59	2015.04.20	ЗГ тогтоол	154	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
60	2015.04.27	ЗГ тогтоол	168	Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай
61	2015.06.22	ЗГ тогтоол	253	Хөрөнгө гаргах тухай
62	2015.12.14	ЗГ тогтоол	480	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
63	2015.12.14	ЗГ тогтоол	481	Хөрөнгө гаргах тухай
64	2016.01.18	ЗГ тогтоол	55	Хөрөнгө гаргах тухай
65	2016.02.01	ЗГ тогтоол	67	Хөрөнгө гаргах тухай
66	2016.05.02	ЗГ тогтоол	241	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
67	2016.07.27	ЗГ тогтоол	2	Хөрөнгө гаргах тухай
68	2016.08.17	ЗГ тогтоол	34	Хөрөнгө гаргах тухай
69	2016.10.26	ЗГ тогтоол	123	Хөрөнгө гаргах тухай
70	2016.11.23	ЗГ тогтоол	160	Хөрөнгө гаргах тухай
71	2016.11.29	ЗГ тогтоол	163	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
72	2017.01.11	ЗГ тогтоол	8	Өвөлжилтийн байдалтай холбогдуулан авах арга зарим арга хэмжээний тухай
73	2017.02.15	ЗГ тогтоол	55	Хөрөнгө гаргах тухай
74	2017.02.15	ЗГ тогтоол	56	Хөрөнгө гаргах тухай
75	2017.04.26	ЗГ тогтоол	130	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
76	2017.08.23	ЗГ тогтоол	238	Хөрөнгө гаргах тухай
77	2017.12.06	ЗГ тогтоол	325	Хөрөнгө гаргах тухай
78	2018.01.19	ЗГ тогтоол	18	Улсын нөөцөөс өвс тэжээл гаргах тухай
79	2018.03.14	ЗГ тогтоол	68	Хөрөнгө гаргах тухай
80	2018.06.27	ЗГ тогтоол	197	Хөрөнгө гаргах тухай
81	2018.08.01	ЗГ тогтоол	230	Хөрөнгө гаргах тухай
82	2018.11.28	ЗГ тогтоол	358	Хөрөнгө гаргах тухай
83	2019.02.20	ЗГ тогтоол	72	Гамшгийн хохирлыг барагдуулах зарим арга хэмжээний тухай

84	2019.02.27	ЗГ тогтоол	82	Улсын нөөцөөс өвс тэжээл гаргах тухай
85	2019.05.01	ЗГ тогтоол	167	Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай
86	2019.07.24	ЗГ тогтоол	306	Хөрөнгө гаргах тухай
87	2019.11.28	ЗГ тогтоол	419	Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай
88	2020.03.11	ЗГ тогтоол	85	Гамшгийн хохирлыг барагдуулах зарим арга хэмжээний тухай
89	2020.10.14	ЗГ тогтоол	139	Хөрөнгө гаргах тухай
90	2020.10.28	ЗГ тогтоол	162	Улсын нөөцөөс хөрөнгө гаргах тухай
91	2020.11.11	ЗГ тогтоол	172	Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай
92	2020.12.16	ЗГ тогтоол	212	Улсын нөөцөөс өвс, тэжээл олгох, тэжээл нөхөн бүрдүүлэх тухай
93	2020.12.30	ЗГ тогтоол	240	Хөрөнгө гаргах тухай
94	2021.02.10	ЗГ тогтоол	28	Улсын нөөцөөс хөрөнгө гаргах тухай
95	2021.02.17	ЗГ тогтоол	40	Хөрөнгө гаргах тухай
96	2021.03.25	ЗГ тогтоол	76	Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай
97	2021.04.08	ЗГ тогтоол	92	Хөрөнгө гаргах тухай
98	2021.05.19	ЗГ тогтоол	153	Хөрөнгө гаргах тухай
99	2021.07.26	ЗГ тогтоол	222	Хөрөнгө гаргах тухай
100	2021.09.29	ЗГ тогтоол	297	Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай
101	2021.09.22	ЗГ хуралдааны тэмдэглэл	57	Хөрөнгө гаргах тухай
102	2022.11.16	ЗГ тогтоол	407	Хөрөнгө гаргах тухай
103	2022.12.14	ЗГ тогтоол	461	Хөрөнгө гаргах тухай
104	2023.04.12	ЗГ тогтоол	133	Хөрөнгө гаргах тухай
105	2023.04.12	ЗГ тогтоол	208	Хөрөнгө гаргах тухай
106	2023.02.07	ЗГ тогтоол	209	Хөрөнгө гаргах тухай
107	2023.08.16	ЗГ тогтоол	293	Хөрөнгө гаргах тухай
108	2023.12.06	ЗГ тогтоол	436	Хөрөнгө гаргах тухай
109	2023.12.13	ЗГ тогтоол	449	Хөрөнгө гаргах тухай
110	2023.12.27	ЗГ тогтоол	479	Хөрөнгө гаргах тухай
111	2024.02.16	ЗГ тогтоол	63	Хөрөнгө гаргах тухай
112	2024.02.28	ЗГ тогтоол	68	Хөрөнгө гаргах тухай
113	2024.05.29	ЗГ тогтоол	-	Хөрөнгө гаргах тухай

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ДАГУУ 2007-2022 ОНД УЛСЫН НӨӨЦӨӨС
ЗАРЦУУЛСАН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ**

Д д	Засгийн газрын захирамж, тогтоол		Хэрэглэгч, хүлээн авагчийн нэр	Барааны нэр төрөл	Хн	Олгосон тоо хэмжээ
	Огноо, дугаар	Ерөнхий сайд				
2007 он						
МУ-ын ЗГ-ын тогтоол шийдвэр гараагүй.						
2008 он						
	2008.04.25 №155	С.Баяр	Байгалийн гамшгийн хохирлыг арилгах	Дизель түлш	тн	97.00
	2008.04.30 №160	С.Баяр	Байгалийн гамшгийн хохирлыг арилгах	А-80 автобензин	тн	2.00
Дүн						99.00
2009 он						
	2009.04.29 №133	С.Баяр	Хаврын тариалалтанд	Дизель түлш	тн	2,944.87
Дүн						2,944.87
2010 он						
	2010.02.03 №29	С.Баяр	Агаарын тээврийн хэвийн үйл ажиллагаа тасалдсан	Онгоцны түлш ТС-1	тн	700.00
Дүн						700.00
2011 он						
	2011.05.25 №165	С.Баяр	Шатахууны хомсдолт байдал бий болсон	Дизель түлш	тн	2,050.00
Дүн						2,050.00
2012 он						
	2012.10.13 №92, 111	Н.Алтанхуяг	Хангамжийг нэмэгдүүлэх	Автобензин Аи-92	тн	2,500.00
	2012.10.27 №111	Н.Алтанхуяг	Хангамжийг нэмэгдүүлэх	Дизель түлш	тн	5,700.00
Дүн						8,200.00
2013 он						
	2013.02.07 №49	Н.Алтанхуяг	Гамшгийн үед нислэг үйлдэх	Онгоцны түлш ТС-1	тн	18.75
	2013.07.06 №255	Н.Алтанхуяг	Газрын тосны газарт шилжүүлэх	Автобензин Аи-92	тн	400.27
	2013.07.06 №255	Н.Алтанхуяг	Газрын тосны газарт шилжүүлэх	Дизель түлш	тн	436.00
Дүн						855.02
2017 он						
	2017.12.09 №325	У.Хүрэлсүх	Гамшгийн үед нислэг үйлдэх	Онгоцны түлш ТС-1	тн	31.14
Дүн						31.14
2018 он						
	2018.05.09 СЯ-ны шийдвэр	Хүрэлбаатар	Гамшгийн үед нислэг үйлдэх	Онгоцны түлш ТС-1	тн	5.02
Дүн						5.02
2019 он						
	2019.07.24 №306	У.Хүрэлсүх	Гамшгийн үед нислэг үйлдэх	Онгоцны түлш ТС-1	тн	4.16
Дүн						4.16
2020 он						
	2020.12 ЗГ-ын тэмдэглэл	У.Хүрэлсүх	Сайжруулсан түлш тээвэр	Дизель түлш	тн	103.06
Дүн						103.06
2021 он						
	2021.03 №76	Л.Оюун Эрдэнэ	Ковид-19	Шатахуун	тн	25.55
Дүн						25.55
2021 он						
	2021.03 №222	Л.Оюун Эрдэнэ	Ковид-19	Шатахуун	тн	50.21
Дүн						50.21
2021 он						
	2021.09 №22	Л.Оюун Эрдэнэ	Шатахууны хомсдол	Шатахуун	тн	1,510.00
Дүн						1,510.00
НИЙТ ДҮН						16,578.03

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ,
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН ТАЛААРХ САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Улаанбаатар хот

Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, сэлгэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал, практикт учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор энэхүү санал асуулгыг явууллаа.

Санал асуулгад Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын 4, Баян-өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудын Улсын нөөцийн салбаруудын 29, Улаанбаатар хот дахь 112, 179, 185 дугаар ангийн 9 нийт 42 алба хаагч хамрагдав.

Алба хаагчдаас улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар болон амьдрал практик дээр тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар нээлттэй 13 асуултаар судалгааг авч санал асуулгын дүнг нэгтгэхэд дараах үр дүн гарч байна.

Хүснэгт № 1. Хамралт

		Frequency	Percent
Valid	Улсын нөөцийн газар	3	7,1
	112 дугаар анги	1	2,4
	185 дугаар анги	1	2,4
	179 дүгээр анги	7	16,7
	Баян-Өлгий аймаг	1	2,4
	Булган аймаг	1	2,4
	Говьсүмбэр аймаг	3	7,1
	Дархан-Уул аймаг	16	38,1
	Дорнод аймаг	1	2,4
	Дундговь аймаг	1	2,4
	Завхан аймаг	1	2,4
	Төв аймаг	1	2,4
	Увс аймаг	2	4,8
	Ховд аймаг	1	2,4
	Хөвсгөл аймаг	1	2,4
Total		42	100,0

НЭГ: АНКЕТЫН ХЭСЭГ.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 21,4 хувь нь 25-29 насны, 31 хувь нь 40-49 хүртэлх насныхан илүү хамралттай байна.

Насны ангиллаар авч үзвэл:

25-29 нас	9 албан хаагч (21,4%)
30-34 нас	4 албан хаагч (9,5%)
35-39 нас	4 албан хаагч (9,5%)
40-44 нас	6 албан хаагч (14,3%)
45-49 нас	7 албан хаагч (16,7%)
50-54 нас	5 албан хаагч (11,9%)
55 наснаас дээш	7 албан хаагч (16,7%)


Боловсрол нь:

Дээд - 23 албан хаагч (25%)
Тусгай дунд - 3 албан хаагч (7,1%)
Бүрэн дунд – 7 албан хаагч (16,7%)
Бүрэн бус дунд – 3 албан хаагч (7,1%)
/хариулахаас татгалзсан 6 албан хаагч/

Диаграм№1 Хүйс




Диаграм№2 Боловсрол



Судалгаанд хамрагдсан 42 албан хаагч хүйсийн харьцааг илэрхийлэх асуултад хариулсан ба үүнээс 26 албан хаагч буюу 61,9 хувь нь эрэгтэй, 14 албан хаагч буюу 33,3 хувь нь эмэгтэй албан хаагч, хариултаас татгалзсан 4,8 хувьтай.

Диаграм №3 Хүйс



Судалгааны явц байдал: Судалгаанд зарим тооны албан хаагчид анкетын хэсэг болон сорилын зарим асуумжуудад дутуу хариулснаас албан хаагчдын тоо судалгаа бүр дээр харилцан адилгүй байна.

Хүснэгт № 2. Ажлын байрны чиг үүрэг

Чиг үүргээр нь		Frequency
Valid	Газрын нөөц хариуцсан мэргэжилтэн	3
	Өвс, тэжээл хариуцсан мэргэжилтэн	1

Агуулахын аж ахуйн бэлэн байдлыг хангах, нөөцийн бараа материалтай холбоотой үүссэн өр авлага барагдуулах ажил хариуцсан	1
Үр тарианы нөөц хариуцсан мэргэжилтэн	4
Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах үйл ажиллагааг саадгүй явуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах	4
Бараа материалын чанар, эрүүл ахуйд хяналт тавих чиг үүрэг	1
Харуул хамгаалалт	7
Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх чиг үүрэг	4
Аж ахуйн бараа материалыг чанар стандартын дагуу хадгалах	2
Нөөцийн бараа материалын чанар, аюулгүй байдалд хяналт тавих чиг үүрэг	1
Нөөцийн барааны тайлан мэдээ нэгтгэх, санхүүгийн тайлан боловсруулах	1
Нөөцийн бараа материалыг хадгалах, хамгаалах, санхүүгийн анхан шатны баримтыг хөтлөх	1
Улсын нөөцийн бараа, материалыг тоо хэмжээнд нь бүрдүүлэх, технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах, сэлгэх шинэчлэх тээвэрлэн хүргэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах, Салбарын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	2
Нөөцийн барааны нярав, нөөцийн бараа материалыг нөхөн бүрдүүлэх, зарцуулах тайлан тооцоог үнэн бодитой гаргах	1
Шатахууны нярав, шатах, тослох материал хариуцсан ажилтан	
Бичиг хэрэг – оператор, аж ахуйн нярав	1
Хүнсний улаан буудайн элеватор	1
Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэхэд хяналт тавих	1
МУ-ын Засгийн газар, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх	1
Хадгалагдаж байгаа улсын нөөцийн бараа, материалыг зохистой хадгалагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, шинжилгээ хийх	1
Улсын нөөцийн харуул хамгаалалтыг удирдан зохион байгуулах	1
Өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хангах, баримт бичиг боловсруулах.	1
Total	42

ХОЁР: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ


Асуулт-2.1 Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийн бусад актуудад хэр нийцсэн гэж үзэж байна вэ? гэсэн асуултад нийт 40 албан хаагч хариулт өгсөн ба дараах сонголтыг хийсэн байна. Үүнд,

- Хууль тогтоомжид нийцсэн гэж 15 албан хаагч буюу 35,7 хувь,
- Хууль тогтоомжид нийцээгүй гэж 1 албан хаагч буюу 2,4 хувь,

- Зарим зүйл заалтыг өөрчлөн шинэчлэх шаардлагатай гэж 24 албан хаагч буюу 57,1 хувь нь хариулсан бол 2 албан хаагч буюу 4,8 хувь нь хариулахаас татгалзсан байна.

Үүнээс албан хаагчид нийтлэг байдлаар зарим зүйл заалтыг өөрчлөн шинэчлэх шаардлагатай гэж 57,1 хувь буюу 5 хүн тутмын 3 нь тодорхойлсон байна.


Диаграм № 2.1



Асуулт-2.2 Нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах улсын нөөцийг хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу нөөцлөн хадгалж чадаж байгаа юу? гэсэн тодруулах 3 хувилбар бүхий асуултад 42 албан хаагч дараах сонголтыг хийснээс 30 албан хаагч буюу 71,4 хувь нь Тийм гэж, 6 албан хаагч буюу 14,3 хувь нь Үгүй гэж, 5 албан хаагч буюу 11,9 хувь нь Мэдэхгүй гэж, 1 албан хаагч буюу 2,4 хувь нь Зарим талаар чаддаг гэсэн хувилбараас сонгосон байна.

Эдгээрээс судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдын 71,4 хувь нь хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу нөөцлөн хадгалж чаддаг гэж үзсэн байна.

Диаграм №2.2 Нөөцийн бараа, материалыг зориулалт, нөхцөлийн дагуу нөөцлөн хадгалж чаддаг эсэх



Асуулт-2.3 Нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр, төрөл, тоо хэмжээг нь хууль тогтоомжид заасны дагуу бууруулахгүйгээр нөөцийн бараа, материалыг хадгалж чадаж байна уу? гэсэн асуултад нийт 41 албан хаагч хариулт өгсөн ба Тийм гэж 28

албан хаагч буюу 66,7 хувь нь, Үгүй гэж 7 албан хаагч буюу 16,7 хувь нь, Энэ талаар мэдэхгүй байна гэж 6 албан хаагч буюу 14,3 хувь нь тус тус хариулсан бол 1 албан хаагч буюу 2,4 хувь нь хариулт өгөөгүй байна.

Үүнээс албан хаагчдын 66,7 хувь нь хууль тогтоомжид заасны дагуу нөөцийн бараа, материалын нэр, төрөл, тоо хэмжээг нь бууруулахгүйгээр хадгалж чаддаг гэж саналаа илэрхийлжээ.

Диаграм№2.3.



Асуулт-4 Худалдан авсан буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулах үйл явц хууль тогтоомжид заасны дагуу хэвийн явагдаж байгаад өгөх үнэлгээ? гэсэн асуултад нийт 42 алба хаагч хариулт өгсөн ба Тийм гэж 29 албан хаагч буюу 69 хувь нь, Үгүй гэж 11 албан хаагч буюу 26,2 хувь нь, Энэ талаар мэдэхгүй байна гэж 2 алба хаагч буюу 4,8 хувь нь тус тус хариултыг өгсөн байна.

Үүнээс алба хаагчдын 69 хувь нь хууль тогтоомжид заасны дагуу худалдан авсан буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулах ажил хэвийн явагдаж байна гэж саналаа илэрхийлжээ.

Диаграм№2.4.



Асуулт-5 Нөөцийн бараа, материал хадгалалтын онцлог нөхцөлөөс шалтгаалан технологийн дагуу хадгалах, сэлгэн шинэчлэх үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулж чадаж байгаа юу? гэсэн асуултад нийт 42 алба хаагч хариулт өгсөн ба Тийм гэж 28 албан хаагч буюу 66,7 хувь нь, Үгүй гэж 6 алба хаагч буюу 14,3 хувь нь, Энэ талаар мэдэхгүй байна гэж 8 алба хаагч буюу 33,6 хувь нь тус тус хариулсан.

Үүнээс албан хаагчдын 66,7 хувь нь гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулж байна гэж саналаа илэрхийлжээ.


Диаграм№5.



Асуулт-6 Монгол улсын Нөөцийн тухай хуулийн талаар ойлголт мэдлэгтэй юу? гэсэн асуултад нийт 40 албан хаагч хариулт өгсөн ба Маш сайн гэж 8 алба хаагч буюу 19,1 хувь нь, Сайн гэж 19 албан хаагч буюу 45,2 хувь нь, Дунд зэрэг гэж 12 албан хаагч буюу 28,6 хувь нь, Энэ талаар мэдлэггүй гэж 1 албан хаагч буюу 2,4 хувь нь тус тус хариулсан бол 2 албан хаагч ажилтан хариулт өгөхөөс татгалзсан байна.

Үүнээс албан хаагчдын 45,2 хувь буюу 5 хүн тутмын 2 нь Монгол улсын Нөөцийн тухай хуулийн талаар ойлголт мэдлэгийн хувьд Дунд түвшинд байна гэж саналаа илэрхийлжээ.

Диаграм№6.



Асуулт-7 Монгол улсын Нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахад ойлгомжгүй, тодорхой бус, салаа утгатай зүйл заалт байдаг уу? гэсэн асуултад нийт 38 албан хаагч хариулт өгснөөс тус бүр хувиар дараах сонголтыг хийсэн байна. Үүнээс,

- Ойлгомжгүй, тодорхой бус, салаа утгатай зүйл заалт байдаг гэж 9 албан хаагч буюу 21,4 хувь,

- Ойлгомжгүй, тодорхой бус, салаа утгатай зүйл заалт байдаггүй гэж 17 албан хаагч буюу 40,5 хувь,

- Энэ талаар мэдэхгүй байна гэж 12 албан хаагч буюу 28,6 хувь нь хариулсан.

/Хариулахаас татгалзсан 4 албан хаагч буюу 9,2 хувь нь/

Мөн хэрвээ ямар зүйл заалт нь ойлгомжгүй, салаа утгатай байна вэ гэсэн асуултад 13.1.10 дахь заалт ойлгомжгүй, Онцгой байдлын нэмэгдэл авдаггүй хэр нь, Онцгой байдлын дүрэмд захирагдаж ажилладаг, Хууль тогтоомжийг судалж байгаагүй тул сургалт оруулах, Онцгой байдлын газрын хууль тогтоомжоос ангид салангид байлгах гэх саналыг бичгээр өгсөн байна.

Диаграм№7.



Асуулт-8 Монгол улсын Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд хүндрэл бэрхшээл хаана нь үүсч байна вэ? гэсэн асуултад 82,1 хувь нь хариулсан байх ба энэхүү сөргөөр нөлөөлж буй шалтгаан-ыг тодруулах асуултад хариултын хувилбараас 2-3 хүртэлх сонголт хийжээ. Үүнд:

- ✓ Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх гэж 4 албан хаагч буюу 9,5 хувь,
- ✓ Нөөцийн бараа, материалыг тээвэрлэх гэж 3 албан хаагч буюу 7,1 хувь,
- ✓ Нөөцийн бараа, материалыг сэлгэх гэж 15 албан хаагч буюу 35,7 хувь,
- ✓ Нөөцийн бараа, материалыг хадгалах гэж 22 албан хаагч буюу 52,3 хувь,
- ✓ Нөөцийн бараа, материалыг зарцуулах гэж 3 албан хаагч буюу 7,1 хувь,
- ✓ Нөөцийн бараа, материалыг шинэчлэх гэж 12 албан хаагч буюу 28,5 хувь,
- ✓ Аль ч биш гэж 10 алба хаагч буюу 14,5 хувь /гэж тус бүрээр сонголт хийжээ.

Диаграм№8. Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд хүндрэл бэрхшээл хаана нь үүссэн эсэх




Асуулт-9 Монгол улсын Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад практикт учирч буй хүндрэл бэрхшээлийн байдаг үү? гэсэн нийт 33 албан хаагч хариулт өгсөн ба Хүндрэл бэрхшээлийн байдаг гэж 12 албан хаагч буюу 28,6 хувь нь, Хүндрэл бэрхшээлийн байдаггүй гэж 15 албан хаагч буюу 35,7 хувь нь, Энэ талаар мэдлэггүй гэж 6 албан хаагч буюу 14,3 хувь нь тус тус хариулсан бол 9 албан хаагч ажилтан буюу 21,4 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна.

Үүнээс алба хаагчдын 45,2 хувь буюу 5 хүн тутмын 2 нь Монгол улсын Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн хувьд зарим талаар хүндрэл бэрхшээл учирдаг гэж илэрхийлжээ.

Харин ямар хүндрэл бэрхшээл учирдаг вэ гэсэн асуултад дараах хариултыг өгсөн. Үүнд:

- Нөөцийн үр хангалтгүй,
- Үйлдвэр техникийн бараа материалын сэлгэлтийн зардал тусгагдаагүй, бараа материал хадгалах агуулахын чанарт анхаарах
- Техникийн шаардлага хангасан тоног төхөөрөмж байхгүй, барилга байгууламж хуучирч муудсан.
- Бараа материалыг сэлгэх явцад техник эвдэрч гэмтэх асуудал их байдаг
- Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах тухай заалт байдаггүй
- Өвс хадгалахад олон жил болсон өвс задарч хураахад хүндрэл гардаг
- Цалин бага учир хүний нөөцийн дутагдалтай
- Холбогдох дүрэм журам дутмаг
- Ажиллах нөхцөл хүнд, хортой хүйтэн нөхцөл, цалингийн шатлал бага зэрэг нь хүний нөөцийн сэтгэл ханамжийг бууруулдаг.
- Бид хүйтний нөхцөлд тоос шороонд ажилладаг мөртлөө хүйтний нэмэгдэл гэж авдаггүй. Олон жил ажиллаж байгаа хүмүүс уушиг, үе мөчний өвчтэй болоод тэтгэвэрт гардаг
- Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх. Засвар үйлчилгээний зардлыг төсөвт тусгадаггүй. Бараа материал хадгалах савны зардал, бэлэн байдал хангах хөрөнгө тусгагддаггүй. Энэ бүхнийг ажилтнуудынхаа хүчээр шийдвэрлэж байна.
- Орон тоо дутмаг, хуулийн заалт дутмаг, төсөвгүй болгосноос үйл ажиллагаа доголдож, авлага нэмэгдсэн.
- Нөөцийн бараа материал бүрдүүлэх тал дээр хуульд сайн тусгаж өгөх хэрэгтэй.
- Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий дүгнэлтээс гадна дотоод хяналтаар гаргасан актад үндэслэн анхнаасаа чанарын шаардлага хангасан бараа материал л хүлээн авбал үр дүнтэй гэх зэрэг санал сэтгэгдлээ нээлттэй илэрхийлсэн байна.

Диаграм№9.



Асуулт-10 Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий албан тушаалтны баталсан ямар дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа талаар нэг бүрчлэн бичнэ үү? гэсэн асуултад дараах байдлаар хариултыг өгсөн. Үүнд:

✓ ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан МУ-ын ЗГ-ын 199/184 тоот улсын нөөцийн бараа материалыг сэлгэх, шинэчлэх журам 2012 оны 494-р тогтоолын Хоргодол тооцох журам гэж – 3 алба хаагч

✓ Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль гэж - 6 алба хаагч

✓ Улсын нөөцийн тухай хууль гэж - 6 алба хаагч

✓ Нөөцийн бараа, материал хөтлөх журам гэж - 6 алба хаагч

✓ Засгийн газрын тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомж гэж - 5 алба хаагч

✓ Нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээ нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах, бараа материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээг санхүүжилтийн дүнг сар улирлаар гаргаж, тайлагнах гэж -

✓ Алба хаагчдын хөдөлмөр аюулгүй байдлыг хангуулах гэж - 2 алба хаагч

✓ Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу

✓ Монгол улсын Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий албан тушаалтны баталсан ямар дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг гэж – 4 албан хаагч

✓ Өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм журам дутмаг байдаг.


✓ ОБЕГ-ийн хагас цэрэгжилтийг шаардах болсон. Цалин бага учир хүмүүс ажлаас гарч эхэлсэн.

✓ Байгууллагын хурал дээр цалин хасах талаар ярьдаг. Энгийн алба хаагчдыг жагсаалтын бэлтгэл хийлгэж дарамталдаг гэх зэргээр санал сэтгэгдлээ илэрхийлсэн байна.

Асуулт-11 Улсын нөөцийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага бий юу? гэсэн асуултад нийт 39 албан хаагч хариулт өгсөн ба *Зөв, зүйтэй юм* гэж 25 алба хаагч буюу 59,5 хувь нь, *Сайн мэдэхгүй* гэж 14 албан хаагч буюу 33,3 хувь нь тус тус хариулсан бол 3 албан хаагч буюу *Буруу* буюу ямар нэгэн хариулт өгөхөөс татгалзсан байна.

Үүнээс албан хаагчдын 59,5 хувь буюу 5 хүн тутмын 3 нь *Монгол улсын Нөөцийн тухай хуулийн шинэчлэн боловсруулах шаардлагатай* гэсэн саналыг илэрхийлжээ.

Диаграм№11.



Асуулт-12 Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлнэ үү? гэсэн асуултад дараах байдлаар нээлттэй хариултыг өгсөн. Үүнд:

✓ ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан ЗГ-ын199/184 тоот улсын нөөцийн бараа материалыг сэлгэх, шинэчлэх журам 2012 оны 494-р тогтоолын Хоргодол тооцох журам гэж – 3 алба хаагч

✓ Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль гэж - 6 алба хаагч

✓ Улсын нөөцийн тухай хууль гэж - 6 алба хаагч

✓ Нөөцийн бараа, материал хөтлөх журам гэж - 6 алба хаагч

✓ Засгийн газрын тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомж гэж - 5 алба хаагч

✓ Нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээ нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах, бараа материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээг санхүүжилтийн дүнг сар улирлаар гаргаж, тайлагнах гэж -

✓ Алба хаагчдын хөдөлмөр аюулгүй байдлыг хангуулах гэж - 2 алба хаагч

✓ Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу

✓ Монгол улсын Нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий албан тушаалтны баталсан ямар дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг гэж – 4 албан хаагч

✓ Өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм журам дутмаг байдаг.

✓ ОБЕГ-ийн хагас цэрэгжилтийг шаардах болсон. Цалин бага учир хүмүүс ажлаас гарч эхэлсэн.

✓ Байгууллагын хурал дээр цалин хасах талаар ярьдаг. Энгийн алба хаагчдыг жагсаалтын бэлтгэл хийлгэж дарамталдаг.

✓ Тоос шороотой хүйтэн газар, хүнд нөхцөлд ажилладаг учир хүйтний нэмэгдэл авах ёстой гэж үзэж байна гэж – 3 алба хаагч

✓ Тоног төхөөрөмжийг шинэчлэх

✓ Ажилчдын унааны мөнгө бага байна.

✓ Цалин бага тул ажиллах хүний нөөц хомсдол бий болж 1 хүн гурван хүний ажил хийж байна.

✓ Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Гамшгаас хамгаалах тухай хууль харилцан уялдаатай байх. Алба хаагчдыг төрийн тусгай төрийн үйлчилгээний гэх зааг ялгааг гаргах.

✓ Улсын нөөцийн тухай хуулийг шинэчлэн боловсруулан гаргасан хуулиудтай уялдуулан шинэчлэх шаардлагатай.

✓ Төв орон нутаг дахь Улсын нөөцийн анги, салбаруудыг буцааж тустай төсөвтэй болгох

✓ Төв орон нутгийн ажилтан албан хаагчдын хүн хүч орон тоо дутмаг

✓ Техник тоног төхөөрөмжийн хангалт маш муу байгаа тул тодорхой судалгаанд дээр үндэслэн нэмэгдүүлэх

✓ Агуулах аж ахуйг их засваруудыг хийлгэх, шинээр агуулахуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх гэж – 3 алба хаагч

✓ Орчин үеийн эдийн засгийн болон геополитик, нөхцөл байдалтай холбогдуулан хадгалах бараа материалын нэршлийг нэмэгдүүлэх, шинэчлэх

✓ Алба хаагчдын ажиллах нөхцөл, хувцасны хангалтыг сайжруулах

✓ Санхүүжилтийн хувьд бие даасан ОБЕГ-ын төсөвтэй нэг биш тусдаа баймаар байна.

✓ Ерөнхий хууль нь боломжийн бөгөөд зарим нэг зөрчилдөөд байгаа нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахыг зөв байх.

✓ 16.1.1 заалтын Орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих гэх зэргээр санал сэтгэгдлийг илэрхийлсэн байна

САНАЛ АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮН

Санал асуулгын дүнгээс алба хаагчдын 66,7 хувь нь “хууль тогтоомжид заасны дагуу нөөцийн бараа, материалын нэр, төрөл, тоо хэмжээг нь бууруулахгүйгээр хадгалж чаддаг” гэж хариулсан бол 69 хувь нь “хууль тогтоомжид заасны дагуу худалдан авсан буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулах ажил хэвийн явагддаг” гэж үзжээ.

Судалгаанд хамрагдагсдын 52,3 хувь нь “Улсын нөөцийн бараа, материалыг **хадгалах** үйл ажиллагаанд илүүтэй доголдол гардаг” болохыг нь онцолсон байна.

Харин алба хаагчдын 45,2 хувь буюу 5 хүн тутмын 2 нь практикт зарим хүндрэл бэрхшээл учирдаг /сэлгэлтийн зардал тусгагдаагүй, бараа материал хадгалах агуулахын чанар тааруу, барилга байгууламж хуучирч муудсан, бараа материалыг сэлгэх явцад техник эвдэрч гэмтэх асуудал их, хүйтний нөхцөлд тоос шороонд ажилладаг боловч нэмэгдэл цалин авдаггүй, Олон жил ажиллаж байгаа хүмүүс уушги, үе мөчний өвчтэй болоод тэтгэвэрт гардаг, цалин хангамж муутай байдаг нь албан хаагч, ажилтны ажлын байрны сэтгэл ханамж бууруулж, хүний нөөцийн хомсдолыг үүсгэдэг/ гэжээ.

Монгол улсын Нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт, оруулах, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагатай гэж судалгаанд хамрагдагсдын 59,5 хувь буюу 5 хүн тутмын 3 нь саналаа илэрхийлжээ.

Алба хаагчдаас дэвшүүлсэн саналыг эрэмбэлбэл:

- Хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу улсын нөөцийг бүрдүүлэхдээ хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий дүгнэлтээс гадна дотоод хяналтаар гаргасан актыг үндэслэн чанарын шаардлага хангасан бараа материал хүлээн авахад анхаарах.

- Улсын нөөцийн бараа, материалыг тоо хэмжээнд нь бүрдүүлэх, технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах, сэлгэх шинэчлэх тээвэрлэн хүргэх үйл ажиллагааг чиг үүрэг бүхий албан хаагч, мэргэжилтнүүдийн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.

- Нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагатай зэргээр тодорхойлж байна.

—oOo—